



# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

ХУУЛЬ, ТОГТООЛ, ЗАРЛИГ,  
ШИЙДВЭР, ХУУЛИЙН ТАЙЛБАР

Монгол Улсын Их Хурлын Тамгын газар

№ 1996 оны 3-р сар № 3 / 46/

## ГАРЧИГ

### 1. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1.	Нийгмийн халамжийн тухай	250
2.	Нийгмийн халамжийн сангаас хүн амын эмзэг хэсэгт төрөөс үзүүлэх нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний тухай	256
3.	Нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжийн тухай	259
4.	Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай	265
5.	Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай	271
6.	Хуульд өөрчлөлт оруулах хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай	279
7.	Монгол Улсын төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	280
8.	Улсын тэмдэгтийн хураамжийн хуульд өөрчлөлт оруулах тухай	281
9.	Прокурорын байгууллагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	282

### 2. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

10.	Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үхэл баримтгалын тухай № 87	284
11.	Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан,	

	түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай № 89	287
12.	10000 төгрөгийн дэвсгэртийг хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцож, гүйлгээнд гаргахыг зөвшөөрөх тухай № 01	288
13.	Тогтоол хүчингүй болсонд тооцох тухай № 03	289
14.	Монгол банкны 1996 оны орлого, зарлагын төсвийг батлах тухай № 04	289

### 3. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

15.	Г.Эрдэнээг элчин сайдаар томилох тухай № 11	291
16.	Монголын тулгар төрийг үндэслэн байгуулсны 790 жилийн ойг тэмдэглэх тухай № 14	291

### 4. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

17.	Зарим ахмад настны тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, орон сууц, түлээ нүүрсний үнийг хөнгөлөх тухай №146	292
18.	Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийг сайжруулах зарим арга хэмжээний тухай № 150	293
19.	Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хуулиудыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай № 156	303
20.	Дүрэм, журам, үнэмлэх, тэмдгийн тодорхойлолт батлах тухай № 157	304
21.	1996 оныг боловсролын жил болгох, багш нарын их хурал хуралдуулах тухай № 158	315
22.	Заавар батлах тухай № 161	318
23.	Шуудангийн үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай № 164	322
24.	Төлөвлөгөө батлах тухай №165	324
25.	Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай № 167	331
26.	Тусгай хамгаалалттай зарим газар нутгийн хамгаалалтын горим, хилийн цэсийг батлах тухай № 169	343

### 5. МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

27.	Ялтныг ялаас хугацааны өмнө тэнцэн судлаж буюу хөнгөн ялаар солих талаархи Эрүүгийн хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг тайлбарлах тухай № 390	366
-----	--	-----

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар  
сарын 12-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь нийгмийн халамжийн төрөл, хамрах хүрээг тогтоож, нийгмийн халамжийн санг бүрдүүлэх, зарцуулах эрх зүйн үндэс, нийгмийн халамжийн асуудал болон үйл ажиллагааг эрхлэх байгууллага, албан тушаалтны чиг үүргийг тодорхойлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хууль

тогтоомж

1. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Нийгмийн халамж, түүний төрөл

1. Нийгмийн халамж нь хүн амын эмзэг хэсэгт хамрагдах ахмад настан, эх, хүүхэд, тахир дутуу хүн, нэн ядуу амьдралтай иргэнд тэтгэвэр, тэтгэмж олгох, хөнгөлөлт, үйлчилгээ үзүүлэх чиглэлээр гэдний амьжиргааг дээшлүүлэх, түүнчлэн хүүхэд төрүүлсэн эх, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эцэг /эх/ болон ихэр хүүхдэд тэтгэмж олгох агуулга бүхий нийгмийн хамгаалалтын арга хэмжээ мөн.

2. Дор дурдсан иргэнийг хүн амын эмзэг хэсэгт хамааруулна:

1/ бие даан амьдрах чадваргүй, асран хамгаалж, тэжээн тэтгэх гөрөл садангүй ганц бие ахмад настан, тахир дутуу хүн болон бүтэн өнчин хүүхэд;

2/ тухайн үеийн амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой ахмад настан, тахир дутуу хүн, олон хүүхэдтэй эрх толгойлсон эх /эцэг/;

3/ нэн ядуу амьдралтай иргэн;

4/ хуульд заасан нөхцөл, журмын дагуу нийгмийн халамжийн тэтгэвэрт хамаарагдах иргэн.

3. Өрхийн нэг хүнд ногдох орлогын хэмжээ нь Засгийн газраас тогтоосон амьжиргааны баталгаажих доод түвшингийн 40 хувиас доогуур бол тухайн өрх, иргэн нэн ядуу амьдралтайд тооцогдоно.

4. Амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээг Засгийн газар тогтоож байна.

5. Нийгмийн халамж дор дурдсан төрөлтэй байна:

- 1/ нийгмийн халамжийн тэтгэвэр;
- 2/ нийгмийн халамжийн тэтгэмж;
- 3/ нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээ;
- 4/ ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ;
- 5/ тахир дутуу хүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ.

4 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн хамрах хүрээ

Хууль тогтоомжид заасан нөхцөл, журмыг хангасан Монгол Улсын иргэн, Монгол Улсад байнга оршин суугах гадаадын иргэн, харьяалалгүй хүн нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд хамаарагдана.

5 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээнд хамаарагдахгүй байх тохиолдол

Нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэн /дайн, байлдаан, зэвсэгт тулгаралтад оролцсоноос бусад/ нийгмийн халамжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, мөн сангаас санхүүжигдэх нийгмийн халамжийн үйлчилгээнд үл хамаарна.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Нийгмийн халамжийн сан

6 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сан, түүний бүтэц, төрөл

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээнд зарцуулах хөрөнгийг нийгмийн халамжийн сангаас санхүүжүүлнэ.

2. Нийгмийн халамжийн сан нь мөнгөн хөрөнгийн сан байх бөгөөд төвлөрсөн болон орон нутгийн салбар сангаас бүрднэ.

3. Нийгмийн халамжийн сан дор дурдсан төрөлтэй байна:

- 1/ нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн сан;
- 2/ нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний сан.

4. Нийгмийн халамжийн сангийн дүрмийг Засгийн газар батална.

7 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангийн орлогын эх үүсвэр

1. Нийгмийн халамжийн сангийн орлого дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

1/ Нийгмийн халамжийн санд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс олгох хөрөнгө;

2/ сангийн хөрөнгийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

3/ олон улсын байгууллага, гадаад улс, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс нийгмийн халамжийн санд шууд зориулалттайгаар олгосон хандивын орлого, тусламж;

4/ бусад эх үүсвэр.

2. Нийгмийн халамжийн сангийн орлого бүх төрлийн татвар, хураамжаас чөлөөлөгдөнө.

8 дугаар зүйл. Нийгмийн халамжийн сангийн хөрөнгийн зарцуулалт

1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу дор дурдсан тэтгэвэр, тэтгэмж олгох, зардлыг санхүүжүүлэх зориулалтаар зарцуулна:

1/ нийгмийн халамжийн тэтгэвэр;

2/ жирэмсний болон амаржсаны, хүүхэд асарсны, олон хүүхэдтэйн, нярай хүүхдийн арчилгааны, ихэр хүүхдийн болон бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч, өсгөсний тэтгэмж;

3/ гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг 4 нас хүртэл төрөөс асрамжан өсгөж хүмүүжүүлэх зардал;

4/ хууль тогтоомжид заасан бусад зардал.

2. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний сангийн хөрөнгийг хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу дор дурдсан зардлыг санхүүжүүлэх зориулалтаар зарцуулна:

1/ ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний зардал;

2/ тахир дутуу хүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний зардал;

3/ нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний байгууллагын үйл ажиллагааны зардал;

4/ хууль тогтоомжид заасан бусад зардал.

3. Хуульд өөрөөр заагаагүй бол нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг зориулалтын бус чиглэлээр ашиглахыг хориглоно.

4. Нийгмийн халамжийн нэг төрлийн сангийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийг Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөлтэй зөвшилцөн хөрөнгө дутагдалтай өөр төрлийн санд 6 сараас дээшгүй хугацаагаар шилжүүлэн зарцуулж болно.

9 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагын төсвийг батлах

Нийгмийн халамжийн санд улсын төвлөрсөн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газраас оруулсан саналыг үндэслэн жил бүрийн Төсвийн тухай хуулиар тогтооно.

2. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал жил бүрийн төсөвт тусгайлан зааж батална.

10 дугаар зүйл. Сангийн тайлан тэнцэл гаргах, тайлагнах

1. Нийгмийн халамжийн сан тус бүрийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд дараахь төсөв захирагч, байгууллага гартан тайлагнаж байна:

1/ улирлын тайланг сум, дүүргийн төсвийн ерөнхийтэн захирагч тухайн улирлын дараа сарын 15-ны дотор аймаг, нийслэлийн төсвийн ерөнхийтэн захирагч тухайн улирлын дараа сарын 25-ны дотор нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад тус тус гаргаж ирүүлнэ;

2/ нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага халамжийн сангийн улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёр дахь сарын 10-ны дотор, жилийн эцсийн нэгдсэн тайланг дараа оны 2 дугаар сарын 25-ны дотор тус тус гаргаж, санал дүгнэлтийн хамт Нийгмийн халамжийн Үндэсний Зөвлөлд тайлагнана.

2. Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөл хагас жилийн болон жилийн эцсийн тайлан тэнцлийг хянан хэлэлцэж зохих дүгнэлт гаргана.

11 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн сангийн бүртгэл, тайлан

Нийгмийн халамжийн сангийн бүртгэл, тайлангийн маягтын загварыг Сангийн болон Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Нийгмийн халамжийн үйл ажиллагааны зохион байгуулалт

12 дугаар зүйл. Нийгмийн халамжийн асуудал эрхлэх байгууллага, албан тушаалтан, тэдгээрийн чиг үүрэг

1. Нийгмийн халамжийн асуудлыг улсын хэмжээнд нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн хэмжээнд тухайн шатны Засаг дарга эрхлэн хэрэгжүүлнэ.

2. Нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ нийгмийн халамжийн талаар төрөөс баримтлах бодлогын асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах;

2/ нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих;

3/ нийгмийн халамжийн сангийн хөрөнгийг төлөвлөх, уг санд улсын төвтөрсөн төсвөөс олгох хөрөнгийн тооцоог хянах, сангийн хөрөнгийн талаар Засгийн газарт санал оруулах;

4/ хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

3. Бүх шатны Засаг дарга нийгмийн халамжийн асуудалтай холбогдсон дор дурдсан чиг үүргийг тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ:

1/ нийгмийн халамжийн асуудлаар нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд авах арга хэмжээний талаар санал боловсруулж, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах;

2/ нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, тэдгээрийн хэрэгжилт, нийгмийн халамжийн сангийн хагас жилийн болон жилийн эцсийн тайлан тэнцлийн талаар иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид илтгэх;

3/ нийгмийн халамжийн санг бүрдүүлж, орлого, зарлагын гүйцэтгэлийг хангуулах;

4/ нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний байгууллагын ажиллах журмыг тогтоон мөрдүүлж, тэдгээрийн үйл ажиллагаа, үйлчилгээний төрөл, хэлбэрийг цаашид боловсронгуй болгох санал боловсруулж шийдвэрлэх;

5/ нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах иргэний талаар зохих тодорхойлолт, шийдвэр гаргах, шаардлагатай гэж үзвэл нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний асуудлыг иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээр хэлэлцүүлэн зохих шийдвэр гаргуулах;

6/ хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

13 дугаар зүйл. Нийгмийн халамжийн үйл ажиллагааг эрхлэх байгууллага, түүний чиг үүрэг

1. Нийгмийн халамжийн үйл ажиллагааг нутгийн захиргааны байгууллага эрхлэн зохион байгуулна.

2. Нийгмийн халамжийн сангаас нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж тогтоон олгох, нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг аймаг, нийслэл, сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/-аар гүйцэтгүүлнэ.

3. Нийгмийн халамжийн үйл ажиллагааг эрхлэх байгууллага дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ:

1/ нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах;

2/ нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагын гүйцэтгэлийг хангах;

3/ нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлтийг цаг тухайд нь олгох, асрамж, үйлчилгээг сайжруулах;

4/ хууль тогтоомжид заасан бусад чиг үүрэг.

14 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөл

1. Нийгмийн халамж, эрүүл мэнд, дэд бүтэц, сангийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон үйлдвэрчний эвлэл, эмэгтэйчүүд, хүүхэд, залуучууд, ахмад настан, тахир дутуу хүмүүсийн зэрэг Засгийн газрын бус байгууллагын төлөөлөгчид оролцсон Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөл /орон тооны бус/-ийг 9-өөс илүүгүй гишүүнтэйгээр нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд байгуулж ажилдуулна.

2. Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөлийг /цаашид "Үндэсний зөвлөл" гэх/ нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тэргүүлэх бөгөөд бүрэлдэхүүнийг Засгийн газар батална.

3. Үндсэн зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

1/ нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, нийгмийн халамжийн сангийн орлого, зарлагын байдалд хөндлөнгийн хяналт тавих;

2/ нийгмийн халамжийн үйл ажиллагааны талаар холбогдох байгууллагын тайлан, мэдээллийг хэлэлцэж, санал дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар зохих шатны байгууллагад санал оруулах;

3/ нийгмийн халамжийн асуудлаар зөвлөмж гаргах;

4/ иргэдээс нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, үйлчилгээтэй холбогдуулж гаргасан гомдлыг барагдуулах үйл ажиллагаанд хяналт тавих;

5/ хууль тогтоомжид заасан бусад бүрэн эрх.

4. Үндэсний зөвлөлийн дүрмийг Засгийн газар батална.

5. Үндэсний зөвлөлийн гишүүнд ажлын оролцоог харгалзан улирал тутам цалингийн нэмэгдэл олгож болно. Цалингийн нэмэгдлийн дээд хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

6. Нийгмийн халамжийн салбар зөвлөлийг аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын дэргэд байгуулж болно. Салбар зөвлөлийн дүрмийг Үндэсний зөвлөл батална.



## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

15 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомж зөрчсөн, хуурамч баримт бичиг бүрдүүлэх, худал мэдээлэх зэргээр нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж авсан, нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд хамрагдсан гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

16 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар сарын 14-ний өдөр

Улаанбаатар хот

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ХҮН АМЫН ЭМЗЭГ ХЭСЭГТ ТӨРӨӨС ҮЗҮҮЛЭХ НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН БОЛОН АСРАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь хүн амын эмзэг хэсэгт төрөөс үзүүлэх нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний төрөл, хамрах хүрээг тогтоож, үйлчилгээг зохион байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээ, түүний төрөл

1. Ахмад настан, тахир дутуу хүн, бүтэн өнчин хүүхэд болон гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг төрөөс байнга асарч сувилах үйлчилгээг нийгмийн асрамжийн үйлчилгээ гэнэ.

2. Иргэнийг түр хугацаагаар хооллох, эсвэл түүнд наад захын хувцас, хүнс болон ахуй, соёлын зарим зүйл олгох, мэргэжил нэмшгүүлэх, хөдөлмөр эрхлүүлэх зэрэг төрөөс үзүүлэх үйлчилгээг нийгмийн халамжийн үйлчилгээ гэнэ.

3. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээ дор дурдсан төрөлтэй байна:

- 1/ ахмад настныг байнга асрамжлах үйлчилгээ;
- 2/ тахир дутуу хүнийг байнга асрамжлах үйлчилгээ;
- 3/ өнчин хүүхдийг байнга асрамжлах үйлчилгээ;
- 4/ нэн ядуу амьдралтай иргэнд үзүүлэх халамжийн үйлчилгээ;
- 5/ гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг 4 нас хүртэл нь төрийн зардлаар асрамжлан өсгөж, хүмүүжүүлэх үйлчилгээ;
- 6/ амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой бөгөөд олон хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-д үзүүлэх халамжийн үйлчилгээ.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний хамрах хүрээ

1. Нийгмийн асрамжийн үйлчилгээнд дор дурдсан иргэн хамрагдана:

1/ бие даан амьдрах чадваргүй, асран хамгаалж, тэжээн тэтгэх төрөл садангүй ганц бие, эсвэл асран хамгаалагч, тэжээн тэтгэгч нь дэмжлэг туслалцаа үзүүлэх бололцоогүй нь тогтоогдсон ахмад насан, тахир дутуу хүн;

2/ хууль ёсны асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүй бүтэн өнчин хүүхэд;

3/ төрийн зардлаар асрамжлан өсгөхийг эцэг, эх нь зөвшөөрсөн гурав ба түүнээс дээш ихэр хүүхэд.

2. Нэн ядуу амьдралтай иргэн, амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой бөгөөд олон хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/ нийгмийн халамжийн үйлчилгээнд хамрагдана.

4 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах

Иргэнийг асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг аймаг, дүүргийн Засаг дарга, халамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэрийг сум, хорооны Засаг дарга тус тус гаргана.

5 дугаар зүйл. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний зардлын хэмжээ

1. Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дор дурдсан зардлын норматив, эд юмсын эдэлгээний хугацаа, журмыг тогтоон мөрдүүлнэ:

1/ нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа иргэний хоол хүнс, хувцас, эм, ариун цэвэр, хичээлийн хэрэгслэлийн нэ хүнд ногдох зардлын норматив, хувцас, хичээлийн хэрэгслэлийн эдэлгээний хугацаа;

2/ нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаад нас барсан иргэнийг оршуулах зардлын норматив;

3/ нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээ үзүүлэх журам, нэг хүнд өдөрт оногдох хоолны болон бусад үйлчилгээний зардлын норматив.

2. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг төрийн зардлаар өсгөж, хүмүүжүүлэх журам, зардлын нормативыг эрүүл мэндийн болон нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно.

6 дугаар зүйл. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний зохион байгуулалт

1. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний бодлого, арга зүйн асуудлыг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, үйлчилгээг зохион байгуулахтай холбогдсон асуудлыг нутгийн захиргааны байгууллага тус тус эрхэлнэ.

2. Нийгмийн асрамжийн үйлчилгээг аймаг, нийслэлийн асрамжийн газар, нийгмийн халамжийн үйлчилгээг сум, дүүргийн халамжийн төв тус тус үзүүлнэ.

3. Сум, дүүргийн нутаг дэвсгэрт биеэ даасан асрамжийн газартай бол түүнд тухайн сум, дүүргийн халамжийн үйлчилгээг нэгтгэн нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний төв байгуулан ажилтуулж болно.

4. Нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний байгууллагын үлгэрчилсэн дүрмийг нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

5. Иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, Засгийн газрын бус байгууллага өөрийн зардлаар ахмад настан, бүтэн өнчин хүүхэд, ахир дутуу хүнийг халамжлан асрахыг төр дэмжинэ.

6. Иргэн, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, Засгийн газрын бус байгууллагад энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан чиглэлээр ажиллах өвшөөрөл олгох буюу асруулагч, үйлдүүлэгчийн эрх ашгийг хохיוосон бол түүний үйл ажиллагааг зогсоох тухай шийдвэрийг сум, дүүргийн Засаг дарга гаргана.

7 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж төрдөнө.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар  
сарын 14-ний өдөр

Улаанбаатар  
хот

### НИЙГМИЙН ХАЛАМЖИЙН САНГААС ОЛГОХ ТЭТГЭВЭР, ТЭТГЭМЖИЙН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр, тэтгэмж тогтоож олгохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэвэр,  
тэтгэмжийн төрөл

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж дараахь төрөлтэй байна:

- 1/ нийгмийн халамжийн тэтгэвэр,
- 2/ жирэмсний болон амаржсаны тэтгэмж;
- 3/ хүүхэд асарсны тэтгэмж;
- 4/ олон хүүхэдтэйн тэтгэмж;
- 5/ нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж;
- 6/ ихэр хүүхдийн тэтгэмж;
- 7/ бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч, өсгөсний тэтгэмж.

3 дугаар зүйл. Нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрх

Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасны дагуу тэтгэвэр авах эрх үүсээгүй дор дурдсан иргэн нийгмийн халамжийн тэтгэвэр авах эрхтэй:

1/ амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой 60 ба түүнээс дээш настай эрэгтэй, 55 ба түүнээс дээш настай эмэгтэй;

2/ хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу хүн;

3/ төрөдхийн тахир дутуу болон 16 насанд хүрээгүй байхдаа тахир дутуу болсон хүн;

4/ тэжээгч нь нас барсан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд;

5/ бүрэн хараагүй, хэлгүй, дүлий болон одой хүн;

6/ хүний амь аврах, байгалийн гамшиг, осолтой тэмцэж иргэний журамт үүргээ биелүүлж яваад хөдөлмөрийн чадвараа бүрэн алдаж тахир дутуу болсон хүн;

7/ энэ зүйлийн 6-д зааснаар журамт үүргээ биелүүлж яваад нас барсан иргэний гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй гишүүд;

8/ амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрх толгойлсон бөгөөд 4 ба түүнээс дээш хүүхэдтэй 45 насанд хүрсэн эх /50 насанд хүрсэн эцэг/.

4 дүгээр зүйл. Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ

1. Нийгмийн халамжийн тэтгэврийг тухайн үеийн амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээгээр бодож олгоно.

2. Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 6, 7-д заасан иргэний нийгмийн халамжийн тэтгэврийг 20 хувиар нэмэгдүүлж болно.

5 дугаар зүйл. Жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрх, тэтгэмжийн хэмжээ

1. Эх хүүхдээ төрүүлэхийн өмнө 45 /ихэр бол 70/ хоног, амаржсаны дараа 56 хоног, ихэр хүүхэд төрүүлсэн, эсвэл хүүхдээ хүндрэлтэй төрүүлсэн бол 70 хоногийн амралтын хугацаанд жирэмсний болон амаржсаны тэтгэмж авах эрхтэй.

2. Хүүхдээ 196-гаас доошгүй хоног тээгээд дутуу төрүүлсэн буюу эмнэлгийн дүгнэлтээр ураг хөндүүлсэн, мөн 196 хоног тээгээгүй боловч амьдрах чадвартай хүүхэд төрүүлсэн эхэд амаржсаны тэтгэмж олгоно.

3. Энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу хүүхдээ асарч байх хугацаандаа хүүхэд төрүүлсэн эхэд жирэмсний болон амаржсаны тэтгэмж олгоно. Энэ тохиолдолд уг эхийн зөвхөн эхний хоёр удаагийн төрөлт хамаарагдана.

4. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг Засгийн газраас тухайн үед тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр бодож олгоно.

5. Хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч, төрийн болон цэргийн байгууллагын албан хаагч эхэд энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу олгох тэтгэмж, тухайн эхийн сарын хөдөлмөрийн хөлсний зөрүүг аж ахуйн нэгж, байгууллага нь олгож болно.

6 дугаар зүйл. Хүүхэд асарсны тэтгэмж авах эрх, тэтгэмжийн хэмжээ

1. Хөдөлмөрийн гэрээгээр ажилладаг бөгөөд амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой эх төрүүлсэн болон үрчлэн авсан хүүхдээ 2 настай /ихэр бол 3 настай/ болтол нь асрах хүсэлтээ гаргавал амаржсаны болон ээлжийн амралтаа эдэлсний дараа хүүхэд асарсны тэтгэмж авах эрхтэй.

2. Хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд нэн ядуу амьдралтай эх болон их, дээд сургууль, коллежийн оюутан эх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийг авах эрхтэй.

3. Хүүхэд асарсны тэтгэмжийг тухайн үеийн амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээ /ихэр бол хүүхэд тус бүрээр бодож/-гээр бодож, сар бүр олгоно.

4. Хүүхэд асарсны тэтгэмж авч байх хугацаандаа хүүхэд дахин төрүүлсэн болон үрчлэн авсан эхийн түрүүчийн хүүхэд асарсны тэтгэмжийг зогсоож, дараагийн хүүхдээ асрахад нь зориулан түүнд хүүхэд асарсны тэтгэмж олгоно. Уг тэтгэмж нь эхийн зөвхөн эхний хоёр удаагийн чөлөөний хугацаанд хамларна.

5. Хүүхдээ асарч байгаа эхэд аж ахуйн нэгж, байгууллага нь нэмэгдэл тэтгэмж олгож болно.

7 дугаар зүйл. Олон хүүхэдтэйн тэтгэмж авах эрх,  
тэтгэмжийн хэмжээ

1. Төрүүлсэн болон үрчилж авсан 16 хүртэл насны 4 ба түүнээс дээш хүүхэдтэй, тухайн үеийн амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой эх /эцэг/ олон хүүхэдтэйн тэтгэмж авах эрхтэй.

2. Амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой, 16 хүртэл насны 2 ба түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх /эцэг/-ийг энэ зүйлийн 1 дэх хэсэгт хамааруулна.

3. Олон хүүхэдтэйн тэтгэмжийг жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний байдлаар эсэн мэнд байгаа энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан насны хүүхэд тус бүрээр тооцож, дараахь хэмжээгээр жилд нэг удаа олгоно.

Хүүхдийн нас : хүүхэд тус бүрт олгох тэтгэмжийн хэмжээ төгрөгөөр

0-3	800
4-7	1500
8-15	2500

8 дугаар зүйл. Нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж  
авах эрх, тэтгэмжийн хэмжээ

1. Нэн ядуу өрхийн эх хүүхдээ төрүүлснээс хойш 3 сарын дотор нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж авах эрхтэй.

2. Нярай хүүхдийн арчилгааны тэтгэмжийн хэмжээг Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөл тогтоож байна.

9 дүгээр зүйл. Ихэр хүүхдийн тэтгэмж авах эрх,  
тэтгэмжийн хэмжээ

1. Хоёр ихэр хүүхэд төрүүлж эсэн мэнд өсгөж байгаа эхийн төрснөөс хойш 3 сарын дараа хүүхэд тус бүрд 5000 төгрөгийн тэтгэмж нэг удаа олгоно.

2. Гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг төрийн зардлаар асрамжлан өсгөөгүй бол энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийг хүүхэд тус бүрд олгоно.

10 дугаар зүйл. Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч, өсгөсний тэтгэмж авах эрх, тэтгэмжийн хэмжээ

1. Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч, өсгөж хүмүүжүүлж байгаа эцэг /эх/ үрчлэн авсан хүүхдээ 16 нас хүртэл нь тэтгэмж авах эрхтэй.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан тэтгэмжийн хэмжээг Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

11 дүгээр зүйл. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох өргөдөл гаргах, шийдвэрлэх хугацаа

1. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгох иргэн өргөдөл, хуульд заасан холбогдох баримт бичгийг дор дурдсан хугацаанд бүрдүүлж, сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/-д өгнө:

1/ нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгох иргэн уг тэтгэврийг тогтоолгон авахыг хүссэн хугацаандаа;

2/ жирэмсний тэтгэмж авах эх жирэмсний амралт эхэлсний дараа 2 долоо хоногийн дотор, амаржсаны тэтгэмж авах эх амаржсаны дараа 4 долоо хоногийн дотор;

3/ олон хүүхэдтэйн тэтгэмж эхний удаа авах иргэн жил бүрийн 5 дугаар сарын 1-ний дотор;

4/ хүүхэд асарсны тэтгэмж авах эх амаржсаны болон ээлжийн амралтаа эдэлсний дараа 2 долоо хоногийн дотор;

5/ нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж авах эх хүүхдээ төрүүлснээс хойш 4 долоо хоногийн дотор, ихэр хүүхдийн тэтгэмж авах эх ихэр хүүхдээ төрүүлснээс хойш 3 сар өнгөрсний дараа 2 долоо хоногийн дотор;

6/ бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч, өсгөсний тэтгэмж авах иргэн хүүхдээ үрчлэн авснаас хойш 4 долоо хоногийн дотор.

2. Тэтгэвэр авах өргөдлийг сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ хүлээж авснаас хойш 30 хоногийн дотор, тэтгэмж авах өргөдлийг 21 хоногийн дотор тус тус хянан шийдвэрлэнэ.

12 дугаар зүйл. Тэтгэвэр, тэтгэмж тогтоолгоход бүрдүүлэх баримт бичиг

1. Тэтгэвэр тогтоолгоход дор дурдсан баримт бичиг бүрдүүлнэ:

1/ энэ хуулийн 3 дугаар зүйлийн 1, 8-д заасан насанд хүрсэн, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авах эрх үүсээгүй, нэн ядуу амьдралтай буюу амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой болох тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт, хүүхдийн төрсний гэрчилгээ;

2/ энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2, 3, 5, 6-д заасан иргэний тахир дутуу болсныг тогтоосон эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын шийдвэр;

- 3/ энэ хуулийн 3 дугаар зүйлийн 4, 7-д заасан хөдөлмөрийн чадваргүй гишүүний төрсний гэрчилгээ, ам бүлийн тодорхойлолт.
2. Жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг эхийн өргөдөл, эмнэлгийн хуудсыг үндэслэн олгоно.
3. Хүүхэд асарсны тэтгэмж олгоход дор дурасан баримт бичиг бүрдүүлнэ:
- 1/ тухайн эхийн амьдарч байгаа өрхийн нэг хүнд ногдох орлого нь амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур буюу нэн ядуу амьдралтай өрх, иргэнд тооцогдох эсэх талаар баг, хорооны Засаг даргын тодорхойлолт;
  - 2/ хөдөлмөр эрхэлдэг эхэд хүүхдээ асрахад зориулж аж ахуйн нэгж, байгууллагаас чөлөө олгосон тухай шийдвэр;
  - 3/ суралцаж байгаа тухай их, дээд сургууль, коллежийн тодорхойлолт;
  - 4/ хүүхдийн төрсний гэрчилгээ.
4. Олон хүүхэдтэйн тэтгэмж олгоход дор дурасан баримт бичиг бүрдүүлнэ:
- 1/ хүүхдийн төрсний гэрчилгээ, эх /эцэг/-ийн иргэний паспорт буюу түүнтэй адилтгах баримт бичиг;
  - 2/ тухайн жилд хүүхэд нэмэгдэж, хасагдсан хөдөлгөөн, хүүхэд эсэн мэнд өсөн хүмүүжиж байгаа тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт.
5. Нярай хүүхдийн арчилгааны тэтгэмж олгоход дор дурасан баримт бичиг бүрдүүлнэ:
- 1/ хүүхэд эсэн мэнд өсөж байгаа тухай өрхийн эмчийн тодорхойлолт;
  - 2/ хүүхдийн төрсний гэрчилгээ;
  - 3/ нэн ядуу амьдралтай өрх, иргэнд тооцогдох тухай баг, хорооны Засаг даргын тодорхойлолт.
6. Ихэр хүүхдийн тэтгэмжийг олгоход дор дурасан баримт бичиг бүрдүүлнэ:
- 1/ ихэр хүүхдийн төрсний гэрчилгээ;
  - 2/ ихэр хүүхэд эсэн мэнд өсөж байгаа тухай өрхийн эмчийн тодорхойлолт;
  - 3/ гурав ба түүнээс дээш ихэр хүүхдийг төрийн зардлаар асрамжлан өсгөөгүй тухай сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт.
7. Бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч, өсгөсний тэтгэмж олгоход дор дурасан баримт бичиг бүрдүүлнэ:
- 1/ бүтэн өнчин хүүхдийн төрсний гэрчилгээ;
  - 2/ бүтэн өнчин хүүхэд үрчлэн авсан эцэг /эх/-ийн иргэний паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг;



3/ бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авч, өсгөн хүмүүжүүлж байгаа тухай сум, дүүргийн Засаг даргын тодорхойлолт.

13 дугаар зүйл. Тэтгэвэр, тэтгэмж олгох

1. Нийгмийн халамжийн тэтгэврийг Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1, 2, 3, 5 дахь хэсэгт заасны дагуу олгоно.

2. Жирэмсний болон амаржсаны, хүүхэд асарсны, нярай хүүхдийн арчилгааны, ихэр хүүхдийн, бүтэн өнчин хүүхэд үрчлэн авч, өсгөсний тэтгэмжийг сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллага /байцаагч/ тухайн иргэний ажиллаж, сурч байгаа аж ахуйн нэгж, байгууллагаар дамжуулан олгож, зохих тооцоог хийж байна.

3. Олон хүүхэдтэйн тэтгэмжийг жил бүрийн 6 дугаар сарын 1-ний дотор багтаан банкны байгууллагаар дамжуулан олгоно.

4. Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан тэтгэмжийг хөдөлмөр эрхэлдэггүй иргэнд сум, дүүргийн нийгмийн даатгалын байгууллагаас олгоно.

14 дүгээр зүйл. Тэтгэврийг нэгтгэн тогтоох, тэтгэвэр, тэтгэмжийг түдгэлзүүлж зогсоох, түүнээс суутгал хийх

Энэ хуулийн 3 дугаар зүйлийн 4, 7-д заасан гэр бүлийн хөдөлмөрийн чадваргүй бүх гишүүнд нийгмийн халамжийн тэтгэврийг нэгтгэн тогтооход Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн заалтыг, нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг түдгэлзүүлж зогсоох буюу түүнээс суутгал хийхэд мөн хуулийн 27, 29 дүгээр зүйлийн заалтыг тус тус баримтална.

15 дугаар зүйл. Тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг өөрчлөх

1. Амьжиргааны өргийн өөрчлөлттэй уялдуулан нийгмийн халамжийн бүх төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг өөрчлөх индексийг Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөлийн саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

2. Амьжиргааны баталгаажих доод түвшингийн хэмжээ өөрчлөгдсөн тухай бүр нийгмийн халамжийн тэтгэвэр болон хүүхэд асарсны тэтгэмжийн хэмжээг өөрчлөн тогтоож байна.

16 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

1. Энэ хуулийн 3, 4, 10 дугаар зүйлийг 1996 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс, 7 дугаар зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс, бусад зүйлийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн тус тус дагаж мөрдөнө.

2. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар  
сарын 18-ны өдөр

Улаанбаатар  
хот

### АХМАД НАСТАН, ТҮҮНД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь ахмад настанд хамрагдах хүрээ, ахмад настны нийгмийн хамгаалалтын талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний нөхцөл, хамрах хүрээ, хэмжээг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт,  
үйлчилгээний тухай хууль тогтоомж

1. Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Ахмад настанд хамрагдах хүрээ

Эрэгтэй нь 60 ба түүнээс дээш настай, эмэгтэй нь 55 ба түүнээс дээш настай Монгол Улсын иргэн болон Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суудаг, тус улсаас тэтгэвэр авдаг гадаадын иргэн, харьяалалгүй хүн ахмад настанд хамрагдана.

4 дүгээр зүйл. Ахмад настны нийгмийн хамгаалалтын талаар  
аж ахуйн нэгж, байгууллага, албан  
тушаалтны гүйцэтгэх үүрэг

1. Нийгмийн хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь ахмад настны нийгмийн хамгаалалтын талаар төрөөс баримтлах бодлогыг боловсруулж батлуулах, улсын төвлөрсөн төсвөөс болон нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх, ахмад настны нийгмийн хамгаалалтыг сайжруулах, энэ талаархи тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авна.

2. Бүх шатны Засаг дарга ахмад настны нийгмийн хамгаалалтын талаар тус тусын эрх хэмжээний дагуу дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

1/ баг, хорооны Засаг дарга ахмад настанг судлан бүртгэж, хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж олгуулах, хөнгөлөлт, үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авах, зохих тодоройлолт гаргах, холбогдох баримт бичгийг бүрдүүлдэг өгөх;

2/ сум, хороо, дүүргийн Засаг дарга ахмад настны нийгмийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг эрхлэн зохион байгуулах, ахмад настанг нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах буюу энэ талаар дээд шатны байгууллагад асуудал тавьж шийдвэрлүүлэх, ахмад настанг нийгмийн амьдралд идэвхтэй оролцуулах, эрүүл мэндийг нь хамгаалах, ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь дампуурсан өөр орон нутгаас шилжин ирсэн ахмад настныг нийгмийн хамгаалалтын арга хэмжээнд хамруулах, хот, суурин газарт амьдарч байгаа ахмад настанд зайлшгүй хэрэгцээтэй хүнсний зүйл худалдаалах үйлчилгээний цэгийг бий болгох, зарим ахмад настанд гэрээр нь үйлчлэх зэрэг арга хэмжээг зохион байгуулах;

3/ аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хэмжээнд ахмад настны нийгмийн хамгаалалтын талаар авах арга хэмжээний тухай санал боловсруулж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, ахмад настны нийгмийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах, ахмад настанг нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэр гаргах.

3. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байсан ахмад настанг байнга анхааран халамжилж, шаардлагатай бол түлш болон нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж олгох, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, орон сууцтай болоход нь туслах арга хэмжээ авна.

4. Ахмад настны ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх үүргийг шилжүүлэн авсан аж ахуйн нэгж, байгууллага энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлнэ.

5. Худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний газрын захиргаа ахмад настанд үйлчлэх дотоодын тусгай журам тогтоож мөрдөнө.

5 дугаар зүйл. Ахмад настны байгууллага

1. Ахмад настны эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий Засгийн газрын бус байгууллага /шаашид "ахмад настны байгууллага" гэх/-ыг үүсгэн байгуулж болно.

2. Ахмад настны олонхийн нийтлэг эрх ашгийг төлөөлж чадах ахмад настны төв байгууллагыг улсын төвлөрсөн төсвөөс, орон нутгийн байгууллагыг тухайн орон нутгийн төсвөөс тус тус санхүүжүүлнэ.

3. Ахмад настны талаархи төрийн бодлогын тодорхой асуудлыг боловсруулах, улс, нутаг дэвсгэрийн хэмжээний зохион байгуулалттай ажилд ахмад настанг татан оролцуулахтай холбогдсон төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг ахмад настны байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардлыг төсвөөс санхүүжүүлж болно.

4. Нийт ажиллагедын 70-аас доошгүй хувийг ахмад настан эзэлдэг, ахмадуудын санаачилгаар үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагад зайлшгүй шаардлагатай бол Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр дэмжлэг үзүүлж болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ, хүндэтгэл

б дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх хөнгөлөлт, түүний нөхцөл, хамрах хүрээ, хэмжээ

1. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний сангаас дор дурдсан ахмад настанд дараахь нөхцөл, хэмжээгээр хөнгөлөлт үзүүлнэ:

1/ Хөдөлмөрийн баатар, ардын болон гавьяат цолтон, 1939 оны Халхын голын байдлаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгаралтад оролцсон, төрийн өндөр албан тушаалд ажиллаж байсан ахмад настан болон амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой ахмад настны эзэмшиж байгаа орон суушны байрны /талбай, халаалт, цэвэр, бохир усны/ хөлсний 50 хувь, гэр, ердийн галзлагаатай сууцанд амьдардаг бол жилд 1 удаа 4 шоо метр түлээ, 4 тонн нүүрсний үнэ /тээврийн хөлсийг оруулж тооцсон/-ийн 50 хувийг тус тус нөхөн олгоно;

2/ 1939 оны Халхын голын байдлаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгаралтад оролцсон ахмад настан болон түүнд амь үрэгдсэн дайчны эхнэр, нөхөрт Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцсон нэг сарын хөлстэй тэнцэх хэмжээний тусламжийг жилд нэг удаа олгоно;

3/ 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгаралтад оролцсон ахмад настан болон эмнэлгийн байгууллагын дүгнэлтээр рашаан сувилалд сувилуулах шаардлагатай болсон амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой ахмад настанд эх орны рашаан сувилалд явах унааны нэг талын зардал, зар бичгийн үнийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгоно;

4/ нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг ахмад настан аймгийн мэргэжлийн эмнэлгийн эмч нарын хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгоно;

5/ ахмад настанд шаардагдах хөл, гар, шүд /үнэт металлээр хийхээс бусад/, сонсох, харах эрхтэний дотоодын протез хийлгэх нэг удаагийн зардлыг олгоно.

2. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллага, түүнчлэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь ахмад настны гүйцэтгэж байсан ажлын нөхцөл, онцлог, байгуулсан гавьяа, зүтгэлийг харгалзан түүнд нэмэгдэл хөнгөлөлт тогтоон олгох эрхтэй.

3. Ахмад настанд орон суушны нөхцөлөө сайжруулах, орон сууц барихад нь зориулж хөнгөлөлттэй зээл олгож болно.

4. Бүтэн буюу хагас өгчин хүүхдийн асран хамгаалагч ахмад настан нь тэтгэвэр, тэтгэмжээс өөр орлогогүй бөгөөд уг хүүхэд дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуульд зохих журмын дагуу тэнцсэн бол түүний сургалтын зардлыг төрийн боловсролын сангаас гаргана.

5. Энэ зүйлд заасан хөнгөлөлт үзүүлэх, хөнгөлөлттэй зээл олгох, төрийн боловсролын сангаас сургалтын зардал гаргах журмыг Засгийн газар тогтооно.

7 дугаар зүйл. Ардын хувьсгалын партизан, Монгол Улсын баатар ахмад настанд үзүүлэх нэмэлт хөнгөлөлт

1. Ардын хувьсгалын партизан, Монгол Улсын баатар ахмад настанд энэ хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, 5-д болон мөн зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасан хөнгөлөлтөөс гадна дор дурдсан нэмэлт хөнгөлөлт үзүүлнэ:

1/ эзэмшиж байгаа орон суушны байр /талбай, халаалт, цэвэр, бохир ус/-ны хөлсийг, гэр, ердийн галлагатай сууцанд амьдардаг бол жилд хэрэглэх түлээ, нүүрсний үнийг тус тус 100 хувь нөхөн олгоно;

2/ Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээгээр тооцсон нэг сарын хөлстэй тэнцэх хэмжээний тусламжийг улиралд нэг удаа олгоно;

3/ жилд нэг удаа эх орны рашаан сувилалд явах замын зардал /ирэх, буцах/, зар бичгийн үнийг олгоно;

4/ нийслэлээс аймагт, аймгаас нийслэлд ирэх, буцах замын зардлыг жилд нэг удаа олгоно.

2. Энэ зүйлд заасан нэмэлт хөнгөлөлт үзүүлэхэд шаардагдах хөрөнгийг улсын төвлөрсөн төсвөөс гаргана.

3. Энэ зүйлд заасан нэмэлт хөнгөлөлт үзүүлэх журмыг Засгийн газар тогтооно.

8 дугаар зүйл. Ахмад настанд үзүүлэх үйлчилгээ

1. Нийгмийн халамжийн тухай хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу ахмад настныг нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээнд хамруулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлчилгээнд ахмад настан төлбөртэйгээр хамрагдахыг хүссэн тохиолдолд нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний байгууллага шаардлагатай үйлчилгээ үзүүлж тусална. Төлбөртэй үйлчилгээний журмыг нийгмийн хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож мөрдүүлнэ.

3. Ахмад настан нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн хэрэгсэл /таксинаас бусад/-ээр үнэ төлбөргүй, худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний газраар эхний ээлжинд тус тус үйлчлүүлнэ.

9 дүгээр зүйл. Ахмад настанд үзүүлэх хүндэтгэл

1. Билгийн улирлын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгэн болон бусад тэмдэглэлт өдрийг тохиолдуулан аж ахуйн нэгж, байгууллага урьд ажиглаж байсан ахмад настандаа хүндэтгэл үзүүлж, бэлэг дурсгалын зүйл гардуулж байна.

2. Билгийн улирлын хаврын тэргүүн сар-цагаан сарын шинийн нэгнийг тохиолдуулан тухайн нутаг дэвсгэрийн хамгийн ахмад настанд аймаг, нийслэл, сум, дүүрэг, баг, хорооны Засаг даргын, 100 ба түүнээс дээш настай ахмад настанд Монгол Улсын Ерөнхийлөгчийн мэндчилгээ, гарын бэлгийг тус тус гардуулна.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Бусад зүйл

10 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

11 дүгээр зүйл. Ахмад настан орон сууц эзэмших, ашиглах эрхээ шилжүүлэх

Ахмад настан төрийн болон орон нутгийн өмчийн орон сууцыг эзэмших, ашиглах эрхээ хуульд заасны дагуу өв залгамжлуулан шилжүүлж болно.

12 дугаар зүйл. Бусад заалт

1. Ахмад настан нас барсан тохиолдолд түүний ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь хүндэтгэл үзүүлж, оршуулгын ажилд тусална.

2. Асран хамгаалагч, тэжээн тэтгэгчгүй ганц бие ахмад настан нас барвал оршуулгын ажлыг тухайн нутаг дэвсгэрийн Засаг дарга зохион байгуулж, зардлыг орон нутгийн төсвөөс гаргана.

3. Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжид заасан оршуулгын тэтгэмж авах эрх үүсэх боломжгүй ахмад настан нас барсан бол түүний оршуулгын зардлын зохих хэсгийг тухайн орон нутгийн төсвөөс гаргана. Төсвөөс олгох зардлын хэмжээг Засгийн газар тогтооно.

4. Энэ зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан оршуулгын ажлыг зохион байгуулах болон оршуулгын зардлыг олгох журмыг аймаг, нийслэлийн Засаг дарга тогтоож мөрдүүлнэ.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ТАХИР ДУТУУ ХҮНИЙ НИЙГМИЙН ХАМГААЛАЛТ, ТҮҮНД ҮЗҮҮЛЭХ ХӨНГӨЛӨЛТ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТУХАЙ

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

##### Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

Энэ хуулийн зорилт нь тахир дутууг тогтоох журам, тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын арга хэмжээ болон энэ талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, тахир дутуу хүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний нөхцөл, хамрах хүрээ, хэмжээг тогтооход оршино.

2 дугаар зүйл. Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль тогтоомж

1. Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль тогтоомж нь Үндсэн хууль, Нийгмийн халамжийн тухай хууль, энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2. Монгол Улсын олон улсын гэрээнд Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хууль тогтоомжоос өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Тахир дутуу хүн, түүнд хамрагдах хүрээ

Бие бялдар, оюун ухааны чадавхи нь удамшлын болон удамшлын бус шалтгаан, төрөлхийн гажиг өөрчлөлт, өвчин, осол гэмтлийн улмаас алдагдаж, хэвийн нөхцөлд хөдөлмөрлөх чадваргүй болсон, хараа, сонсгол, хэл ярианы болон бие эрхтэний тахир дутуу, оюун ухааны хомсдол, сэтгэцийн өөрчлөлттэй болох нь тогтоогдсон Монгол Улсын иргэн, Монгол Улсад хууль ёсоор байнга оршин суугаа гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг тахир дутуу хүн гэнэ.

4 дүгээр зүйл. Тахир дутууг тогтоох, үнэмлэх олгох

Тахир дутууг тухайн иргэний оршин суугаа аймаг, сум, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс тогтооно.



2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын тогтоолыг үндэслэн тахир дутуу хүнийг сум, дүүргийн Засаг даргын тамгын газар бүртгэж, тахир дутуугийн үнэмлэх олгоно.

3. Тахир дутуугийн үнэмлэх нь тахир дутуу хүн хууль тогтоомжид заасан эрхээ эдлэх, хөнгөлөлт, үйлчилгээнд хамрагдах үндсэн баримт болно.

4. Тахир дутуугийн үнэмлэхийн загвар, үнэмлэх олгох журмыг Нийгмийн хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага баталж мөрдүүлнэ.

5 дугаар зүйл. Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын талаар аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтны гүйцэтгэх үүрэг

1. Нийгмийн хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын талаархи төрийн бодлогыг боловсруулж батлуулах, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах, тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын асуудлаар нутгийн захиргааны байгууллагыг арга зүйн удирдлагаар хангах үүргийг хэрэгжүүлнэ.

2. бүх шатны Засаг дарга тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын талаар тус тусын эрх хэмжээний дагуу дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

1/ баг, хорооны Засаг дарга тахир дутуу хүнийг судлан бүртгэж, эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссоор түүний тахир дутуу болохыг тогтоолгох ажлыг зохион байгуулах, хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж олгуулах, хөнгөлөлт, үйлчилгээнд хамруулах арга хэмжээ авах, зохих тодорхойлолт гаргах, холбогдох баримт бичгийг бүрдүүлж өгөх;

2/ сум, хороо, дүүргийн Засаг дарга тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг эрхлэн зохион байгуулж, тахир дутуу хүнийг нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээнд хамруулах шийдвэр гаргах буюу энэ талаар дээд шатны байгууллагад асуудал тавьж шийдвэрдүүдэх, тахир дутуу хүний эрүүд мэндийг хамгаалах, түүнийг тусгайлсан болон ердийн сургалтад хамруулах, урлаг соёлын арга хэмжээнд татан оролцуулах, ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь дампуурсан, өөр орон нутгаас шилжин ирсэн тахир дутуу хүнийг нийгмийн хамгаалалтын арга хэмжээнд хамруулах;

3/ аймаг, нийслэлийн Засаг дарга тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын талаар орон нутгийн хэмжээнд авах арга хэмжээний асуудлаар санал боловсруулж иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд оруулах, тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын тухай хууль

тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналтыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах, тахир дутуу хүнийг нийгмийн асрамжийн үйлчилгээнд хамруулах тухай шийдвэр гаргах.

3. Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажиллаж байгаад тахир дутуу болсон хүмүүсээ байнга анхааран халамжилж, эмчилгээ хийлгэх зардал болон түлш, нэмэгдэл тэтгэвэр, тэтгэмж олгох, хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд дэмжлэг үзүүлэх, орон сууцтай болоход нь туслах арга хэмжээ авна.

4. Тахир дутуу хүний ажиллаж байсан аж ахуйн нэгж, байгууллага нь өөрчлөн зохион байгуулагдсан буюу татан буугдсан бол түүний эрх үүргийг шилжүүлэн авсан аж ахуйн нэгж, байгууллага нь энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан үүргийг хэрэгжүүлнэ.

5. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний болон тахир дутуу хүмүүсийн санаачилгаар буюу тэдгээрт зориулан үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллага нь тахир дутуу хүнд зохицсон хөдөлмөр зохион байгуулалтын арга хэмжээ авах, түүнд нийгмийн амьдрал оролцох, орлого олох чадвар эзэмшихэд нь туслах үйл ажиллагаа явуулах, хууль тогтоомжийн дагуу шаардлагатай халамж, асрамжийн үйлчилгээ үзүүлэх ажлыг эрхэлнэ.

6. Худалдаа, тээвэр, холбоо, эрүүл мэнд, нийтийн үйлчилгээний газрын захиргаа тахир дутуу хүнд үйлчлэх дотоодын тусгай журам тогтоож мөрдөнө.

6 дугаар зүйл. Тахир дутуу хүний эрх ашгийг хамгаалах

Засгийн газрын бус байгууллага

1. Тахир дутуу хүний эрх ашгийг хамгаалах үүрэг бүхий Засгийн газрын бус байгууллагыг үүсгэн байгуулж болно.

2. Тахир дутуу хүний талаархи төрийн бодлогын тодорхой асуудлыг боловсруулах, улс, нутаг дэвсгэрийн хэмжээний зохион байгуулалттай зарим ажил, соёл, урлаг, биеийн тамир, спортын арга хэмжээнд тахир дутуу хүнийг татан оролцуулахтай холбогдсон төрийн гүйцэтгэх байгууллагын зарим чиг үүргийг тахир дутуу хүний эрх ашгийг хамгаалах Засгийн газрын бус байгууллагаар гүйцэтгүүлж, төсөл, арга хэмжээний зардалыг санхүүжүүлж болно.

## ХОЁРДУГААР БҮЛЭГ

### Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалтын арга хэмжээ

7 дугаар зүйл. Тахир дутуу хүний бие эрхтэний  
нөхөн сэргээлт

1. Тахир дутуу хүн нийгмийн амьдралд идэвхтэй оролцох, чийрэгжих, өөрөө өөртөө үйлчилж сурах, хөдөлмөрлөх чадвартай болох зорилгоор үйл ажиллагаа нь алдагдсан эрхтэнээ сэргээх, солиулах зэргээр нөхөн сэргээлтийн эмчилгээ, үйлчилгээнд хамрагдана.

2. Тахир дутуугийн нөхөн сэргээлтийг эмчилгээ, сувилгаа, сургалт, биений тамир, чийрэгжүүлэлтийн үйл ажиллагаа болон протез, ортопедийн хэрэгслийн үйлдвэрлэл явуулдаг аж ахуйн нэгж, байгууллага эрхэлнэ.

3. Тахир дутуугийн нөхөн сэргээлтийн зориулалттай тоног төхөөрөмж, протез, ортопедийн хэрэгсэл үйлдвэрлэдэг, засварладаг аж ахуйн нэгж, байгууллагын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх үүргийг төр хүлээнэ.

8 дугаар зүйл. Тахир дутуу хүний боловсрол, сургалт

1. Хөдөлмөрийн насанд хүрсэн тахир дутуу хүн сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үеэс бусад тохиолдолд эрүүл хүмүүстэй хамт сурч, боловсрох, мэргэжил эзэмшихийг төрөөс дэмжинэ.

2. Бүх шатны боловсролын болон мэргэжил олгох байгууллага нь сурч, мэргэжил эзэмших чадвартай тахир дутуу хүнийг сүрьеэ зэрэг архаг халдварт өвчнийг бусад халдварлуулахаас сэргийлэхээс бусад шалтгаанаар элсүүлэх, элсэлтийн шалгалтад оруулахаас татгалзахыг хориглоно.

3. Сургуулийн өмнөх насны хүүхдийн байгууллага нь тухайн байгууллагад хүмүүжиж чадах бэлтгэл хангасан тахир дутуу хүүхдийг сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үеэс бусад тохиолдолд эрүүл хүүхэдтэй хамт өсгөж хүмүүжүүлнэ.

4. Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан тахир дутуу хүүхдийг эрүүл хүүхэдтэй хамт сурч боловсрох боломжийг нь төр, олон нийт, эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, бэлтгэлийг нь сургуулийн өмнөх насны тусгай сургалтын байгууллага тус тус хангана.

5. Дотоодын их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургуульд зохих журмын дагуу тэнцсэн нэн ядуу амьдралтай өрхийн тахир дутуу сурагч, окутны болон хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүдтэй /эхнэр, нөхөр хоёулаа буюу аль нэг нь/

өрхийн нэг сурагч, оюутны сургалтын зардлыг төрийн боловсролын сангаас гаргана.

6. Тусгай нөхцөлд сургалт-хүмүүжлийн болон үйлдвэрлэл-сургалтын үйл ажиллагаа эрхэлдэг цэцэрлэг, ясли, сургууль, үйлдвэрлэл-сургалтын аж ахуйн нэгж, байгууллага /шаашид "тусгай сургалтын байгууллага" гэх/-д тахир дутуу хүүхэд, насанд хүрэгчдийг тусгай сургалтад хамруулна. Тусгай сургалтын байгууллагад хамрагдах тахир дутуу хүүхэд, насанд хүрэгчийн тодорхойлолтыг аймаг, сум, дүүргийн эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс, боловсролын байгууллага хамтран гаргана.

7. Тусгай сургалтын байгууллага тахир дутуу хүнд түүний боломжид тулгуурласан стандарт, шаардлагын дагуу боловсрол эзэмшүүлдэг. Тусгай сургалтын стандартыг боловсролын болон нийгмийн хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран боловсруулж, стандартчиллын төв байгууллага батална.

8. Тусгай сургалтын төрийн өмчийн байгууллагын инженер-техникийн болон үйлчилгээний ажилтан, арга зүйч, багш, сурган хүмүүжүүлэгч, тусгай сургалтын цэцэрлэг, ясли, сургуулийн эрхлэгч, захиралд төрийн үйлчилгээний ижил төрлийн албан хаагчийн хөдөлмөрийн хөлсний сүлжээнд заасан албан тушаалын цалингийн 10-30 хувиар бодож нэмэгдэл хөлс олгоно.

9. Тухайн ажлын нөхцөл, машин, тоног төхөөрөмжийн ажиллагаа нь тахир дутуу хүний амь бие эрүүл мэндэд хохирал учруулахааргүй байвал түүний техниктэй харьцаж сурах сургалтыг төрөөс дэмжиж, энэ талаархи мэдээллийг түүнд үнэ төлбөргүй хүргэнэ.

10. Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан сургалтын зардал, мөн зүйлийн 8 дахь хэсэгт заасан нэмэгдэл хөлс олгох журмыг Засгийн газар батална.

9 дүгээр зүйл. Тахир дутуу хүний хөдөлмөр эрхтэлт

1. Тахир дутуу хүн ажиллах чадвар, мэргэжил бололцоондоо тулгуурлан хөдөлмөр, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд төрийн зүгээс бүх талын дэмжлэг үзүүлдэг.

2. Тахир дутуу хүн ажилладаг аж ахуйн нэгж, байгууллагад хууль тогтоомжид заасан хөнгөлөлт, дэмжлэг үзүүлдэг.

Хараагүй, дүлий болон эрхтэн дутуу хүмүүсийн санаачилгаар, эсвэл тэдэнд зориулан төрөөс үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагад зайлшгүй шаардлагатай бол Засгийн газрын болон аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн шийдвэрээр дэмжлэг үзүүлэх буюу улс, орон нутгийн төсвөөс зохих аргаар нь нөхөн санхүүжүүлж болно.

3. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид тахир дутуу хүнийг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажлаас халах, сүрьеэ зэрэг архаг халдварт өвчний халдвартай үеэс бусад тохиолдолд боломжтой ажил, албан тушаалд авч ажиллуулахаас татгалзахыг хориглоно.

4. Хараагүйн улмаас хөдөлмөрийн чадвараа алдсан иргэний ажлын өдрийн үргэлжлэлийг 2 цагаар хорогдуулна.

10 дугаар зүйл. Тахир дутуу хүний соёл, урлаг, биеийн тамирын арга хэмжээ

1. Тахир дутуу хүнийг соёл, урлаг, биеийн тамирын арга хэмжээнд идэвхтэй оролцох, энэ чиглэлээр ажиллахыг төр дэмжинэ.

2. Тахир дутуу хүнд зориулсан соёл, урлаг, биеийн тамир, спортын арга хэмжээ нь түүний чадавхид зохицсон байхаас гадна энэ талаар төрөөс баримтлах нийтлэг зарчимтай уялдсан байна.

3. Тахир дутуу хүний сэтгэл санааг өөдрөг байлгах зорилгоор дор дурдсан арга хэмжээг төр зохион байгуулна:

1/ тахир дутуу хүний ажил, амьдралын талаар төрийн хөвтөл, мэдээллийн хэрэгслээр үнэ төлбөргүй сурталчлах,

2/ хараагүй, дүлий, оюуны хомсдолтой хүнийг түүнд зориулсан хөвтөл, мэдээллийн материалаар хангах, телевизийн хөтөлбөр, зарим киног дохионы хэлний орчуулгатай гаргах;

3/ тахир дутуу хүнийг биеийн тамирт өргөнөөр хамруулах, тэднийг тахир дутуу хүмүүсийн олон улсын хэмжээний болон өөрийн оронд зохиогддог соёл, урлаг, спортын арга хэмжээнд оролцуулж, туршлага солилцуулах.

4. Аж ахуйн нэгж, байгууллагын эрх баригчид тахир дутуу хүний соёл, урлаг, биеийн тамир спортын арга хэмжээг ивээн тэтгэхийг төрөөс дэмжинэ.

## ГУРАВДУГААР БҮЛЭГ

### Тахир дутуу хүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээ

11 дүгээр зүйл. Тахир дутуу хүнд үзүүлэх хөнгөлөлт, түүний нөхцөл, хамрах хүрээ, хэмжээ

1. Нийгмийн халамж, асрамжийн үйлчилгээний сангаас дор дурдсан тахир дутуу хүнд дараахь нөхцөл, хэмжээгээр хөнгөлөлт үзүүлнэ:

1/ хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан тахир дутуу гишүүнтэй, имьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой өрсийн эзэмшиж байгаа орон сууцны байрны талбайн хөлсийг тахир дутуу нэг хүнд 10 ам метр оногдохоор бодож нөхөн олгоно,

2/ хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан тахир дутуу гишүүнтэй, амьжиргааны баталгаажих доод түвшингээс доогуур орлоготой, гэр болон ердийн галлагаатай сууцанд амьдардаг өрхийн 4 шоо метр түлээ, 4 тонн нүүрсний үнэ /тээврийн хөлсийг оруулж тооцсон/-ийн 50 хувийг жилд нэг удаа нөхөн олгоно;

3/ нийслэлээс 1000 ба түүнээс дээш км алслагдсан газарт байнга оршин суудаг, нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэртэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх үүсээгүй, нэн ядуу амьдралтай өрхийн тахир дутуу гишүүн өвчний улмаас аймгийн мэргэжлийн эмнэлгийн хяналтын комиссын шийдвэрээр нийслэлд ирж эмчлүүлэх, шинжилгээ хийлгэх зайлшгүй шаардлагатай тохиолдолд нэг талын унааны зардлыг жилд нэг удаа нөхөн олгоно;

4/ нэн ядуу амьдралтай өрхийн 16 хүртэлх насны /суралцаж байгаа бол 19 хүртэл/ тахир дутуу хүүхэд болон нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэртэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр авах эрх үүсээгүй нэн ядуу амьдралтай тахир дутуу хүний дотоодын протез, ортопедийн хэрэгслийн үнийг нэг удаа 100 хувь нөхөн олгоно;

5/ нэн ядуу амьдралтай өрхийн 16 хүртэлх насны /сурч байгаа бол 19 хүртэл/ тахир дутуу хүүхдийн зориулалтын тэргэцрийн үнийг нэг удаа 100 хувь нөхөн олгоно;

6/ байнгын асрамжинд байдаг тахир дутуу хүүхдээ /16 хүртэлх насны/ асарч байгаагийн улмаас хөдөлмөр эрхэлдэггүй бөгөөд нэн ядуу амьдралтай өрхийн гишүүн асран хамгаалагч /нэг хүн/-д тухайн үеийн амьжиргааны баталгаажих доод түвшингийн 75 хувьтай тэнцэх хэмжээний тусламжийг хүүхдээ асархад нь зориулж сар бүр олгоно ;

7/ 10-аас доошгүй жил хөдөлмөр эрхэлсэн бүрэн хараагүй хүнд магнитфоныг нэг удаа 50 хувийн хөнгөлөлттэй үнээр, мөн, хугацаанд хөдөлмөр эрхэлсэн сонсгол султай хүнд мэргэжлийн эмч нарын магадлагааг үндэслэн сонсголын аппаратыг эхний удаа үнэгүй, 2 дахь удаад 50 хувийн хөнгөлөлттэй үнээр тус тус олгоно;

8/ тусгай сургуульд орон нутгаас ирж суралцдаг хараагүй, хэлгүй дүлий сурагчийн анх ирэх болон амралтаараа орон нутагтаа буцах ирэх унааны зардлыг олгоно;

9/ нийслэлд болон аймгийн төвийн суманд байнга оршин суудаг хөдөлмөрийн насанд хүрсэн бүрэн хараагүй хүний гэрт өөрийн нэ зардлаар телефон утас тавина. Хэрвээ уг иргэн тухайн үеийн

амьжиргааны баглагаажих доод түвшингээс доогуур орлоготой бол телефон утасны сар бүрийн хөлсний 50 хувийг хөнгөлнө;

10/ нөхөр, эхнэр хоёулаа хараагүй буюу өрхийн дотор нь бүрэн хараагүй, дүлий 2 ба түүнээс дээш хүн амьдардаг бол тухайн өрхийн эзэмшиж байгаа орон сууцны байрны хөлс /талбай, цахилгаан, дулааны/-ийг 100 хувь, гэр болон ердийн галлагаатай сууцанд амьдардаг бол жилд нэг удаа 4 тонн нүүрс, 4 шоо метр модны үнэ /тээврийн хөлсийг оруулж тооцсон/-ийг 100 хувь тус тус нөхөн олгоно;

11/ нийтдээ 10-аас доошгүй жил хөдөлмөр эрхэлсэн бүрэн хараагүй, дүлий хүнийг эх орны рашаан сувилалд сувилуулахад жилд нэг удаа /зөвхөн аймгийн төв хүртэлх/ унааны болон зар бичгийн үнийн 50 хувийг хөнгөлнө.

2. Тахир дутуу хүн нийслэл, аймгийн төвийн нийтийн тээврийн /таксинаас бусад/ хэрэгслээр үнэ төлбөргүй зорчино.

3. Хараагүй хүний брайлын үсгээр бичсэн захидал, ил захидал, 10 кг-аас доош илгээмжийг үнэ төлбөргүй явуулж, өрхийн дотор нь хөдөлмөрийн чадвартай гишүүн байхгүй бол хараагүй хүний төлөх радио цэгийн хураамжийг чөлөөлнө.

4. Хөдөлмөрийн чадвартай гишүүнгүй өрхийн хараагүй, дүлий хүний 4 хүртэл насны хүүхдийг цэцэрлэг, яслид үнэ төлбөргүй асарч, хүмүүжүүлнэ.

5. Энэ зүйлд заасан хөнгөлөлт үзүүлэх журмыг Засгийн газар тогтоож мөрдүүлнэ.

12 дугаар зүйл. Тахир дутуу хүнд үзүүлэх үйлчилгээ

1. Тахир дутуу хүнийг хууль тогтоомжид заасны дагуу асрамжийн газарт байнга асрах буюу халамжийн төвийн үйлчилгээнд хамруулна.

2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйлчилгээнд тахир дутуу хүн төлбөртэйгээр хамрагдахыг хүссэн тохиолдолд нийгмийн халамжийн болон асрамжийн үйлчилгээний байгууллага шаардлагатай үйлчилгээ үзүүлж туслана. Төлбөртэй үйлчилгээний журмыг нийгмийн хамгаалалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтоож мөрдүүлнэ.

3. Хүн ам олноор зорчиж, цуглардаг үйлчилгээ, үзвэрийн газар, талбай, зам, гүүр болон утсан харилцааны хэрэгсэл тахир дутуу хүн зорчих, биеэ авч явахад зохицсон байх бөгөөд эдгээрийн нэр, утсан харилцааны хэрэгсэл байрлах цэгийн жагсаалтыг сум, дүүргийн Засаг дарга батална.

## ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

### Бусад зүйл

13 дугаар зүйл. Хууль зөрчигчид хүтээлгэх хариуцлага

Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлдэх хөнгөдөлт, үйлчилгээний тухай хуулийг зөрчсөн гэм буруутай этгээдэд хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүтээлгэнэ.

14 дүгээр зүйл. Бусад заалт

Нийгмийн амьдралд идэвхтэй оролцож дорвитой хувь нэмэр оруулсан тахир дутуу хүн болон тахир дутуу хүний эрх ашгийг хамгаалахад онцгой гавьяа байгуулсан иргэнийг шагнаж урамшуулах бөгөөд уг асуудлаар Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөл холбогдох байгууллагад санал тавина.

15 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар  
сарын 19-ний өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ, ХУУЛИЙН ЗАРИМ ЗҮЙЛИЙГ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Тэтгэмжийн хуулийн 3 дугаар зүйлд "жирэмсний болон амаржсаны, хүүхдийн, хүүхэд асарсны", 5 дугаар зүйлд "хүүхдийн, хүүхэд асарсны, жирэмсний болон амаржсаны тэтгэмжийг улсын төсвийн хөрөнгөөс" гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Монгол Улсын Тэтгэврийн болон Тэтгэмжийн хуулийн дараахь зүйлийг дор дурдсан хугацаанаас эхлэн хүчингүй болсонд тооцугай:

1/ Монгол Улсын Тэтгэмжийн хуулийн 10, 11, 12, 14, 16, 17, 18, 19 дүгээр зүйлийг 1996 оны 2 дугаар сарын 1-нээс, мөн хуулийн 13, 15 дугаар зүйлийг 1997 оны 1 дүгээр сарын 1-нээс;



2/ Монгол Улсын Тэтгэврийн хуулийн 27, 44, 47, 48, 73 дугаар зүйлийг 1996 оны 7 дугаар сарын 1-нээс.

3 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрднө.

Монгол Улсын Их Хурлын дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар  
сарын 25-ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол улсын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт, 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийг дор дурасанаар өөрчлөн найруулсугай:

1/ 5 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт:

"1/ төсвийн ерөнхийлөн болон төвлөрүүдэн захирагчаас хуваарилан хүргүүлсэн төсөв, Засгийн газрын тусгай санг зориулалтын дагуу зарцуулах."

2/ 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын өргөн барьсан төсвийн төслийг төсвийн жил эхлэхээс өмнө хянан хэлэлцэж, сум, дүүргийн төсвийн орлогыг нийт дүн /орлогын нэр төрлөөр/ зарлагыг төсвийн шууд захирагч тус бүрээр, зардлын зүйлээр баталж тогтоол гаргана."

2 дугаар зүйл. Монгол Улсын Төсвийн тухай хуульд дор дурасан агуулгатай 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 13; 10 дугаар зүйлийн 4; 13 дугаар зүйлийн 5; 17 дугаар зүйлийн 8; 18 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус нэмсүгэй:

1/ 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 13 дахь заалт:

"13/ төсвийн дансны үлдэгдлийг банкинд ашиглуулсны төлөө гэдгээрээс гэрээний дагуу хүү авах."

2/ 10 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

"4. Төсвийн хөрөнгийг энэ хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд зээл буюу гэрээний үүргийн баталгаа болгох, бусдад хандивлах, ивээн тэтгэх, хувь нийлүүлэх, түр ашиглуулах болон Засгийн газраас тогтоосон журамд зааснаас бусад хэлбэрээр эргэж төлөгдөх нөхцөлөөр ашиглуулахыг хориглоно."

3/ 13 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:

"5. Дээд шатны төсвийн ерөнхийлөн захирагч доод шатны төсвийн жилийн тайлангаар төсвийн зарлагаас давсан орлогыг тухайн шатны төсвийн ерөнхийлөн захирагчтай зөвшилцөн бүс нутгийг хөгжүүлэх арга хэмжээнд зарцуулахаар төвлөрүүлэн авч болно."

4/ 17 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:

"8. Дээд шатны төсвийн захирагч доод шатны төсвийн зарцуулалтын гүйцэтгэлд хяналт тавьж, үйл ажиллагаанд нь санхүүгийн шалгалт хийж илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээ авна."

5/ 18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:

"2. Монголбанк, түүний салбар нь жилийн дүнгээр аздагдалгүй төлөвлөгдсөн боловч төсвийн гүйцэтгэлийн явцад улирлын чанартай гарсан төсвийн орлого, зарлагын зөрүүг нөхөхөд зориулж тухайн төсвийн жил дуусахаас өмнө төлөгдсөн байхаар түр хугацааны зээлийг төсвийн ерөнхийлөн захирагчид зохих хүүтэйгээр олгож болно. Зээл олгох, эгүүлэн төлүүлэх журмыг Засгийн газар, Монголбанк тогтооно."

Монгол Улсын Их Хурлын дэд дарга

Ж. ГОМБОЖАВ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### УЛСЫН ТЭМДЭГТИЙН ХУРААМЖИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын тэмдэгтийн хураамжийн хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг "2. Шүүхэд эрх зүйн маргаан хянан шийдвэрлүүлсний хураамжийг шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн журмаар төлүүлдэг." гэж өөрчлөн найруулсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 1996 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө. Энэ хуулийг буцаан хэрэглэхгүй.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

1995 оны 12 дугаар  
сарын 26-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ПРОКУРОРЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Прокурорын байгууллагын тухай хуулийн дараахь зүйл, хэсгийг дор дурдсанаар өөрчлөн нэвтрүүлсүгэй:

1/ 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5:

“5/ анхан шатны болон давж заалдах шатны шүүхийн хуулийн хүчин төгөлдөр болсон шийдвэр хуульд нийцээгүй гэж үзвэл эсэргүүцэл бичих;”

2/ 36 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:

“6. Прокурор дүрэмт хувцастай байна. Прокурорын дүрэмт хувцсанд прокурорын зэрэг дэвнийг тусгасан ялгах тэмдэг байна. Тэдгээрийн загвар, хэрэглэх журмыг Ерөнхийлөгч батална.”

3/ 39 дүгээр зүйлийн 1, 5, 6 дахь хэсэг:

“1. Прокурор хууль болон байгууллагын дотоод журмыг зөрчсөн, прокурорын ёс зүйн хэм хэмжээ, хуульд заасан албан үүргээ биелүүлээгүй бол тухайн зөрчлийн шинж байдлыг харгалзан дараахь сахилгын шийтгэл оногдуулна:

1/ сануулах;

2/ албан тушаалын шалингийн хэмжээг 6 сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

3/ албан тушаал бууруулах;

4/ ажлаас халах.

5. Аймаг, нийслэлийн прокурор болон түүнтэй адилтгах прокурор нь энэ зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2-г заасан сахилгын шийтгэлийг харьяа прокурорт оногдуулж болно.

6. Прокурор сахилгын шийтгэл оногдуулсан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл энэ тухай гомдлоо тухайн шийдвэрийг мэдсэн өдрөөс хойш 1 сарын дотор:

1/ аймаг, нийслэлийн прокурор оногдуулсан бол Улсын ерөнхий прокурорт;

2/ Улсын ерөнхий прокурор оногдуулсан бол шүүхэд тус тус гаргана.

2 дугаар зүйл. Прокурорын байгууллагын тухай хуульд дор дурдсан агуулгатай дараахь зүйлийг нэмсүгэй:

1/ 12<sup>1</sup> дүгээр зүйл.

"12<sup>1</sup> дүгээр зүйл. Эрүүлжүүлэх, цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд тавих хяналт.

Прокурор дараахь ажиллагаанд хяналт тавина:

1/ эрүүлжүүлэх, цагдан хорих, баривчлах, албадан саатуулах шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуульд заасан үндэслэл, журмын дагуу явагдаж байгаа эсэх;

2/ эрүүлжүүлэх, цагдан хорих, баривчлах, албадан саатуулах, шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хуулиар тогтоосон нөхцөл, дэглэмд нийцэж байгаа эсэх.

3/ эрүүлжүүлэгдсэн, цагдан хоригдсон, баривчлагдсан, албадан саатуулагдсан этгээдийн хууль ёсны эрх, эрх чөлөө хангагдаж байгаа эсэх."

2/ 14<sup>1</sup> дүгээр зүйл.

"14<sup>1</sup> дүгээр зүйл. Гүйцэтгэх ажилд тавих прокурорын хяналт

1. Гэмт хэрэг, түүнийг үйлдсэн этгээдийг илрүүлэх зорилгоор эрх бүхий байгууллагаас явуулах гүйцэтгэх ажил хуулийн дагуу явагдаж байгаа эсэхэд прокурор хяналт тавина.

2. Гүйцэтгэх ажилд хяналт тавих прокурорын эрх хэмжээг хуулиар тогтооно.

Монгол Улсын Их Хурлын дарга

Н. БАГАБАНДИ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
• ТОГТООЛ**

1995 оны 12 дугаар  
сарын 4-ний өдөр

Дугаар 87

Улаанбаатар  
хот

**Монгол Улсад эдийн засгийн чөлөөт  
бүс байгуулах үзэл баримтлалын  
тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үзэл баримтлалыг баталсугай.

Дарга

**Н. БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСАД ЭДИЙН ЗАСГИЙН ЧӨЛӨӨТ  
БҮС БАЙГУУЛАХ ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

**НЭГ. ОРШИЛ**

1. Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах **ҮНДЭСЛЭЛ** нь:

1/ эдийн засгаа нээлттэй аргаар хөгжүүлэх зохион байгуулалтын нэг шинэ хэлбэр болсон эдийн засгийн чөлөөт бүсийг сонгон авч хэрэгжүүлж байгаа дэлхийн олон орны нийтлэг жишиг;

2/ манай орны тодорхой бүс нутагт хөрөнгө оруулэх эрмэлзлэл бүхий гадаадын хөрөнгө оруулагчдын сонирхлыг өөрийн орны эрх ашигтай зөв жослон, тухайн бүс нутгийн болон улс орны эдийн засгийн хөгжилд тус дөхөм үзүүлэх явдал гэж үзнэ.

2. Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах **ЗОРИЛГО** нь тус улсын нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийн байгаль орчин, хүн ам, түүхий эдийн нөөц, газар зүйн байрлал, зам харилцааны боломжийг зохисгой ашиглан, гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, дэвшилтэт технологи оруулах замаар эдийн засгийн чадавхийг дээшлүүлэхэд оршино.

3. Эдийн засгийн чөлөөт бүсийн үйл ажиллагаа нь дараахь журилтыг хангахад чиглэгдэнэ:

- Экспортын үйлдвэрлэл, импортын орлох бүтээгдэхүүнийг нэмэгдүүлэх;
- Удирдлагын болон үйлчилгээний орчин үеийн арга барил, маркетинг, худалдаа арилжааны туршлага нэвтрүүлэх;
- Хүн амын ажил эрхлэлтийг сайжруулах;
- Валютын чөлөөт хөрвөлтийг хангаж, нөөцийг нь нэмэгдүүлэх;
- Барааны хангамжийг сайжруулах.

### **ХОЁР. Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах онцлог, зарчим**

1. Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулах үндсэн агуулга нь бусад орныхтой зарчмын хувьд адил төстэй боловч улс орны эдийн засгийн одоогийн бодит байдал, нийгмийн тодорхой хэрэгцээ, шаардлага, газар зүйн байрлалаас шалтгаалан дараахь онцлогтой байна:

-Тус орны зах зээл нь хил залгаа ОХУ, БНХАУ-аас нэлээд хамааралтай.

-Газар зүйн байршлын хувьд гадаадын хөрөнгө оруулагчдаас алслагдсан;

-Нэн тэргүүнд Ази, Номхон далайн орнуудтай хамтран ажиллах боломж илүүтэй.

-Улс орны янз бүрийн бүс нутагт оршдог эрдэс баялгийн томоохон ордуудыг түшиглэн хөрөнгө оруулах хэрэгцээ, шаардлага өсч байгаа.

-Гадаад худалдааны бүтцийн хувьд машин, техник төхөөрөмж, сэлбэг, хэрэгсэл, өргөн хэрэгцээний бараа голлон импортоддог, экспортод мал аж ахуйн түүхий эд, мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн дийлэнх хувийг эзэлдэг.

2. Монгол Улс эдэлбэр газрын нөөц, эрдэс баялаг ихтэй, зах зээлийн багтаамж сайтай орнуудтай хил залгадаг давуу талтай боловч далайд гарцгүй, дэлхийн зах зээлийн гол төв, зангиуранаас хол, эрс тэс уур амьсгалтай, хүн ам цөөн, үйлдвэрлэл, нийгмийн дэд бүтэц харьцангуй сул хөгжсөн зэрэг эдийн засгийн чөлөөт бүс байгуулахад харгалзах нөхцөл байдал, бодит хүчин зүйл гэж үзнэ.

3. Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулахад дээр онцлог, нөхцөл байдал, бодит хүчин зүйлийг харгалзан үзэхийг хамт дараахь зарчмыг баримтална:

-Чөлөөт бүс байгуулах зохих шалгуурыг хангасан, харьцангуй бага зардал шаардах, илүү тохиромжтой нутаг дэвсгэрийг сонгон авах;

-Эдийн засгийн чөлөөт бүсийг үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээ

дагнасан ба хосолсон хэлбэрээр байгуулах;

-Эхний ээлжинд Буянт-Ухаагийн нисэх онгоцны буудал болон улсын хил орчим нутагт "Худалдааны чөлөөт бүс"-ийг энгийн хэлбэрээр бий болгож, зохих туршлага хуримтлуулсны үндсэн дээр эдийн засгийн чөлөөт бүсийг нутгийн гүнд үйлдвэрлэл, худалдаа хосолсон хэлбэрээр, үе шаттай хөгжүүлэх;

-Чөлөөт бүсэд гадаадын хөрөнгө оруулагчдад тааламжтай нөхцөл бүрдүүлж, дотоодын аж ахуйн нэгжүүдийг тэдгээртэй эдийн засгийн ижил орчинд өрсөлдөх нөхцөлөөр хангах;

### **ГУРАВ. Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах утгвар нөхцөл**

Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зорилтыг хангахын тулд эдийн засаг, зохион байгуулалтын дараахь утгвар нөхцөлийг бүрдүүлсэн байна:

-Олон улсын стандартад нийцсэн орчин үеийн холбоо, эрчим хүч, зам, тээвэр зэрэг үйлдвэрлэлийн болон нийгмийн дэд бүтэц шинээр бүрдүүлэх буюу сайжруулах;

-Чөлөөт бүс байгуулах эрх зүйн үндсийг бүрдүүлж, чөлөөт бүсийн хүрээнд гадаадын хөрөнгө оруулагчид, аж ахуйн нэгж, байгууллага чөлөөтэй, итгэл үнэмшилтэй ажиллах таатай орчин нөхцөл бий болгох;

-Гадаадын хөрөнгө оруулагчидтай харилцаа тогтоосон, чөлөөт бүсэд хөрөнгө оруулах баталгаатай, бизнесийн үйл ажиллагааг үр ашигтай явуулах чадвартай компаниуд бий болгох;

-Худалдаа, бизнесийн үйл ажиллагаанд мэргэшсэн буюу энэ төрлийн ажил хийх сонирхол, мэргэжлийн ур чадвар сайтай, үйлчилгээний өндөр соёл эзэмшсэн ажиллах хүч бий болгох;

-Чөлөөт худалдааны төв, гаалийн баталгаат агуулах, хил, гаалийн шалтан нэвтрүүлэх цогцолбор, үйлдвэртэлийн барилга байгууламж, банк, зочид буудал, үйлчилгээний бусад цэг салбар байгуулах талаар дотоод, гадаадын хөрөнгө оруулагчидтай гэрээ, хэлцэл хийсэн байх.

### **ДӨРӨВ. Чөлөөт бүс байгуулахад баримтлах шалгуур**

I. Эдийн засгийн чөлөөт бүс байгуулах нутаг дэвсгэрийг сонгоход дараахь шалгуурыг баримтална:

1/ Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын шаардлагад чанд нийцсэн байх;

2/ тээвэр-газар зүйн байрлалын хувьд гадаад худалдааны үйл

ажиллагаа явуулахад тохиромжтой байх;

3/ зохих чиглэлээр үйлдвэртэл, үйлчилгээ эрхэлж гадаадын зах зээлд гаргах боломж илүүтэй байх;

4/ үйлдвэртэл, нийгмийн зохих дэд бүтэц бүрдсэн буюу шинээр бүрдүүлэхэд дөхөмтэй байх;

5/ гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдын сонирхлыг татахуйц нөхцөл бүрдсэн байх;

2. Монгол Улсад эдийн засгийн чөлөөт бүс байгуулж хөгжүүлэх үйл ажиллагааг энэ үзэл баримтлалд дурасан зарчим, онцлог, бодит хүчин зүйл, утгвар нөхцөл, шалгуурыг үндэслэн сонгож авсан тодорхой бүсүүдийн статусыг тухай бүрт нь хуулиар тогтоон мөрдүүлэх замаар хэрэгжүүлнэ.

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар  
сарын 19-ний өдөр

Дугаар 89

Улаанбаатар  
хот

Нийгмийн халамжийн тухай хуулиуд,  
Ахмад настан түүнд үзүүлэх хөнгөлөлт,  
үйлчилгээний тухай болон Тахир дутуу  
хүний нийгмийн хамгаалалт, түүнд  
үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай  
хуулиудыг хэрэгжүүлэх зарим арга  
хэмжээний тухай

Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

1. Дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газарт даалгасугай:

1/ Нийгмийн халамжийн тухай хуулиуд, Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай болон Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулиудад Засгийн газраас батлан мөрдүүлэхээр тогтоосон дүрэм, журам, тэтгэмж, зардлын хэмжээг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний дотор батлан гаргах;

2/ Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт, халамжийн болон асрамжийн үйлчилгээ, ахмад настан, тахир дутуу хүний



нийгмийн хамгаалалтын хэрилцааг зохицуулах, норм, норматив тогтоох асуудлаар урьд гаргасан Засгийн газар /БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлд/, түүний байгууллагуудын шийдвэрийг 1996 оны 4 дүгээр сарын 1-ний дотор багтаан дээр дурдсан хуулиудад нийцүүлэх;

3/1996 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс өмнө нийгмийн халамжийн тэтгэвэр тогтоолгосон иргэдийн нийгмийн халамжийн тэтгэврийг 1996 оны 7 дугаар сарын 1-ний дотор багтааж шинэчлэн тогтоох;

4/ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, Тахир дутуу хүний нийгмийн хамгаалалт, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу ахмад настан, тахир дутуу хүмүүсийн санаачилгаар болон тэдгээрт зориулж төрөөс үүсгэн байгуулагдсан аж ахуйн нэгж, байгууллагад дэмжлэг үзүүлэх, алдагдлыг нь нөхөн санхүүжүүлэх асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд тухай бүр шийдвэрлэж байх;

5/Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу Нийгмийн халамжийн Үндэсний зөвлөлийг 1996 оны 1 дүгээр сард багтаан байгуулж ажиллуулах.

2 Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Нийгмийн бодлогын байнгын хороо /Б Дэмбэрэл/-нд даалгасутай.

Дэд дарга

Ж.ГОМБОЖАВ

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1996 оны 1 дүгээр  
сарын 2-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар  
хот

**10000 төгрөгийн дэвсгэртнийг  
хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд  
тооцож, гүйлгээнд гаргахыг  
зөвшөөрөх тухай**

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. "Мөнгөн тэмдэгтийн загвар, тодорхойлолт батлах, эрх олгох тухай" Монгол Улсын Их Хурлын 1994 оны 6 дугаар сарын 9-ний өдрийн 46 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн "10000 төгрөг"-ний

дэвсгэртийг Монгол Улсын хууль ёсны талбөрийн хэрэгсэлд тооцсугай.

2. Гүйлгээнд байх бэлэн мөнгөний дэвсгэртийн бүтцийг харгалзан Монгол Улсын Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн "10000 төгрөг"-ний дэвсгэртийг гүйлгээнд гаргахыг Монголбанк /Д. Моломжамц/-д зөвшөөрсүгэй.

Дарга

**Н. БАГАБАНДИ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1996 оны 1 дүгээр  
сарын 5-ны өдөр

Дугаар О3

Улаанбаатар  
хот

**Тогтоол хүчингүй болсонд  
тооцох тухай**

Улсын Их Хурлын тухай хуулийн 45<sup>1</sup> дүгээр зүйлийн 4 дэх хэсгийг үндэслэн **ТОГТООХ** нь:

<<Ж. Бямбажавыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилгох тухай>> Улсын Их Хурлын 1995 оны 12 дугаар сарын 8-ны өдрийн 84 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Дэд дарга

**Ж. ГОМБОЖАВ**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ТОГТООЛ**

1996 оны 1 дүгээр  
сарын 9-ний өдөр

Дугаар О4

Улаанбаатар  
хот

**Монголбанкны 1996 оны орлого,  
зарлагын төсвийг батлах тухай**

Монгол Улсын Их Хурлаас **ТОГТООХ** нь:

Монголбанкны 1996 оны орлогыг 4.657.800.0 мянган төгрөг зарлагыг 4.271.600.0 мянган төгрөг, үүнээс санхүүжих Монголбанкны төсөвт зардлыг 749.600.0 мянган төгрөгөөр тогтоож, түүний зүйл ангийг хавсралтаар баталсугай.

Дэд дарга

**Ж. ГОМБОЖАВ**

Улсын Их Хурлын 1996 оны 1  
дүгээр сарын 9-ний өдрийн  
04 дүгээр тогтоолын хавсралт

## МОНГОЛБАНКНЫ 1996 ОНЫ ТӨСӨВТ ЗАРДАЛ

/зүйл ангиар, мян. төг/

1. Ажилтнуудын цалин хөлс, шимтгэл:	113.800.0
1. Үндсэн цалин:	97.200.0
2. Нийгмийн даатгалын шимтгэлийн зарлага	13.600.0
3. Эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн зарлага	3.000.0
II. Бусад зардал	635.800.0
Үүнд:	
1. Алт хүргүүлэх, татах зардал	118.400.0
2. Мөнгөн тэмдэгт хэвлүүлэх, татах, хүргүүлэх зардал	65.000.0
3. Албан томилолтын зардал	55.000.0
4. Элдэв хорогдлын шимтгэл	48.000.0
5. Ашигласны зарлага /цахилгаан, халаалт, цэвэр ба бохир ус /	60.000.0
6. Цэрэгжүүлсэн харуул, аюулгүй байдлын зарлага	28.000.0
7. Харилцаа холбооны зарлага /Ройтерын талборт/	151.400.0
8. Авто хэрэгсэл, шатахуун болон тээврийн зарлага	10.000.0
9. Автоматжилтийн холбогдолтой зарлага	80.000.0
10. Бусад зардал	20.000.0
<b>ЗАРЛАГЫН ДҮН</b>	<b>749.600.0</b>

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1996 оны 1 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 11

Улаанбаатар  
хот

Г. Эрдэнээг элчин сайдаар  
томилгох тухай

Гүржавын Эрдэнээг Монгол Улсаас Бүгд Найрамдах Беларусь  
Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайдаар томилсугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН  
ЗАРЛИГ**

1996 оны 2 дугаар  
сарын 01-ний өдөр

Дугаар 14

Улаанбаатар  
хот

Монголын тулгар төрийг үндэслэн бай-  
гуулсны 790 жилийн ойг тэмдэглэх  
тухай

Монголын тулгар төрийг үндэслэн байгуулсны 790 жилийн ойг  
Монголын ардын хувьсгалын 75 жилийн ойн баярын өдрүүдэд орон  
даяар хамтатган ёслол тэмдэглэх нь зүйтэй гэж үзэж, үүнтэй  
холбогдсон зохион байгуулалтын арга хэмжээ авахыг Засгийн газарт  
чиглэл болгосугай.

Монгол Улсын Ерөнхийлөгч

**П. ОЧИРБАТ**

Монгол Улсын Ерөнхий сайд

**П. ЖАСРАЙ**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар  
сарын 21-ний өдөр

Дугаар 146

Улаанбаатар  
хот

**Зарим ахмад настны тэтгэвэр,  
тэтгэмжийг нэмэгдүүлэх, орон  
суун, түлээ нүүрсний үнийг  
хөнгөлөх тухай**

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Өндөр насны тэтгэвэр авдаг 70 ба түүнээс дээш насны иргэд болон өвчний улмаас байнга хэвтэрт асруулдаг тэтгэврээс өөр орлоггүй 60 ба түүнээс дээш насны эрэгтэй, 55 ба түүнээс дээш насны эмэгтэйчүүдийн "Тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 104 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлд заасны дагуу нэмэгдэх тэтгэврийг 1997 онд хүрсэн байвал зохих түвшингийн хэмжээгээр 1995 оны 12 дугаар сараас эхлэн олгох арга хэмжээ авахыг Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд Э. Гомбожав, Сангийн сайд Э. Бямбажав нарт заалгасугай.

2. Хүүхэд, ах дүү, төрөл садангаас нь асарч туслах бололцоогүй бөгөөд тэтгэврээс өөр орлогын эх үүсвэргүй тэтгэвэр авагч 65-аас дээш насны эрэгтэй, 60-аас дээш насны эмэгтэй, мөн нөхцөлд амьдардаг хөдөлмөрийн чадвараа бүрмөсөн алдсан тахир дутуугийн тэтгэвэр авагч (гэхдээ тэтгэвэр авагч 2 ба түүнээс дээш хүн нэг гэр бүлд амьдардаг бол аль нэгэнд нь)-ийн орон сууцанд байнга амьдардаг бол суушных нь талбай, халаалт, цэвэр бохир усны, гэрт амьдардаг бол жилд 4 шоо метр түлээ, 4 тонн нүүрсний үнийн тус тус 50 хувийг амьдрал ядуу, орлого багатай айл өрх, иргэдэд туслах сангаас тухайн иргэний харьяалагдах баг, хорооны ахмадын хэсгийн санал дүгнэлтийг үндэслэн уг баг, хорооны Засаг даргын шийдвэрээр олгож байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт заалгасугай.

3. Халх голын 1939 оны байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгаралтад эролцсон ахмад дайчдад хүүхэд, ах дүү, төрөл садангаас нь тэднийг асарч туслах бололцоотой эсэх, түүнчлэн тэтгэврээс өөр орлогын эх үүсвэртэй эсэхийг үз харгалзан энэ тогтоолын 2 дугаар зүйлд заасан сонгохдөлийг үзүүлж, шаардагдах зардлыг мөн зүйлд заасан эх үүс-

вэрээс гаргаж байсугай.

4. Халх голын 1939 оны байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн, тус улсын баруун хил дээр 1940-1948 онд болсон зэвсэгт тулгаралтад оролцсон ахмад дайчид, түүнчлэн дайнд оролцож яваад амь үрэгдэгсдийн бэлбэсэн эхнэр (нөхөр)-г жил бүр 5 мянган төгрөгний тэтгэмжийг 1996 оноос эхлэн олгож байхаар тогтоосугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Сайд нарын Зөвлөлийн 1986 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 24 дүгээр тогтоолоор батлагдсан "1939 оны Халх голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайнд оролцогчидод тэтгэмж олгох заавар"-ын 6 дугаар зүйл, "БНМАУ-ын баруун хил дээр зэвсэгт тулгаралтад оролцож байлдаж явсан ахмад дайчдын тэтгэмжийг нэмэгдүүлэх тухай" Сайд нарын Зөвлөлийн 1989 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 227 дугаар тогтоол, "Амьдрал ядуу, нэн бага орлоготой өрх иргэд болон ахмад дайчдын талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 7 дугаар сарын 23-ны өдрийн 123 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "а" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Хүн амын бодлого,  
хөдөлмөрийн сайд

Э. ГОМБОЖАВ

Сангийн сайд

Э. БЯМБАЖАВ

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар  
сарын 24-ний өдөр

Дугаар 150

Улаанбаатар  
хот \*

Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл  
мэндийн тусламжийг сайжруулах  
зарим арга хэмжээний тухай

Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн чанар, хүртээмжийг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион бай-

гуулалт, үйл ажиллагааны үндсэн чиглэл"-ийг хавсралтын дээр баталсугай.

2. Эрүүл мэндийн сайд П. Нямдаваад даалгах нь:

а/ хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг 1996 оноос эхлэн өрхийн эмчийн үйлчилгээний хэлбэрт тодорхой үе шаттайгаар шилжүүлэх зохион байгуулалтын арга хэмжээ авсугай;

б/ хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагын ерөнхий эмч, эрхлэгч нарыг 1996-1998 онд багтаан эрүүл мэндийн удирдлага, эдийн засгийн сургалтад бүрэн хамруулсугай.

3. Хөдөөгийн хүн эмнэлгийг түргэн тусламжийн машинаар хангах асуудлыг 1996 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн аймгийн Засаг дарга нарт хариуцуулсугай.

Үүнтэй холбогдуулан хөдөөгийн хүн эмнэлгийг түргэн тусламжийн машинаар хангахад шаардагдах зардалыг тухайн орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлж байхыг аймаг, сумын Засаг дарга нарт даалгасугай.

4. Сумдын хүн эмнэлгийн эмчилгээ, үйлчилгээг шуурхай болгон эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх чиглэл боловсруулж, боловцоотой зарим сумын эмнэлгийг хувьчлах ажлыг 1996-1997 онд туршилтын журмаар хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газрын Өмч хувьчлалын комисс /Л. ЭНЭБИШ/, Эрүүл мэндийн яам /П. НЯМДАВАА/-д даалгасугай.

5. Дорноговь аймаг дахь Анагаах ухааны коллеж, Говь-алтай, Дархан-уул аймаг дахь Анагаах ухааны дунд сургуулийг тухайн аймгуудын нэгдсэн эмнэлэгтэй тус тус нэгтгэн Анагаах ухааны төвүүд болгон өөрчлөн зохион байгуулж, хүн амд эмнэлгийн төрөлжсөн, нарийн мэргэжлийн тусламж үзүүлэх, анагаах ухааны мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, эрдэм шинжилгээний ажлыг хослон гүйцэтгэх чиглэлээр ажиллуулахыг Эрүүл мэндийн яам /П. НЯМДАВАА/, Шинжлэх ухаан, боловсролын яам /С. ТӨМӨР-ОЧИР/, Дорноговь, Говь-алтай, Дархан-уул аймгуудын Засаг дарга /Л. ОДОНЧИМЭД, Р. ЦОГТБААТАР, Л. АМАРСАНАА/-д даалгасугай.

6. Хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн хүртээмж, чанарыг бодитой сайжруулахад чиглэгдсэн дор дурдсан арга хэмжээнүүдийг Олон улсын байгууллага, гадаад орнуудын туслалцаатайгаар 1996 оноос эхлэн үе шаттайгаар авч хэрэгжүүлэхийг Үндэсний хөгжлийн газар (Ч. УЛААН), Эрүүл мэндийн яам (П. НЯМДАВАА), Дэд бүтцийн хөгжлийн яам (Р. САНДАЛХАН), Эрчим хүч, геологи, уул уурхайн яам (Б. ЖИГЖИД), Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам (Э. ГОМБОЖАВ), аймгийн Засаг дарга нарт даалга-

сугай:

а/ багийн бага эмчийн салбарыг эмнэлгийн зохих шаардлагыг хангасан ажлын байртай, сумын эмнэлэгтэй богино долгионы радио холбоогоор харилцах боломжтой болгох;

б/ хөдөөгийн хүн эмнэлгийн үйл ажиллагааны санхүүжилтийн байдлыг сайжруулах зорилгоор сумын эмнэлгийг 200,0-300,0 мянга, багийн бага эмчийн салбарыг 40,0-60,0 мянган төгрөгт багтаан "Эрүүл мэндийн эргэлтийн сан"-тай болгож, нэн шаардлагатай эм, эмнэлгийн бараагаар тасралтгүй хангах;

в/ аймгийн төвөөс алслагдсан, эрчим хүчний төвлөрсөн системд холбогдоогүй 2-3 сумыг аймаг бүрээс сонгон авч нар, салхи, усны хүчийг ашиглан эрчим хүчээр найдвартай хангах;

г/ Хова, Дорнод аймгийн төлд аймаг дундын оношлогоо-эмчилгээний төв байгуулж, иргэдэд эмнэлгийн нарийн мэргэжлийн яаралтай тусламж үзүүлэх, түргэн тусламжийн холбоо, тээврийн хэрэгслээр хөрөнгө оруулалтын дунд хугацааны хөтөлбөрт тусгах замаар хангах;

д/ эхчүүдийн амрах байрыг сэргээх, үйлчилгээг сайжруулах, тогтмол ажиллагаатай болгоход тусалцаа үзүүлдэг байх;

е/ багийн бага эмч нарыг шаардагдах эм, эмнэлгийн багаж хэрэгслээр хангах, тэнд ажиллах эрүүл мэндийн сайн дурын туслагч нарыг бэлтгэх.

7. Хүн амын өсөлт, эмнэлгийн байршил зэрэгтэй уялдан төлөвлөлтийн үндэслэл болох хөдөөгийн хүн эмнэлгийн хүч чадал, орон тоо, эрүүл мэндийн байгууллагын зэрэглэлийн нормативыг Сангийн яамтай тохиролцон баталж мөрдүүлэхийг Эрүүл мэндийн яам /П. НЯМДАВАА/, Хүн амын бодлого, хөдөлмөрийн яам /Э. ГОМ-БОЖАВ/-д үүрэг болгосугай.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөдөөгийн хүн амын эрүүл мэндийг хамгаалах ажлыг сайжруулах тухай" БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1990 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 10 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Эрүүл мэндийн сайд

П. НЯМДАВАА



Засгийн газрын 1995 оны 150 дугаар  
тогтоолын хавсралт

## ХӨДӨӨГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГЫН БҮ- ТЭЦ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

### Нэг. Нийтлэг үндэслэл

Хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагад аймгийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв, сумын эмнэлэг, багийн бага эмгийн салбар хамаарна.

Эдгээр нь дэвсгэр нутгийн хүн амын тодорхой бүлэг /хамтлаг/, гэр бүл, хувь хүмүүсийн эрүүл мэндийг хамгаалах зорилтуудыг шийдвэртэхэд гол үүрэг гүйцэтгэж, хүн амын өвчлөлд илүү өртөмтгий болон ядуу зүдүү бүлэг, эх, хүүхэд нэг бүрийг илүү анхаарч ажиллана.

Хүн амын өвчлөлд илүү өртөмтгий бүлэгт жирэмслэх насны эмэгтэйчүүд, 5 хүртэлх насны хүүхэд, өсвөр үе, асрамжийн хүмүүс, өндөр настан багтана.

Гэр бүлийн эрүүл мэндийг хамгаалах зорилтуудад эх хүүхдийн эрүүл мэнд, ундны ус, хоол хүнс, вакцинжуулалтын хүрэлцээ, хангамж, хадгалалт, тээвэрлэлт, орны эрүүл ахуй, залуу гэр бүлийг амьдралд сургах, эрүүл мэндийн боловсрол болон өөртөө үйлчлэх мэдлэг олгох зэрэг эрүүл мэндийн анхны тусламжтай холбоотой асуудлууд хамаарна.

Тодорхой бүлэг /хамтлаг/-ийн эрүүл мэндийг хамгаалах зорилтуудад салбар дундын хамтын ажиллагааг сайжруулах, хүн амын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлэх, харилцаа холбоо, тээврийн хэрэгсэл, эм, хоол хүнс, цэвэр усар хангах, удирдах ажилтнуудыг сургах, эрүүл мэндийн сургалт явуулах, өвчлөлийн байдалд хяналт тавих, эрүүл мэндийг сахин хамгаалахад нийтгэм, хамт олны хүчийг дайчлах, тухайн орон нутгийн онцлогоор эмнэлгийн мэргэжлийн тусламжийн хэрэгцээг тодорхойлох, хүн амын бие бялдрыг чийрэгжүүлэх зэрэг асуудал хамаарна. Хөдөөгийн эрүүл мэндийн байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгож, ажлын чанарыг сайжруулснаар хөдөөгийн хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийн чанар дээшилж, Дэлхийн эрүүл мэндийн байгууллагаас "Бүх нийтээр эрүүл байх" талаар дэвшүүлсэн зорилт биелж, өвчлөл, нас баралт буурч, эрүүл мэндийн байдалын түвшний алтаа арилах үндсэн нөхцөл бүрдэнэ.

Дэлхий дахины чиг хандлага, өөрийн орны өвөрмөц нөхцөл бай-

далд зохицсон зохион байгуулалттай байх нь боловсон хүчнийг төлөвлөх, эрүүд мэндийн анхны болон эмнэлгийн төрөлжсөн нарийн мэргэжлийн тусламжийг хөгжүүлэх бодлогын үндэс болно.

### **Хоёр. Аймгийн нийгмийн эрүүд мэндийн төвийн бүтэц, зохион байгуулалт**

Аймгийн нийгмийн эрүүд мэндийн төв нь тухайн аймгийн нутаг дэвсгэр дээр нийгмийн эрүүд мэндийн арга хэмжээг зохион байгуулан хэрэгжүүлэх, хүн амын эрүүд мэнд, өвчлөлийн байдалд судалгаа хийж, дүгнэлт гаргах, эрүүд ахуй, халдвар судлалын хяналт тавих, аймгийн төвийн хүн амд эрүүд мэндийн анхан шатны тусламж үзүүлэх үндсэн чиг үүрэг бүхий мэргэжлийн байгууллага мөн.

Нийгмийн эрүүд мэндийн төвийг эрүүд ахуй, халдвар судлалын хяналтын байгалийн голомтот халдварын, эрүүд мэндийн сургалт-чигрэгжүүлэлтийн, сүрьеэ, арьс өнгө, халдварт, ариутгал-халдвар-гүйтлийн, статистик-мэдээллийн, өрхийн эмчийн тусламжийн чиглэлээр эмнэлэг, үйлчилгээ, хяналт шалгалт явуулах хүч чадалтай байхаар зохион байгуулна.

Аймгийн Засаг даргын Тамгын газраас томилогдсон захирал нийгмийн эрүүд мэндийн төвийг удирдана. Нийгмийн эрүүд мэндийн төвийн өдөр тутмын үйл ажиллагааг Засаг даргын Тамгын газраас баталсан дүрэм, Эрүүд ахуй, халдвар судлалын хяналтын дүрэм болон байгууллагын дотоод журмаар зохицуулна.

### **Гурав. Аймгийн нэгдсэн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалт**

Аймгийн нэгдсэн эмнэлэг нь тухайн аймгийн дэвсгэр нутаг дахь хүн амд эмнэлгийн тусламж үзүүлж, сумын эмнэлгийг мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангах, асрагч, сувилагч бэлтгэх болон эмч, эмнэлгийн дунд мэргэжилтний мэргэшил, дадлагыг дээшлүүлэх үндсэн чиг үүрэг бүхий эмнэлгийн тусламжийн 3 дахь шатлалын байгууллага мөн.

Нэгдсэн эмнэлэг нь дотор, мэс засал, гэмтэл, нүд, чих, хамар хоолой, шүд болон сүрьеэ, арьс өнгө, ДОХ, халдварт, мэдрэл-сэтгэцийн эмгэг, эх барих эмэгтэйчүүд, хүүхдийн болон уламжлалт эмнэлгийн чиглэлээр стационар, поликлиникийн тусламж үзүүлэх хүч чадалтай, үүнтэйгээ уялдсан оношлогоо, нөхөн сэргээх, эмгэг анатомн, шүүх эмнэлэг зэрэг туслах кабинетуудтай байна.

Аймгийн нэгдсэн эмнэлгийг аймгийн Засаг даргын Тамгын газраас томигдсон ерөнхий эмч удирдана.

Тасаг, кабинетийн хүч чадлыг хүн амын өвчлөлийн бүтэц, онцлогтой уялдуулан эмнэлгийн захиргаа тогтооно.

Аймгийн нэгдсэн эмнэлгийн өлөр тутмын үйл ажиллагааг Засаг даргын Тамгын газраас баталсан дүрэм болон байгууллагын дотоод журмаар зохицуулна.

**Дөрөв. Аймгийн нийгмийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн хоорондох ажлын уялдаа холбоо**

Аймгийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв нь үйл ажиллагаагаа дор дурасанаар харилцан уялдаатай явуулна:

1/ нэгдсэн эмнэлэг нь төрөлжсөн нарийн мэргэжлээр стационарын бүх тусламжийг хариуцахын хувьд нийгмийн эрүүл мэндийн төвийн эмч нараас хэвтүүдэж эмчлүүлэхээр илгээсэн өвчтнийг хүлээн авна.

2/ нэгдсэн эмнэлгийн поликлиникт нийгмийн эрүүл мэндийн төвөөс үзүүрж шинжилгүүлэх, зөвлөлгөө авах, эмчилгээ хийлгэхээр илгээсэн хүмүүсийг зохих журам, дарааллаар нь үйлчилнэ.

3/ хоёр байгууллагын эмч нарын заалтаар хийгдэх клиник, биохимийн ба патогистологийн шинжилгээг нэгдсэн эмнэлгийн лабораториудад, бактериологи, серологи, химийн шинжилгээг нийгмийн эрүүл мэндийн төвийн лабораториудад тус тус төрөлжүүлэн хийнэ.

4/ төв, хөдөөгийн түргэн тусламжийн дуудлагыг нэгдсэн эмнэлэг дээр төвлөрүүлэх, хоёр байгууллагын эмч нараас дуудлагад томилж явуулах, жижүүрийн эмчээр ажиллуулах асуудлыг нэгдсэн эмнэлгийн захиргаа нийгмийн эрүүл мэндийн төвийн удирдлагатай зөвшилцсөн үндсэн дээр зохицуулна.

5/ нийгмийн эрүүл мэндийн төв, нэгдсэн эмнэлгийн эмч нар дангаар буюу хамтран сумдын хүн амд газар дээр нь нарийн мэргэжлийн тусламж үзүүлдэх, зөвлөлгөө өгөх, урьдчилан сэргийлэх үзлэг шинжилгээ явуулах ажлыг гүйцэтгэнэ.

6/ нийгмийн эрүүл мэндийн төвийн статистик-мэдээллийн алба аймгийн хэмжээний эрүүл мэндийн холбогдолтой бүх талын мэдээг нэгтгэх, дүн шинжилгээ хийх, холбогдох газруудад мэдээлэх ажлыг төвлөрүүлж хариуцах ба нэгдсэн эмнэлгийн захиргаа өөрийн байгууллагын үйл ажиллагааны талаархи тайлан мэдээг хутагаанд нь тус албанд гарган өгч байна.

7/ аймгийн хүн амын дунд тодорхой өвчин, эмгэгээр эмнэлгийн идэвхтэй хяналт тогтоох ажлыг нийгмийн эрүүл мэндийн төвийн сүрьеэ, арьс өнгө, халдварт ба өрхийн эмч нар болон нэгдсэн эмнэлгийн поликлиникийн холбогдох мэргэжлийн кабинетийн эмч

нар өөр өөрсдийн мэргэжлийн чиглэлээр хариуцан гүйцэтгэнэ.

Нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төв нь эрүүл мэндийн хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтран ажиллах, харилцан дэмжих, шударгаар өрсөлдөх зарчмыг баримталж ажиллана.

### Тав. Сумын хүн эмнэлгийн зохион байгуулалт

Сумын хүн эмнэлэг нь засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тодорхой нэгжийн хүн ам, газар нутгийг хамран үйлчлэх эрүүл мэндийн анхан шатны тусламжид суурилсан үндэсний эрүүл мэндийн системийн шинж чанарыг өөртөө ямар нэг хэмжээгээр агуулсан эмнэлгийн тусламжийн 2 дахь шатлалын байгууллага мөн.

Сумын хүн эмнэлэг нь аймгийн нэгдсэн эмнэлгээс мэргэжлийн удирдлага, арга зүйгээр хангагдана.

Сумын хүн амын эрүүл мэндийг хамгаалах зорилтуудыг шийдвэрлэх, зохицуулахад туслах зорилгоор олон нийтийн үүсгэл санаачилгаар "Сумын эрүүл мэндийн зөвлөл"-ийг байгуулж ажиллана. Түүнийг санаачлагч нь сумын Засаг даргын Тамгын газар, сумын хүн эмнэлэг байна. Сумын эрүүл мэндийн зөвлөлийн дарга нь сумын Засаг даргын орлогч байх бөгөөд дор дурдсан бүрэлдэхүүнтэй байна:

- сумын хөдөлмөрчдөөс сонгогдсон нэг буюу хэд хэдэн төлөөлөгч;
- сумын хүн эмнэлгийн эрхлэгч буюу ерөнхий эмч;
- сумын хүн эмнэлгийн бага эмч буюу ахлах сувилагч;
- эмнэлгийн үйлчилгээнд туслах Засгийн газрын бус олон нийтийн байгууллагын төлөөлөгч;
- ажил төрлийн хувьд шууд холбогдох засаг захиргааны байгууллагын эрх мэдэл бүхий төлөөлөгч /Засаг даргын Тамгын газрын ажилтан/.

Зөвлөл нь дараахь ажлыг хийж гүйцэтгэнэ:

1/ эрүүл мэндийн зорилтуудыг шийдвэрлэхэд оролцогч байгууллагуудын үйл ажиллагааг зохицуулах, эх, хүүхэд, ядуу зүүдүү болон өвчлөлд илүү өртөмтгий бүлгийн эрүүл мэндийг хамгаалахад олон нийтийн хүчийг чиглүүлэх;

2/ эрүүл мэндийн үйл хэрэгт зориулагдсан төсөв хөрөнгө, байгууллага, хүмүүсээс хандивласан тусламжийг зориулалтын дагуу зарцуулж буй эсэхэд хяналт тавих;

3/ эрүүл мэндийн үйл ажиллагааны үзүүлэлт, эмнэлгийн тайлан тэнцээд дүн шинжилгээ хийж, эрүүл мэндийн бодлого, хөтөлбөрийн биелэлтэд хяналт тавих, холбогдох саналаа зохих шатны төр захиргааны байгууллагад оруулах;

4/ хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг судалж шаардлагатай арга хэмжээг төлөөлөж хэрэгжүүлэх;

5/ эмнэлгийн үйл ажиллагааг төлөвлөх, удирдахад хүн хүү, санхүү, материал техникийн нөөц бололцоог дайчлах ажлыг зохицуулах;

6/ эрүүл мэндийн анхан шатны тусламжийг хэрэгжүүлэхэд чиглэсэн арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах;

7/ хүн амыг эмээр хангах, эмнэлгийн хоол хүнс, материалын хангамжийг сайжруулах арга хэмжээ алах;

Эмнэлгийн тусламжийн хөгжлийн уламжлал болон хүн амын нягтрал, байршил, газар нутгийн байдал үйлчлэх хүрээ, зам тээвэр, холбоо харилцааны хөгжил зэрэг нөхцлийг харгалзан суманд хэвтүүлж эмчлэх /стационар/, амбулаториор үйлчлэх гэсэн эмнэлгийн тусламжийн хоёр төрлөөр оношлогоо, эмчилгээ, үйлчилгээ, нөхөн сэргээх үйл ажиллагааг өрхийн тогтолцоогоор явуулна. Хэвтүүлж эмчлэх орыг хүүхэд, дотор төрөх, халдварт гэсэн ангиллаар зохион байгуулах бөгөөд өрхийн эмч өөрийн хариуцсан өрхийнхөө хүнийг эмчлэх зарчим баримтална. Эмнэлгийн байгууллагын эдийн засгийн үр өгөөжийг харгалзан рентген, клиник, биохимийн лабораторийн болон бусад багажийн оношлогоог сумын эмчээр хийлгэхээр зохион байгуулж үүний тулд сумын эмчийг нарийн мэргэжлээр давхар мэргэшүүлэх, зүрхний цахилгаан бичлэг, клиник шинжилгээг өрхийн эмч нараар хийлгэхээр бэлтгэж сургана.

Сумын хүн эмнэлгийн эмч, мэргэжилтэн дараахь чиглэлийн ажил үүргийг хариуцна:

1/ эмнэлгийн эрхлэгч буюу ерөнхий эмч нь сумын хэмжээнд эрүүл мэндийн үйлчилгээ, эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын ажлыг зохион байгуулах;

2/ өрхийн эмч нь харьяалах хүн амаа үзэж, стационарт хэвтэж буй өвчтөнөө өөрсдөө үзэж эмчлэх;

3/ төрөх эмэгтэйчүүдийн тусламжийг мээ засал-эмэгтэйчүүдийн эмч, ийм эмчгүй бол ерөнхий эмч шууд хариуцах;

4/ мээ засал-эмэгтэйчүүдийн эмч нар стационар, амбулаторид, шүдний эмч зөвхөн амбулаторид ажиллах.

Сумын хүн эмнэлэгт эмийн бус, нөхөн сэргээх, физик, биенийн гамирын болон зүү төөнүүр, илгэг зэрэг ардын уламжлалт эмчилгээг хөгжүүлэх чиглэл баримтална.

Эхчүүдийн амрах байрыг сумын эмнэлгийн орны фондод багтаан зохион байгуулж, үйл ажиллагааг нь төсвөөс санхүүжүүлнэ. Сумын эмнэлгийн үйл ажиллагааг сумын Засаг даргын Тамгын газраас багалсан дүрэм, дотоод журмаар зохицуулна.

#### **Зургаа. Багийн бага эмчийн салбарын чиг үүрэг**

Багийн бага эмчийн салбар нь сумын эмнэлгийн бүтцэд багтсан, өрхийн эмчийн тогтолцооны салшгүй нэг хэсэг бөгөөд дэвсгэрийн

хүн амд эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлдэг эмнэлгийн тусламжийн анхдагч нэгж мөн.

Баг бүрт бага эмч буюу эмнэлгийн дунд мэргэжлийн сувилагч /дипломтай/, түүний шууд удирдлага дор эрүүл мэндийн сайн дурын туслагч нар ажиллана. Багийн бага эмч нь багийн Засаг даргын шууд удирдлагын дор ажиллана. Харин сумын хүн эмнэлгийн эрхлэгч, их эмч багийн эмчийг мэргэжлийн чиглэлээр удирдаж, мэргэжил мэдлэгийг нь системтэй дээшлүүлэх арга хэмжээ авна. Багийн зөвлөл нь багийн бага эмчийг тогтвор суурьшилтай ажиллуулах бололцоо нөхцөлөөр хангах, үзлэг-үйлчилгээгээ явуулах байр, дуудлага, эргэлт үзлэгээр явж үйлчлэх унаа хөсөг /морь эсвэл мотоцикл/-өөр хангах асуудлыг шийдвэртэн зохицуулна.

Багийн бага эмчийн салбарт ортой байх эсэх тухай асуудлыг аймгийн Засаг даргын Тамгын газраас зөвлөмж болгосны дагуу тухайн орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага шийдвэрлэнэ.

Багийн бага эмч дараахь үндсэн үүрэг хүлээнэ:

1/ нутаг дэвсгэрийн хүн амд дуудлага болон идэвхтэй эргэлт үзлэгээр явж эрүүл мэндийн анхан шатны тусламж үзүүлэх;

2/ өндөр настан, архаг өвчтэй хүмүүс, 0-5 насны хүүхэд, жирэмсэн эхчүүдэд давхар хяналт тогтоож, жирэмсэн эх бүрийг сумын эмнэлгийн төрөх тасагт төрүүлэх;

3/ нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг хэрэгжүүлэх талаар гаргасан хууль, тогтоомж, хөтөлбөрүүдийг багийн хөдөлмөрчдөд сурталчлах, хэрэгжүүлэх ажилд оролцох;

4/ багийн хүн амыг элдэв өвчлөлөөс урьдчилан сэргийлэх арга, далалд сургах;

5/ удирдлагадаа ажиллаж буй эрүүл мэндийн сайн дурын туслагч нарын ажилд хяналт тавьж, тэднийг дадлагажуулахад тусламж дэмжлэг үзүүлэх.

#### Долоо. Эрүүл мэндийн сайн дурын туслагч

Эрүүл мэндийн сайн дурын туслагч нь эрүүл мэндээ хамгаалах үйл хэрэгт олон нийтийн оролцоог илэрхийлэх бөгөөд бие хүний хувьд буяны үйлс бүтээж буй явдал юм.

Эрүүл мэндийн сайн дурын туслагч нь 10-15 өрхийн дунд нэг хүн байх нь зохимжтой бөгөөд хэнийг ажиллуулахаа тэдгээр өрх, хот айлын иргэд шийдэж саналаа сумын эрүүл мэндийн зөвлөлд ирүүлнэ.

Эрүүл мэндийн сайн дурын туслагч нарыг өрхийн эмч мэргэжлийн удирдлагаар хангах бөгөөд багийн бага эмч, өрхийн сувилагч нарт тэдгээрийг хуваарилан хариуцуулна.

Эрүүд мэндийн сайн дурын туслагч нар дараахь ажлыг гүйцэтгэнэ:

а/ зонхилон тохиолдох зарим өвчний үед анхны тусламж үзүүлэх;

б/ нэн шаардлагатай эмийг эмчийн заавраар хөдөлмөрдөд түгээх;

в/ жирэмсэн эхчүүдийг эмчийн хяналтад зохих хугацаанд нь оруулах, эмнэлэгт үзүүлэхэд тусалцаа үзүүлэх, хэрэв хүндрэлийн анхны тэмдэг илэрвэл эмчид мэдээлэх;

г/ бага насны хүүхдийг асрах, хооллох талаар эцэг, эхчүүдэд зөвлөлтөө өгөх;

д/ хүүхдийг бор хоолонд оруулах аргад эцэг эхчүүдийг сургах;

е/ хүүхдийн жинг тогтмол хянаж эмч нарт мэдээлэх;

ж/ товлолын дагуу урьдчилан сэргийлэх тарилгад хүүхдийг хамруулах, тарилгын дараа хүүхдийн биеийн байдалд хяналт тавих;

з/ гэр бүл төлөвлөлтийн талаар сурталчлах, зөвлөлтөө өгөх;

и/ орчны ариун цэвэр, уух ус, хоол ундны бүтээгдэхүүний эрүүл ахуйн болон хүн амыг чийрэгжүүлэхийн ач тус, архи тамхины хор холбогдлын талаар хүн амд эрүүл мэндийн сургалт явуулах, ариун цэврийн дадат заншил эзэмшүүлэх;

к/ халдварт өвчин гарсан тухай бүрд мэдээлэх, голомтыг илрүүлэхэд эмчид туслах;

л/ эмч дуудах, өвчтөнг эмнэлэгт яаралтай хүргэх тохиолдолд хэл хүргэх, зөөвөртөх унааны асуудлыг урьдчилан төлөвлөж уг ажлыг тухайн үед нь шуурхай зохицуулах.

Эрүүд мэндийн сайн дурын туслагч нарыг 21 хүртэл хоногийн сургалтаар бэлтгэж жил бүр 7 хүртэл хоногийн сургалт, семинарт зохион байгуулалттайгаар хамруулж тэдний мэдлэгийг дээшлүүлнэ. Эрүүд мэндийн сайн дурын туслагч нарын сургалтыг сумын төвд явуулна. Сургалтыг хөтлөн явуулах багш нарыг сумын эмч нараас сонгон тусгай хөтөлбөрөөр аймгийн нэгдсэн эмнэлэг, нийгмийн эрүүл мэндийн төвд бэлтгэнэ.

Сургалтын төсөв, зардлыг сумын Засаг даргын Тамгын газар сариуцна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар  
сарын 25-ны өдөр

Дугаар 156

Улаанбаатар  
хот

### Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хуулиу- дыг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого болон "Боловсролын тухай хуулиуд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 1995 оны 37 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. Шинжлэх ухаан, боловсролын яам /С. ТӨМӨР-ОЧИР/-д даалгах нь:

а/ Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, "Боловсролын тухай", "Бага дунд боловсролын тухай", "Дээд боловсролын тухай" Монгол Улсын хуулиудыг дагаж мөрдөхтэй холбогдон баримт бичгийг 1995 оны 11 дүгээр сард багтаан боловсруулж шийдвэрлүүлэх арга хэмжээ авсугай;

б/ төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хуулиудыг хэрэгжүүлэх ажлын чиглэл, төлөвлөгөө 1995 оны 9 дүгээр сард багтаан гаргаж хэрэгжүүлэх арга хэмжээ авч ажиллахын хамтаар эдгээр бодлого, хуулиудыг боловсролын салбарын багш, сурган хүмүүжүүлэгчид болон бусад ажиллагчдад сурталчлах ажлыг эрчимтэй зохион байгуулсугай;

в/ хүүхдийн цэцэрлэг, бүх шатны сургуулийг 1995-1996 оны хичээлийн жилийн 1 улиралд багтаан зэрэглэн улсын бүртгэлд бүртгэх, гэрчилгээжүүлэхийн хамтаар багш, сурган хүмүүжүүлэгчдийг шалгаруулалтад хамруулж тэдний ажлыг үнэлж, мэргэшлийн зэрэг болон ур чадварыг тогтоох, тэдэнд мэргэшлийн зэргийн болон ур чадварын нэмэгдлийг холбогдох хууль тогтоомжийн дагуу олгож байх зохион байгуулалтын арга хэмжээ авсугай;

г/ мэргэжлийн боловсролын сургалтын агуулгыг 1996-1998 онд багтаан кредит цагийн хэмжээгээр ялгагдах боловсролын зэрэглэлтэй мэргэжилтэн бэлтгэх аргачиллын дагуу өөрчилсүгэй;

д/ боловсролын стандартыг боловсролын тухай хуулиудтай нийцүүлж 1996 оны эхний хагаст багтаан шинэчлэн боловсруулж батлуулах арга хэмжээ авсугай.



2. Ерөнхий боловсролын сургуулийг тойргийн журмаар зохистой байршуулах, анги дүүргэлт хангалтгүй сургуулиудын шатлалыг бууруулах замаар хөрөнгө, зардал хэмнэх талаар Шинжлэх ухаан, боловсролын яамнаас боловсруулсан саналыг зарчмын хувьд зүйтэй гэж үзэж, ерөнхий боловсролын 10 жилийн дунд сургуулийг 1995-1996 оны хичээлийн жилээс эхлэн тус яамны саналын дагуу байршуулан зохион байгуулахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасутай.

3. Нэг суралцагчид бага, дунд боловсрол эзэмшүүлэхэд ногдох зардлын норматив, дээд боловсролын сургалтын хөтөлбөрийг эзэмшүүлэхэд шаардагдах зардлын хэмжээг 1995 оны 11 дүгээр сард багтаан тогтоохыг Шинжлэх ухаан, боловсролын яам /С. ТӨМӨР-ОЧИР/, Сангийн яам /Э. БЯМБАЖАВ/-д даалгасутай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Шинжлэх ухаан, боловсролын сайд

С. ТӨМӨР-ОЧИР

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар  
сарын 28-ны өдөр

Дугаар 157

Улаанбаатар  
хот

Дүрэм, журам, үнэмлэх, тэмдгийн  
тодорхойлолт батлах тухай

"Төрийн хяналт шалгалтын тухай хууль"-ийн 17 дугаар зүйлийн 3, 21 дүгээр зүйлийн 7 дугаар, Монгол Улсын Их Хурлын 1995 оны 25 дугаар тогтоолын 2 дугаар заалтуудыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих төрийн захиргааны хяналтын дүрэм"-ийг 1 дүгээр, "Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүн, биелэлтийг дүгнэх, мэдээлэх нэгдсэн журам"-ыг 2 дугаар, "Монгол Улсын захиргааны хяналтын улсын байцаагчийн тэмдэг, үнэмлэхийн тодорхойлолт"-ыг 3 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1993 оны 8 дугаар сарын 4-ний өдрийн 125 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд

Д. ЭНЭБИШ

Засгийн газрын 1995 оны 157 дугаар  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ, ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТЭД ТАВИХ ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ХЯНАЛТЫН ДҮРЭМ**

1. Монгол Улсын хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтэд тавих төрийн захиргааны хяналтын зорилт нь холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг шалгаж биелэлтийг хангуулах, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, сахилга, дэг журмыг бэхжүүлэх, захиргааны хяналтын байгууллагуудын харилцан ажиллагааг нийтлэг зорилгод чиглүүлэн уялдуулан зохицуулахад оршино.

2. Монгол Улсын сайд, Засгийн газрын үндсэн ба дэд бүтцэд ордог тусгай газрын дарга нар хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын болон өөрийн шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг эрхэлсэн үйл ажиллагааны хүрээнд хамаарах салбар, харьяа төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, өөрийн аппаратын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг Засгийн газраас тогтоосон журмын дагуу мэдээлэх ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

Монгол Улсын сайд, тусгай газрын дарга нарын эрхэлсэн үйл ажиллагааны хүрээнд хийгдэх захиргааны хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, албаны дүрмийг Засгийн газраас баталж мөрдүүлнэ.

3. Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газар, түүний байгууллагын шийдвэр, дээд шатны Засаг даргын захирамж болон Хурлын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх, биелэлтийг хянан шалгах ажлыг нутаг дэвсгэртээ оршдог төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, өөрийн аппаратын хэмжээнд зохион байгуулж, биелэлтийг Засгийн газраас тогтоосон жур-

мын дагуу холбогдох дээд шатны байгууллагад мэдээлэх ажлыг эрхлэн гүйцэтгэнэ.

4. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явцыг хянан шалгах, үр дүнг тооцох ажлыг улсын хэмжээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, түүний бүтцийн нэгж (шашид "Хэрэг эрхлэх газар" гэнэ) эрхлэн гүйцэтгэнэ.

5. Хэрэг эрхлэх газар нь энэ дүрмийн 4-т заасан үүргийг хэрэгжүүлэхдээ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, бусад хууль тогтоомжийн акт хийгээд Засгийн газраас баталсан тус газрын дүрэм болон энэ дүрмийг үйл ажиллагаандаа удирдлага болгоно.

6. Хэрэг эрхлэх газрын төрийн захиргааны хяналт хариуцах ажилтнууд нь "албан шаардлага" гэсэн хэвлэмэл хуудас, тогтоосон журмаар хийсэн хувийн дугаар бүхий тэмдэг хэрэглэнэ.

7. Хэрэг эрхлэх газар захиргааны хяналтын талаар дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ.

а) хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн харьяа төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид хянан шалгах, гүйцэтгэлийг нь хангуулах, Засгийн газрын шийдвэрийн гүйцэтгэлд техник хяналт тавьж, үр дүнг нэгтгэн тодорхойлж, Засгийн газрын хуралдаанд оруулах;

б) Ерөнхий сайд, Засгийн газрын даалгавраар аймаг, нийслэлийн Засаг дарга нар бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгааг шалган илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

в) Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 5 дахь заалтыг үндэслэн нам, олон нийтийн байгууллага, хувийн өмчийн аж ахуйн нэгж хууль тогтоомжийг хэрхэн биелүүлдэг байгааг Засгийн газарт олгогдсон эрх хэмжээний хүрээнд хяналт тавьж зөрчил дутагдлыг арилгуулах;

г) захиргааны хяналтын төв байгууллагууд бүрэн эрхээ хэрхэн хэрэгжүүлж байгааг шалган илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авах;

д) захиргааны хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, алба болон нутгийн захиргааны байгууллагуудын хяналтын ажил эрхэлсэн ажилтнуудад эрх зүй, арга зүйн туслалцаа үзүүлж, тэдгээрийн хяналт шалгалтын үйл ажиллагааг дараахь хэлбэрээр чиглүүлэх, уялдуулан зохион байгуулах. Үүнд:

-захиргааны хяналтыг хэрэгжүүлэх байгууллага, албадаас тухайн жилд хийх хяналт шалгалтын төлөвлөгөөний төслийг авч үзэж.

үйл ажиллагааны давхардлыг арилгах зорилгоор зохицуулах;

-захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, байгууллага, албадын хүчээр тэдгээрийн бүрэн эрхийнх нь хүрээний асуудлаар хяналт шалгалт хийлгэх, дүнг авч үзэх;

-захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, байгууллага, албадын ажлын тайлан мэдээг хагас, бүтэн жилээр авч үзэн дүн шинжилгээ хийж чиглэл өгөх;

-захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, байгууллага, албадын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг боловсронгуй болгохтой холбогдсон асуудлыг авч үзэж шаардлагатай гэж үзнэл түүнийг засгийн газрын хуралдаанд оруулах;

-захиргааны хяналтын мэргэжлийн ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх, тэдний ажлын нөхцөл, нийгмийн баталгааг хангах чиглэлээр санал боловсруулж зохих байгууллагад оруулах;

е) энэ дүрмийн 7 дугаар зүйлийн "а", "б", "в"-д хамаарах асуудлаар байгууллага, иргэдээс ирүүлсэн санал, өргөдөл, гомдлыг хүлээн авч барагдуулах.

8. Хэрэг эрхлэх газар захиргааны хяналтын талаар дор дурдсан эрх эдэлнэ:

а) хяналт шалгалтын ажигч зайлшгүй шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулж авах;

б) шаардлагатай тохиолдолд мэргэжлийн хүмүүсийг төрийн захиргааны зохих байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр ажлын 12 хоног хүртэл хугацаагаар үүрэгт ажлаас нь чөлөөтүүлж, шалгалтын ажилд оролцуулах. Энэ тохиолдолд тэдгээрийн хяналт шалгалтын ажилд оролцсон хугацааны цалин, томилолтын зардлыг үндсэн байгууллага нь олгоно;

в) шаардлагатай үед захиргааны хяналтыг хэрэгжүүлэх, байгууллага, алба болон нутгийн захиргааны байгууллагуудын хяналтын ажилтнуудаар шалгалт, шинжилгээ судалгаа хийлгэх, үнэлэлт дүгнэлт гаргуулах;

г) холбогдох хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, ажил сайжруулах талаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын удирдлага, төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, холбогдох албан тушаалтанд албан шаардлага тавьж гүйцэтгэлийг хангуулах;

Уг албан шаардлагыг холбогдох байгууллагын удирдлагууд хугацаанд нь биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй.

д) үндсэн үүргээ зохих ёсоор биелүүлээгүй, гэм буруутай болох нь шалгалтаар нотлогдсон албан тушаалтанд хөдөлмөрийн болон төрийн албаны хуульд заасан шийтгэл ногдуулах санал тавих, эрүүгийн гэмт хэргийн шинжтэй асуудал илэрсэн тохиолдолд холбогдох баримт материалыг эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлэх;

е) хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр зөрчсөнөөс болон биелүүлээгүйгээс байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хууль бусаар олсон орлого, эд хөрөнгийг улсын орлогод оруулах, мөн бусдад учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх;

ж) шалгалтын дүнг гаргах, шийдвэрийн төсөл болон шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах талаар шалгагдсан байгууллагаас хийх ажил, авах арга хэмжээний тухай саналын хамт Засгийн газрын удирдлагад танилцуулж шаардлагатай гэж үзвэл Засгийн газрын хуралдаанд оруулах;

з) хяналт шалгалтын дүргийн талаар Засгийн газрын төв хэвлэлд мэдээлэх.

9. Хэрэг эрхлэх газрын захиргааны хяналт хариуцсан ажилтнууд нь энэ дүрмийн 7, 8 дугаар зүйлд заасан үүрэг хүлээж, эрх эдэлнэ.

10. Хэрэг эрхлэх газрын захиргааны хяналт хариуцсан ажилтнуудын өгсөн үнэлэлт дүгнэлтийг хууль зүйн үндэслэлгүй гэж шалгагдсан байгууллага, албан тушаалтан үзвэл энэ тухай гомдлоо Хэрэг эрхлэх газрын удирдлагад гаргаж болно. Уг гомдлыг хүлээж авснаас хойш 14 хоногийн дотор хянаж шийдвэрлэж хариу өгнө.

Хэрэг эрхлэх газрын удирдлагын өгсөн хариуг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу хуулийн байгууллагад гаргаж болно.

Засгийн газрын 1995 оны 157 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

**ХУУЛЬ ТОГТООМЖ, ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ШИЙДВЭРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ҮР ДҮН, БИЕЛЭЛ-  
ТИЙГ ДҮГНЭХ, МЭДЭЭЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол Улсын яам, Засгийн газрын үндсэн болон дэд бүтцэд ордог тусгай газрууд (цаашид "төрийн захиргааны төв байгуулла-

гууд" гэх), нутгийн захиргааны байгууллага, төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлигаар Засгийн газарт даалгасан буюу чиглэл болгосон заалт (цаашид "хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг" гэх) засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, үр дүн, биелэлтийн байдалд хяналт тавьж мэдээлэхдээ энэхүү журмыг мөрдөнө.

**Хоёр. Монгол Улсын хууль тогтоомж,  
Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн  
газрын шийдвэрийг хэрэгжүүлэх  
ажлыг зохион байгуулах**

2. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах, биелэлтэд нь хяналт тавих төв байгууллага нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байх ба энэ үүргийг төрийн захиргааны төв байгууллагад сайд, тусгай газрын дарга, нутгийн захиргааны байгууллагад бүх шатны Засаг дарга нар, бусад байгууллага, аж ахуйн нэгжил тэдгээрийн удирдлага шууд хариуцна.

3. Засгийн газрын Хэрэг эрхлэх газар нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулахдаа төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад Ерөнхийлөгчийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, шийдвэр, тэдгээртэй холбогдох заалтыг хүргүүлэх, удирдлага, зохицуулалт, арга зүйн зааварчилга өгөх, түүний мөрөөр зохиосон ажлын үр дүнг гаргуулан авч дүгнэлт хийж ажиллана.

4. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор хүргүүлсэн зааварчилгын мөрөөр холбогдох ажил зохион байгуулж, үр дүнг тогтоосон хугацаанд нь эргэж мэдэгдэх үүрэгтэй.

Энэ чиглэлээр нутгийн захиргааны байгууллага нь өөрийн нутаг дэвсгэрт оршин үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгжид нэр зэмж буюу нийтлэг байдлаар хариуцуулсан үүрэг даалгаврыг хуудийн хүрээнд зохион байгуулж гүйцэтгэлд хяналт тавина.

5. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг харьяа төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид хэрхэн зохион байгуулж байгаа явц, байдалд хяналт тавьж биелэлтийн хангуулна.

6. Төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх зорилгоор төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгуудлагаас өгсөн үүрэг, даалгаврыг биелүүлэх ажлыг зохион байгуулж үр дүнг тэдгээрээс тогтоосон хугацаанд эргэж мэдээлэх үүрэгтэй.

Төрийн өмчийн төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж нь хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх чиглэлээр тэдгээрт нийцүүлэн гаргасан шийдвэрийн биелэлтийг зохион байгуулна.

7. Шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг хэрхэн зохион байгуулж байгааг харьяа байгууллага, аж ахуйн нэгжид холбогдох дээд байгууллага нь шалгалт хийж, илтгэл сонсголыг нь хэлэлцэж, түүний мөрөөр хуулийн хүрээнд тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

**Гурав. Монгол Улсын хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар зохион байгуулж буй ажлын үр дүн, биелэлтийг дүгнэх, тооцох, мэдээлэх**

8. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг сурталчлах, хэрэгжүүлэх талаар зохион байгуулж буй ажлын явц байдалд тухайн шийдвэрийн заалт бүрээр хяналт тавих, үр дүнг нэгтгэж дүгнэх, мэдээлэх ажлыг улсын хэмжээнд Засгийн газрын Хэрэг эрхлэх газар хариуцан гүйцэтгэнэ.

9. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага нь өөрийн аппарат, харьяа төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжид зохион байгуулсан тухай, түүний үр дүн, явц байдал, хэрэв тасарч байгаа бол шалтгааныг заалт нэг бүрээр энэхүү журмын 1 дүгээр хавсралтын дагуу гаргаж улирал бүрийн эхний сарын 5-ны дотор Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн байна.

10. Засгийн газрын шийдвэрээр байгуулсан ажил төрлийн байнгын болон түр комисс, эвлэл, ажлын хэсгүүд хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг зохион байгуулах, хянах, явц, үр дүнг тооцох ажлыг өөрсдөө хариуцан хэрэгжүүлж дүнг энэхүү журмын 1, 2 дугаар хавсралтын дагуу гаргаж улирал бүрийн эхний сарын 5-ны дотор Засгийн газрын

Хэрэг эрхлэх газарт ирүүлсэн байна.

11. Төрийн өмчийн болон төсөвт байгууллага, төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгж хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж биелэлтэд хяналт тавин явц байдал, үр дүнг харьяалах төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагад улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор энэхүү журмын 1, 2 дугаар хавсралтын дагуу гаргаж хүргүүлсэн байна.

12. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийн явцыг тухайн байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлага буюу зөвлөл улирал бүр хэлэлцэн дүгнэж, биелэлтийн явцыг эрчимжүүлэх, илэрсэн дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч, гэм буруутай албан тушаалтан, ажилтантай зохих хариуцлага тооцож байна.

13. Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлигаар Засгийн газарт өгсөн үүрэг даалгавар, чиглэлийн биелэлтийг төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас ирүүлсэн мэдээллийн үндсэн дээр Засгийн газрын Хэрэг эрхлэх газар улирал бүр хянан нэгтгэж Засгийн газрын хуралдаанд танилцуулсны үндсэн дээр Улсын Их Хуралд болон Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлнэ.

14. Засгийн газрын шийдвэрийн хэрэгжилтийн явц байдлыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар улирал бүрийн эхний сарын 15-ны дотор Засгийн газрын гишүүд, тусгай газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарын хариуцсан заалт нэг бүрээр энэхүү журмын 2 дугаар хавсралтын дагуу нэгтгэн гаргаж дүнг Засгийн газрын хуралдаанд танилцуулж байна.

15. Хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэрийн хяналтад байгаа заалт болит шалтгааны улмаас биелэгдэх боломжгүй болсон, цаг хугацааны болон агуулгын хувьд ач холбогдолгүй болсон нөхцөлд уг шийдвэрийг санаачилсан буюу хэрэгжүүлэх үүрэг бүхий байгууллага, албан тушаалтан түүнийг өөрчлөх буюу хяналтаас хасах эсэхийг нягтлан үзэж санал бэлтгэн Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газарт хүргүүлэх буюу Засгийн газрын хуралдаанд оруулж шийдвэртүүлнэ.

16. Монгол Улсын Их Хурлын тогтоолын биелэлтийг хангах чиглэлээр зохиосон ажил, түүний үр дүнгийн талаархи жилийн тайланг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас нэгтгэн гаргаж Засгийн газрын хуралдаанд оруулж хэлэлцүүлсний үндсэн дээр жил бүрийн эхний сард багтаан Улсын Их Хуралд хүргүүлж байна.

17. Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, Засгийн газрын шийдвэрээр байгуулсан ажил төрлийн байн-



гын болон түр комисс, зөвлөл, ажлын хэсгүүд тогтоол шийдвэрийн биелэлтийг гэргаж мэдээлэхдээ дор дурдсан зарчмыг баримтална:

а) тогтоол шийдвэрийн заалтын нэр заасан үүргийн биелэлтийг нэр заагдсан яам, газар, Засаг дарга, комисс, зөвлөл, ажлын хэсэг улирал тутам мэдээлж байх;

б) хэд хэдэн яам, Засаг дарга, комисс, зөвлөл, ажлын хэсэгт өгсөн үүргийн биелэлтийг эхэнд нь нэр нь бичигдсэн Засгийн газрын гишүүн, Засаг дарга, комисс, зөвлөл, ажлын хэсгийн дарга (ахлагч) нар нэгтгэн дүнг улирал тутам мэдээлж байх;

в) сайд, тусгай газрын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тодорхой байгууллага, хүний нэр заалгүйгээр өгсөн нийтлэг үүрэг, норматив (тухайн жилд гарсан болон урьд онд гарсан боловч биелэлтийг нь дахин мэдээлэх шаардлагатай) заалтын биелэлтийг жилийн эцэст бүрэн хэмжээгээр гэргаж мэдээлж байх.

Хуримт 1 дүгээр хэсэрийг  
ТОГТООЛ ШИЙДВЭРИЙН БИЕЛЭЛТИЙН ТУХАЙ  
ТА Н И Я Ц У У Р Ъ Г А

Д/Д	Эхнэ хүйн анхны нэр, он, сар, ндөр, дугаар	Зүйл, заалтын дугаар, агуулга	Заалтын биелэлтийн хэсгэд байрлах тухай тэмдэглэл, биелсэн, хэрэгжих илтгэлд байгаа, хугацаа болоогүй, тасарсан аль нь болохыг тэмдэглэхийн тусгалаар мэдээлж өгөхөд
	1	2	3

Яам, Улсын Их Хурлын Тогтоол

Хөдөр Ерөнхийлөгчийн зардал

Гурав Засгийн газрын Тогтоол

Дөрөв Ерөнхий сайдын зардал

Тав Засгийн газрын Хуралдааны тэмдэглэл

Биелэлтийг гэргажсан

Яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын

Тангын газрын дарга

(Гарын үсэг)



Засгийн газрын 1995 оны 157 дугаар  
тогтоолын 3 дугаар хавсралт

## МОНГОЛ УЛСЫН ЗАХИРГААНЫ ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧИЙН ТЭМДЭГ, ҮНЭМЛЭХИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### Нэг. Тэмдэг

1. Монгол Улсын Захиргааны хяналтын улсын ерөнхий байцаагчийн тэмдэг нь дугуй хэлбэртэй, диаметр нь 40 мм, улсын ахлах байцаагчийн тэмдгийн диаметр 35 мм, улсын байцаагчийнх 30 мм хэмжээтэй байна. Тэмдгийн төв хэсэгт нь "Улсын ерөнхий байцаагч", "Улсын ахлах байцаагч", "Улсын байцаагч" гэсэн үг, цагдаагийн байгууллагаас олгосон регистрийн болон улсын байцаагчийн хувийн дугаар байна. Тэмдгийн гадна хүрээн дотор баруун гар талаас нь эхлэн захиргааны тухайн хяналтын байгууллагын нэрийг бичсэн байна.

2. Тэмдэг хийлгэх зөвшөөрлийг цагдаагийн байгууллагаас авах ба тэмдгийг хуулбарлан хийлгэж хэрэглэхийг хориглоно.

3. Улсын байцаагчийн тэмдэг ашиглах, хадгалахдаа "Заавар батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 1993 оны 13 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг мөрдөнө.

### Хоёр. Үнэмлэх

1. Монгол Улсын Захиргааны хяналтын улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн үнэмлэх нь 90мм х 70 мм-ийн хэмжээтэй, нүүрэн талдаа соёмбо дүрсэлсэн болон Монгол Улсын захиргааны хяналтын улсын байцаагчийн үнэмлэх гэсэн бичээстэй байна.

Үнэмлэх нь дугаар, зүүн дээд хэсэгтээ 3х4 хэмжээтэй биеийн зурагтай байх ба тухайн яам, тусгай газар, аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр, улсын байцаагчийн албан тушаал, овог нэрийг бичиж ..... биелэлтэд хяналт тавих талаар хууль тогтоомжид заасан төрийн захиргааны хяналтын бүрэн эрхийг эдэлж, хариуцлага хүлээлгэх эрх бүхий албан тушаалтан мөн гэсэн болон үнэмлэхийг бусдад шилжүүлэхийг хориглоно, үнэмлэхийг 19 .. оныг дуустал хугацаагаар олгов. Монгол Улсын ..... сайд, эсвэл ..... аймаг, нийслэлийн Засаг дарга гэсэн гарын үсэг зурах бичээстэй байна. Мөн үнэмлэхийн бичээс бүхий тал нь удаан өнгийн ташуу зураастай байх бөгөөд хуурамчаар үйлдэгдэх, норж гэмтэх, хаягдаж үрэгдэхээс сэргийлж зүүх боломжтой нийлэг хавтсанд хийж битүүмжилсэн байна.

2. Үнэмлэхийг тухайн яам нь бичиж бигтүүмжилж, 2 жилийн хугацаагаар олгох ба уг байцаагчийг ажлаас чөлөөлөгдөх үед нь хураан авч, тусгай бүртгэл хөтлөн устгал хийж байна.

3. Үнэмлэх, тэмдгийг яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын захиалгын дагуу Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас эрхлэн нэгдсэн журмаар хийлгэж, тусгай дугаар, индекс тавьж тухайн яам, тусгай газар, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газруудад зохих үнээр нь бүртгэлээр олгож байна.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 8 дугаар  
сарын 29-ний өдөр

Дугаар 158

Улаанбаатар  
хот

1996 оныг боловсролын жил болгох,  
багш нарын их хурал хуралдуулах  
тухай

Улсын Их Хурлаас баталсан төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хуулиудыг хэрэгжүүлэх ажлыг шуурхай зохион байгуулах, төрийн захиргааны бүх шатны байгууллага, албан тушаалтан, багш, сурган хүмүүжүүлэгчдийн анхаарал, хүчийг энэ ажилд чиглүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. 1996 оныг "Боловсролын жил" болгож, боловсролын жилийн ажлыг улс орон даяар зохион явуулах, багш нарын ээлжит их хурлыг 1996 оны III улиралд хуралдуулах тухай Шинжлэх ухаан, боловсролын яамнаас оруулсан саналыг зүйтэй гэж үзсүгэй.

2. Боловсролын жилийн ажлыг зохион байгуулах болон багш нарын их хурал хуралдуулах бэлтгэлийг хангах үндэсний хороог энэ тогтоолын хавсралтад дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

3. Боловсролын жилийн ажлыг зохион байгуулах болон багш нарын их хурал хуралдуулах бэлтгэлийг хангах үндэсний хороо, Шинжлэх ухаан, боловсролын яаманд даалгах нь:

а) боловсролын жилийн хүрээнд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө гаргаж ажиллахын хамт багш нарын их хурал хуралдуулах бэлтгэлийг хангах арга хэмжээ авсугай;

б) боловсролын жилийн хүрээнд болон багш нарын их хурлыг утгаж зохион байгуулах ажилд төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, бүх шатны сургууль, багш, сурган хүмүүжүүлэгчдийг төрөөс боловсролын талаар баримтлах бодлого,

боловсролын тухай хуулиудыг хэрэгжүүлэх чиглэлээр тодорхой үүрэг, зорилготойгоор оролцуулж, тэдний зохиож байгаа ажлын талаар хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах, үр дүнг хагас жил тутам Засгийн газарт танилцуулж байсугай;

в) олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгж, ажил хэрэгч хүмүүс, хамт олон, иргэдийн үүсгэл санаачлагыг дэмжин, тэдэнтэй хамтран ажиллаж, тэднийг боловсролын жилийн ажилд идэвхтэй оролцуулж байсугай;

г) үндэсний хорооны бүрэлдэхүүнд оруулах сургууль, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчдийг холбогдох байгууллагатай нь тохиролцсоны үндсэн дээр энэ оны 9 дүгээр сарын 15-ны дотор багтаан томилсугай.

4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а) төрөөс боловсролын талаар баримтлах бодлого, боловсролын тухай хуулиудыг хэрэгжүүлэх арга хэмжээг тухайн орон нутгийн онцлогтой уялдуулан 1996 оны төсөв, эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиглэлд тусган, гүйцэтгэлийг тодорхой хутагаанд дүгнэж нийтэд мэдээлж байсугай.

б) сургуулийн насны хүүхэд, суурь боловсрол эзэмшээгүй иргэдэд холбогдох хууль тогтоомж, хөтөлбөр, журмын дагуу суурь боловсрол эзэмшүүлэх, нөхөн олгох арга хэмжээг 1995/1996 оны хичээлийн жилээс эхлэн авч хэрэгжүүлэх үндсэн дээр сургууль завсардалтыг бууруулах арга хэмжээ авсугай;

в) боловсролын жилийн хүрээнд болон багш нарын их хурлыг угтаж бүх шатны сургууль, хүүхдийн цэцэрлэгийн сургалт, хүмүүжил, боловсролын судалгаа шинжилгээний ажлын чанарыг дээшлүүлэх, багш нарын нийгмийн асуудлыг шийдвэрлэх чиглэл, төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлж ажилласугай.

5. Боловсролын жилийн ажлыг зохион явуулах, багш нарын их хурал хуралдуулах бэлтгэлийг хангахад шаардагдах зардлыг 1996 оны төсөвт тусгах арга хэмжээ авахыг Сангийн яам (Э. БЯМБАЖАВ), Шинжлэх ухаан, боловсролын яам (С. ТӨМӨР-ОЧИР)-д даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Монгол Улсын Шадар сайд

Л. ЭНЭБИШ

Шинжлэх ухаан,  
боловсролын сайд

С. ТӨМӨР-ОЧИР

Засгийн газрын 1995 оны 158 дугаар  
тогтоолын хавсралт

**БОЛОВСРОЛЫН ЖИЛИЙН АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ  
БОЛОН БАГШ НАРЫН ИХ ХУРАЛ ХУРАЛДУУЛАХ  
БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ  
БҮРЭЛДЭХҮҮН**

Дарга	-Монгол Улсын Шадар сайд
Орлогч дарга	-Шинжлэх ухаан, боловсролын сайд
Нарийн бичгийн дарга	-Шинжлэх ухаан, боловсролын дэд сайд
Гишүүд:	-Соёлын сайд; -Хүн амын бодлого, хөдөлмөрийн сайд; -Радио телевизийн хэрэг эрхлэх газрын дарга; -Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч; -Монгол Улсын Үндэсний их сургуулийн ректор; -Улсын багшийн их сургуулийн ректор; -Сургалтын агуулга, арга зүйн институтийн захирал; -Сангийн яамны төсвийн төлөвлөлт, санхүүжилтийн газрын дарга; -Шинжлэх ухаан, боловсролын яамны дээд боловсролын газрын дарга; -мөн яамны ерөнхий боловсролын газрын дарга; -Хүүхэд асран хүмүүжүүлэх төвийн захирал; -Сургууль, аж ахуйн нэгж, байгууллагын төлөөлөгчид.

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

1995 оны 8 дугаар  
сарын 30-ны өдөр

Дугаар 161

Улаанбаатар  
хот

**Заавар батлах тухай**

Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

Монгол Улсад Олон нийтийн байгууллагыг бүртгэх зааврыг хавсралтын ёсоор баталж, Иргэдийн эвлэлдэн нэгдэх эрхийн тухай хууль батлагдан гарах хүртэл хугацаанд мөрдүүлсүгэй.

Монгол Улсын ерөнхий сайд

**П.ЖАСРАЙ**

Хууль зүйн сайд

**Н.ЛУВСАНЖАВ**

Засгийн газрын 1995 оны  
161 дүгээр тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСАД ОЛОН НИЙТИЙН БАЙГУУЛЛАГЫГ  
БҮРТГЭХ ЗААВАР**

**НЭГ. Нийтлэг үндэслэл**

1. Олон нийтийн байгууллагын дүрэм, мөрийн хөтөлбөр, түүнийг үүсгэн байгуулсан шийдвэр нь Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжийн актад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, тэдгээрийг улсын бүртгэлд бүртгэхэд энэхүү зааврыг мөрдөнө.

2. Улсын бүртгэл нь тухайн олон нийтийн байгууллагыг хуулийн этгээд болохыг эрх зүйн хувьд баталгаажуулсан албан ёсны баримт мөн.

3. Олон нийтийн байгууллага нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр явуулах үйл ажиллагааны зорилго, хүрээгээр үндэсний болон олон улсын, түүнчлэн орон нутгийн шинжтэй байж болно.

## ХОЁР.Баримт бичгийг бүрдүүлэх

4.Олон нийтийн байгууллагыг бүртгүүлэхэд дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

а)олон нийтийн байгууллагыг байгуулах шаардлага, үйл ажиллагааны онцлогийг тусгасан өргөдөл;

б) үүсгэн байгуулагчдын хурлын тэмдэглэл, тухайн олон нийтийн байгууллагыг байгуулсан, удирдлагыг сонгож дүрмийг баталсан тухайн хурлаас гарсан шийдвэр;

в)олон нийтийн байгууллагын дүрэмд байгууллагын нэр, оршин байгаа хаяг, зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, үйл ажиллагаа явуулах газар нутгийн хүрээ, бүтэц зохион байгуулалт, гишүүнчлэл, санхүүжилтийн эх үүсвэр, татан буулгах журам, сангийн дүрэмд сангийн зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл,бүтэц зохион байгуулалт, хөрөнгийн эх үүсвэр, түүнийг хэрхэн захиран зарцуулах, татан буулгах журам зэргийг тодорхой заана;

г) удирдах байгууллагын гишүүдийн дэлгэрэнгүй бүртгэл/ажлын болон гэрийн хаяг/, нийт гишүүдийн бүртгэл /паспортын болон регистрийн дутаар/, байгууллагын хаяг /байр танхим шинээр барих, худалдан авах, түрээсээр ашиглах бол техникийн нөхцөл болон холбогдох бусад газраас авсан зөвшөөрөл/;

д) улсын тэмдэгтийн хураамж төлсөн тухай баримт.

5.Олон нийтийн байгууллагыг бүртгүүлэх баримт бичиг нь монгол хэл дээр үйлдэгдсэн байна.

## ГУРАВ. Олон нийтийн байгууллагыг бүртгэх, гэрчилгээ олгох

6.Олон нийтийн байгууллага нь улсын бүртгэлд бүртгүүлэх өргөдлийг үүсгэн байгуулагчдын хурлаар дүрмээ баталснаас хойш 1 сарын дотор энэ зааврын "Хоёр"-т заасан баримт бичгийн хамт Хууль зүйн яаманд, орон нутагт бол аймгийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

7.Аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар орон нутагтаа байгуулагдсан олон нийтийн байгууллагын улсын бүртгэлд бүртгүүлэх баримт бичгийг бүрдэл болсон гэж үзвэл 14 хоногийн дотор Хууль зүйн яаманд ирүүлнэ.

8.Хууль зүйн яам олон нийтийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгүүлэх тухай өргөдлийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шийдвэрлэнэ.



9. Олон нийтийн байгууллага нь дүрэмдээ заасан бол тогтоосон журмын дагуу өөрийн салбартай байж болно. Салбар нь бие даасан хуулийн этгээд бол улсын бүтгэлд бүртгүүлнэ.

10. Бүртгэх байгууллага нь олон нийтийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгэсэн болон бүртгэлийг хүчингүй болгосон тухай төвийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд албан ёсоор зарлан мэдээлнэ.

11. Хууль зүйн яам шаардлагатай гэж үзвэл ирүүлсэн баримт бичгийн үнэн зөвийг шалгах, өргөдөл гаргагч буюу үүсгэн байгуулагч гишүүдээс нэмэлт баримт бичиг шаардах, тайлбар гаргуулах, бусад байгууллагаас холбогдох мэдээлэл болон дүгнэлт гаргуулах зэрэг үйл ажиллагаа явуулна.

12. Баримт бичиг нь бүрдэл болсон, ямар нэг маргаангүй олон нийтийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгэж, регистрийн дугаар олгон, данс нээлгүүлсний дараа гэрчилгээг албан ёсоор олгоно.

#### ДӨРӨВ. Хяналт тавих

13. Олон нийтийн байгууллагын үйл ажиллагаанд Хууль зүйн яам болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газраас хяналт тавина.

14. Олон нийтийн байгууллага нь ажлын тайлангаа жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор Хууль зүйн яаманд, санхүүгийн үйл ажиллагааны тайлан мэдээг Сангийн яаманд дараа оны 2 дугаар сарын 1-ний дотор ирүүлэх бөгөөд дүрэмдээ нэмэлт, өөрчлөлт оруулсан бол тухай бүр, оршин байгаа байршил, хаягийн өөрчлөлтийг 7 хоногийн дотор бүртгэх байгууллагад мэдэгдэж байна.

15. Хууль зүйн яам, Сангийн яамтай хамтран олон нийтийн байгууллагын үйл ажиллагааны зорилго, чиглэл, орлого, зарлага, татвар төлөлтийн байдлыг санхүүгийн баримтад тулгуурлан шалгах дүгнэлт гаргана.

16. Бүртгэх байгууллага нь тухайн олон нийтийн байгууллага хууль тогтоомж зөрчсөн гэх үндэслэл бүхий мэдээллийн дагуу холбогдох бусад байгууллагатай хамтран шалгалт хийж болно.

#### ТАВ. Олон нийтийн байгууллагыг бүртгэхээс татгалзах, бүртгэлийг хүчингүй болгох

17. Олон нийтийн байгууллагыг бүртгэхээс дор дурдсан үндэслэлээр татгалзаж болно:

а) Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид тухайн олон нийтийн байгууллагын зорилт, дүрэм, мөрийн хөтөлбөр, үүсгэн байгуулсан шийдвэр, тэдгээрийн агуулга, заалт харшилсан;

б) энэ зааврын "Хоёр"-т заасан баримт бичиг бүрдэл болоогүй;

в) тухайн олон нийтийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, хөрөнгийн эх үүсвэр тодорхойгүй;

г) өмнө бүртгэгдсэн олон нийтийн байгууллагатай зорилго, үйл ажиллагааны үндсэн чиглэл, гишүүнчлэл зэрэг нь давхцаж байвал.

18. Олон нийтийн байгууллагыг улсын бүртгэлд бүртгэхээс татгалзсан тухай шийдвэрийг бичгээр гаргана.

19. Дор дурдсан тохиолдолд бүртгэлийг хүчингүй болгоно:

а) олон нийтийн байгууллага нь өөрийн үйл ажиллагааг зогсоохоор шийдвэрлэсэн бол.

Үйл ажиллагаагаа зогсоох тухай шийдвэр гаргасан олон нийтийн байгууллага нь Хууль зүйн яаманд 7 хоногийн дотор мэдэгдэх бөгөөд Хууль зүйн яам нь уг мэдээллийг хүлээн авснаас хойш данс хаалгах, тэмдэг хураалгах асуудлыг холбогдох байгууллагад мэдэгдэж хариу авсны дараа улсын бүртгэлээс хасч, гэрчилгээг хураана;

б) олон нийтийн байгууллага нь өөрийн дүрэмд заасан чиглэл, зорилгоо хэрэгжүүлэхгүйгээр өөр төрлийн үйл ажиллагаа явуулж байгаа бол;

в) олон нийтийн байгууллага нь улсын бүртгэлд бүртгэгдсэн өдрөөс хойш 6 сарын дотор дүрэмд заасан үйл ажиллагаагаа эхлээгүй, 6 сараас дээш хугацаагаар ямар ч үйл ажиллагаа явуулаагүй бол;

г) Монгол Улсын хууль тогтоомж зөрчсөн тухай хууль хяналтын байгууллагын шийдвэр гарсан бол.

20. Олон нийтийн байгууллагын бүртгэлийг хүчингүй болгосон тухай шийдвэрийг олон нийтийн байгууллагын удирдах дээд байгууллага, банк, санхүү, татварын болон цагдаагийн байгууллага, тухайн нутаг дэвсгэрийн Засаг даргын Тамгын газарт явуулна.

21. Олон нийтийн байгууллагыг бүртгэхээс татгалзах, бүртгэлийг хүчингүй болгох талаар Хууль зүйн яамнаас гаргасан шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо шүүхэд гаргана.

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 9 дүгээр  
сарын 6-ны өдөр

Дугаар 164

Улаанбаатар  
хот

Шуудангийн үнэт цаасны талаар  
авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын шуудангийн үнэт цаас/марк, марктайгаар хэвлэсэн дугтуй, ил захидлын хуудас/-ыг хэвлүүлж гаргах, хуваарилах, борлуулахтай холбогдсон бодлого, зохицуулалтын асуудлыг Дэд бүтцийн хөгжлийн яаманд хариуцуулсугай.

2. Монгол шуудангийн Маркийн улсын фонд бүрдүүлэх журмыг хансралтын ёсоор баталсугай.

3. Монгол Улсын эх зургаар болон захиалгаар гадаадад хэвлүүлэн импортоор оруулан авчирч байгаа шуудангийн үнэт цаасыг "Гаалийн баталгаат агуулах"-д хадгалан тэндээс дотоодын худалдаанд гаргах болон экспортлох үед нь гааль, худалдааны татварын тооцоо хийж байхыг Дэд бүтцийн хөгжлийн яам /Р.Сандалхан/, Гаалийн ерөнхий газар /Б.Шаравсамбуу/-т зөвшөөрсүгэй.

4. Монгол шуудангийн Маркийн улсын фондод марк шилжүүлэх, чанарын үзлэг шалгалт хийх, тооллого явуулах байнгын комисс байгуулан шаардлагатай үед бусад яам, газартай тохиролцсоны үндсэн дээр тэдгээрийн холбогдох мэргэжлийн хүмүүсийг уг байнгын комиссын бүрэлдэхүүнд оруулан хамтран ажиллахыг Дэд бүтцийн хөгжлийн яам /Р.Сандалхан/-д даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Улсын фондод марк шилжүүлэх, улсын фондод маркийг хадгалах, борлуулах журам батлах тухай" Сайд нарын Зөвлөлийн 1985 оны 12 дугаар сарын 13-ны өдрийн 325 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд гооцсугай.

Монгол Улсын Ерөнхий Сайд

П.ЖАСРАЙ

Дэд бүтцийн хөгжлийн сайд

Р.САНДАЛХАН

Засгийн газрын 1995 оны 164 дүгээр  
тогтоолын хавсралт

## МОНГОЛ ШУУДАНГИЙН МАРКИЙН УЛСЫН ФОНД БҮРДҮҮЛЭХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1. Монгол шуудангийн Маркийн улсын фонд/цаашид "Улсын фонд" гэж нэрлэх/бүрдүүлэх ажлыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага эрхлэн гүйцэтгэнэ.

2. Улсын фонд бүрдүүлэх зорилгоор шуудангийн марк/цаашид "марк" гэж нэрлэх/шилжүүлэх ажлыг хагас жилд нэг удаа гүйцэтгэх бөгөөд фондоод марк шилжүүлэх, чанарын үзлэг шалгалт, тооллого хийх байнгын комиссыг харилцаа холбооны асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын тушаалаар томилон ажилдуулна.

### Хоёр. Улсын фондоод марк шилжүүлэх

3. Улсын фондоод цэвэр марк шилжүүлэхдээ дор дурдсан хэмжээг баримтална:

а/улс төр, цаг үеийн сэдэвтэй марк тус бүрээс 100 ширхгийг;

б/бусад бүх төрлийн чөлөөт сэдэвтэй сери марк тус бүрээс 300 серийг;

в/блок, клейнбоген тус бүрээс 300 ширхгийг.

4. Улсын фондоод шилжүүлэх маркийг хагас жилээр нь нэг боодол болгон боож лацлана. Боодол бүр дээр маркийн нэр төрөл, тоо ширхэг, номиналь үнэ, үнийн дүнг тодорхойлсон шошго наана.

5. Улсын фондоод маркийг шилжүүлэх ажлыг байнгын комиссын оролцоотойгоор гүйцэтгэнэ.

6. Улсын фондоод байхгүй, байвал зохих тоо хэмжээнд хүрээгүй болон сольж шинэчлэх шаардлагатай маркийг нөхөн бүрдүүлэх ажлыг Маркийн улсын фондын асуудал эрхэлсэн байгууллага /"Монгол шуудан" компани/ хариуцна.

### Гурав. Улсын фондын маркийг хадгалах

7. Улсын фондын маркийг чанар нь алдагдаж гэмтэхээс бүрэн хамгаалагдсан нөхцөл бүхий байранд тусгай тавиур, сейфонг хадгална.

8. Улсын фондын марк хадгалах байрны цонх нь төмөр тортой нарны гэрэл үл нэвтрэх хөшигтэй, хаалга нь төмөрлөгдсөн байхын

дээр уг байр нь цахилгаан дохиоллын системээр тоноглогдсон байна.

9.Улсын фондын маркийн өрөөний цахилгаан, халаалтын шугамын угсралт нь гал, усны аюулд нэрвэгдэхгүй байхаар хийгдсэн байна. Гэрлийн унтраалга, халаалтын системийн крант нь фондын өрөөний гадна талд байна.

10.Улсын фондын маркийн тооллого, чанарын шалгалтыг жил бүрийн хоёрдугаар улиралд хийж, гэмтсэн маркийг шинээр солих, нөхөн сэргээх бүх талын арга хэмжээг тухай бүр авч байна.

#### Дөрөв.Бусад асуудал

11.Маркийн асуудал эрхэлсэн байгууллага болон зах зээлээс олдоогүй маркийг улсын фондоос авч зарцуулах асуудлыг зөвхөн харилцаа холбооны асуудал эрхэлсэн Монгол Улсын сайдын тушаалаар шийдвэртэй байна.

12.Улсын фондын маркийг бүрдүүлэх, хадгалж хамгаалахтай холбогдон гарах зардлыг улсын фондын асуудал эрхэлсэн байгууллага /"Монгол шуудан" компани /жэлийнхээ төлөвлөгөөнд тусгаж гаргана.

13.Улсын фондын маркийн бүрдүүлэлт, хадгалалт, хамгаалалтын болон тооллого, үзлэг шалгалт хийсэн дүнгийн талаар харилцаа холбооны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад мэдээлж байна.

14."Монгол шуудангийн маркийн улсын фонд бүрдүүлэх журам"-ын аливаа заалтыг зөрчсөн байгууллага, албан тушаалтанд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж, учирсан хохирлыг нөхөн төлүүлнэ.

### МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 9 дүгээр  
сарын 6-ны өдөр

Дугаар 165

Улаанбаатар  
хот

Төлөөлөгөө батлах тухай

Тарваган тахал болон олон улсын хөл хориот гоц халдварт бусад өвчинүүдтэй тэмцэх, сэргийлэх ажлыг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гоц халдварт өвчнөөс сэргийлэх, түүнтэй тэмцэх арга хэмжээний үлгэрчилсэн төлөвлөгөө"-г хавсралтын ёсоор баталсугай.

2. Гоц аюулт халдварт өвчинтэй тэмцэх улсын дайчилгааны төлөвлөгөөг таван жилийн хугацаанд мөрдөхөөр 1995 оны 9 дүгээр сард багтаан шинэчлэн баталж, цаашид жил бүр тодотгон, хэрэгжүүлэх арга хэмжээг зохион байгуулж ажиллахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Улсын байнгын онцгой комиссын орлогч, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга Г.Дамдинсүрэн нарт даалгасугай.

3. Гоц аюулт халдварт өвчинтэй тэмцэх дайчилгааны талаар орон нутагт гүйцэтгэх ажлын төлөвлөгөөг 1995 оны 10 дугаар сард багтаан шинэчлэн боловсруулж, баталж мөрдөхийг аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга, байнгын онцгой комиссын дарга нарт даалгасугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Эрүүл мэндийн сайд

П.НЯМДАВАА

ГОЦ ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС СЭРГИЙЛЭХ,  
ТҮҮНТЭЙ ТЭМЦЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ  
ҮЛГЭРЧИЛСЭН ТӨЛӨӨЛӨГТӨӨ

д/д	Хөлий ажил	Хугацаа	Харуулах зүйл
-----	------------	---------	---------------

Нэг Төрөлтийг туслах сурталдаах,  
түүнтэй тэмцэх

А Төрөлтийг тэмцэх сурталдаах тусалар

1. Олонх оюу төрөлтийн тэмцэл өмчлөөх сурталдаах, сэмдэг тусалар зохиосон ажлыг дүгнэх, дараа оюу үйлдвэлтэй ажлыг төлөргөхөдөөх бодлогын өмчлөх той комиссын даргад танилцуулвалд үзэгдэл хийж байх
 

жюу бүрлийн  
I үзэгдэл

Үгс, аймэг, нийслэл, сүм, дүүргийн байнгын өмчлөх комисс
2. Энгийн төрөлтийн шинжлэлтэйг оюуныг шалгуулахтай илрүүлдэг
 

жюу бүрлийн  
II, III үзэгдэл

Аймэг, нийслэл, сүм, дүүргийн Засаг дарга, байнгын өмчлөх комисс, Зүүн комиссийн ажлын хэргийг хийж байгаа үзэгдэл
3. Төрөлтийн тухайн байрлалын өдөрлөхтэй голлохт бүрэл илрүүлдэг сэрэмжлүүлтийн тойл, тэмцэл, сэмдэг тэмдэг, үрэл нь тэмцэлтэй сэрээдэй шилжүүлэх
 

жюу бүрлийн  
IV, V сэрэл

Аймэг, нийслэл, сүм, дүүргийн байнгын өмчлөх комисс, төм, оюуны үзэгдэлтэй сэрэл, байрлал сэрэмжлүүлтийн байрлалд
4. Илэрхийлэлтэй илрүүлтийн төрөлтийн тухайн явцад үзсэн дуураагчид шалгуулахтай тэмцэлтэй буюу өмчлөгчүүдэд байрлалтай явцлын буюу-даны дүгээр сийрэгжүүлэх, өмчлөгчүүдэд
 

жюу бүрлийн  
II III үзэг-дэл

Аймэг, нийслэл, сүм, дүүргийн байнгын өмчлөх комисс, төм, оюуны үзэгдэлтэй илрүүлтийн сэрээдэй шилжүүлэх байрлалд





11. Аймаг, нийслэл, сум, багийн эмнэлэг, үндэсний сургахал бусад байгууллагад түрээстэй талхын үед гүүрлэх амьтанын бусад, хийгч, жоржуулах багтсангйг шалгах, шалгах үеэрээ эм, аргаартайн бусад, тийгэм төлөөрөө, амьтанын сэтгэл хэргээрээ, биеийн шалгахуу- лалт илэрхийлэх арга хэмжээ авч байх

Жаг бүрийн  
1 үндэс

Аймаг, нийслэл, сум, айуурын  
байршил онцгой комисс, арга  
хэрэгсэлтэй байгууллагууд

12. Дээдэл байгууллагуудад түрээс эргэлдэх амьтаны ачаар талхыг сургахал, хяналтын комисс үзүүлэх

Жаг бүрийн  
II үндэс

Аймаг, нийслэлийн шалгахын  
гэрээ, төм, орон нутгийн  
байршил комиссууд хяналт  
өмнөтэй талхыг байгууллагууд

II Түрээсгүй амьтны онцгой шалгахын комисс бүхий  
түрээсгүй амьтны амьт

13. Түрээсгүй амьтны онцгой шалгахын комисс үндэслэл бүхий, төр-  
лөлийн жоржуулах арга хэрэгсэл бүхий онцгой комиссын талхыг, арга  
хэрэгсэлтэй байгууллагийн хяналтын жоржуулахуудад жор-  
жуулах арга хэрэгсэл, байршил, орон нутгийн байгууллагууд  
ажлынхуудад амьтны онцгой шалгахын үндэс, төрлийн талхыг

Жаг бүрийн  
VIII-X сар

Аймаг, нийслэл, сум, айуурын  
байршил онцгой комисс

14. Түрээсгүй амьтны комиссын жоржуулах үндэслэл бүхий, төр-  
лөлийн жоржуулах арга хэрэгсэл бүхий онцгой комиссын талхыг, арга  
хэрэгсэлтэй байгууллагийн хяналтын жоржуулахуудад жор-  
жуулах арга хэрэгсэл, байршил, орон нутгийн байгууллагууд

Жаг бүрийн  
VIII-X сар

Сум, айуурын байршил онцгой  
комисс

15. Түрээсгүй амьтны онцгой шалгахын комиссын жоржуулах үндэслэл  
бүхий, төрлөлийн жоржуулах арга хэрэгсэл бүхий онцгой комиссын талхыг,  
арга хэрэгсэлтэй байгууллагийн хяналтын жоржуулахуудад жор-  
жуулах арга хэрэгсэл, байршил, орон нутгийн байгууллагууд

Жаг бүрийн  
VII-IX сар

Аймаг, сум, айуурын, байршил Дээд  
арга хэрэгсэл

16. Түрээсгүй амьтны комиссын жоржуулах үндэслэл бүхий, төр-  
лөлийн жоржуулах арга хэрэгсэл бүхий онцгой комиссын талхыг, арга  
хэрэгсэлтэй байгууллагийн хяналтын жоржуулахуудад жор-  
жуулах арга хэрэгсэл, байршил, орон нутгийн байгууллагууд

Жаг бүрийн  
II-III үндэс

Сум, байршил Дээд арга, төм, орон  
нутгийн байршил комиссууд амь-  
тны онцгой талхыг байгуулахууд

В Төрөлтийг тээвэр, өмчил, тусгай санхүүг  
 хэргээр нь үндэс арга хэмжээг

17. Дундаар хүдээн дамдгай дуудлагын хэргийг ажилтай гэрээж, байнгын  
 өмчийн комиссар болон байдалыг оруул

1 цагийн  
 дотор

Төв, орон нутгийн байнгын өмч-  
 лол комисс, эрүүг мөрдлийн ком-  
 комисс байгуулалтууд

18. Саяагийн өмчийн гэмтэлд халварын судалгаа хийж хяналтын  
 барууны түсгэрхэл, өмчийг баталгах хүртэл хол хөрөнө тэргүүл

Тухайн газар  
 очсон дэргүй

Төв, орон нутгийн байнгын өмч-  
 лол комисс, эрүүг мөрдлийн ком-  
 комисс байгуулалтууд

19. Дуудлагын хэргийн агуулгыг нь өмчийн хөдөлгөөн, хэргийн  
 шийдвэрлэлийн яам, халвар эсэргүүцэх арга хэмжээний талаар шүүр-  
 кийг хэлэлцэж болно

Цэг тусам

Төв, орон нутгийн дуудлагын хэс-  
 гийн ажилчид

20. Олонд баталгаатай үе, орон нутгийн байнгын өмчийн комисс нь  
 байнгын тасалгааныг хэрэгжүүлж эхэлнэ

Мэдээлэх  
 ажлын дэргүй

Үе, орон нутгийн байнгын  
 өмчийн комисс

Холбоо Урлах талд өмчийг урьдчилсан сурталдах талаар  
 хэлэлцэж болно

А. Урлах талд өмчийг сурталдах талаар

21. Энэ тус тусам өмчийн нэг дэх хэргийн 1, 9, 10, 11-д ажлын арга  
 хэмжээг тус тус хэрэгжүүртэл

Жаа бүрийн  
 1 үеэргэд

Тусам хэрэгжүүлэгч байгуулалтууд

22. Хүн амаар үндэс тэвэр үеэр байнгын өмчийг хийнэ

Төртхөөд

Орон нутгийн Эсэрг арга, үе  
 ажиллагааны байгуулалтууд

23. Байдалд халварын аргаар эрүүг мөрдлийн аргаар хийнэ

Төртхөөд

Ажилт, шийдвэр, орон нутгийн  
 Эсэрг арга нэр

24. Хүн амаар үндэс талд өмчийг сурталдах талаар тусам халварын  
 хэрэгжүүлэгч өмчийг сурталдах

Дундаар үн-  
 гал үргүүлэн

Ажилт, шийдвэр, орон нутгийн  
 Эсэрг арга нэр, Эрүүг мөрдлийн яам, Монгол-  
 арга Галин, төлөөллийн хэрэг арга  
 арга нэр

6. Урлах талд өргөн гарсан үед ажил эрх хэмжээний талд

- |    |   |  |  |
|----|---|--|--|
| 25 | Энэ төлөвлөгөөний 18-21-д заасан бую эрх хэмжээг авах   | Тусгийн да-<br>сан хугацаанд   | Тусгийн хөрөнгийн байгууллагууд  |
| 26 | Хая хөрөнгийг бусад байгуул үгүй амьт гийгны цэвэр үсээр хангах, шударгалтай үед үгүй хооронд   | Төртний  | Үгүй, өргөн нутгийн байнгын өн-<br>гүй комисс, үс давтгалтын бай-<br>гууллагууд  |
| 27 | Энэ төлөвлөгөөний 24-д заасан эрх хэмжээг авах  | Төртний  | Тусгийн хөрөнгийн байгууллагууд  |
| 28 | Энэ төлөвлөгөөний эрх, шийтгэлийн цөөхөн байдалтайн үүсгэх үгүйг үйлдүүлэн амьдралд оруулах   | 24 цагийн<br>аюул  | Тусгийн өргөн нутгийн Эсгэл дэргүүн<br>Тайвны тэргүүн комиссийн дахь             |
| 29 | Нийтийн хөөрөгний газар, хүүхдийн үйлдвэр, уудаага, үсэл хангалж, үс-<br>дэргүүн байгууламтын тийш эргүүлэн шударгалтай өндөрлүүлж<br>байдалтай нь хаяг үг гүйц, галдэргүүн нийг үсгийн шийтгэлтэй<br>ажал соргийн төгс нийгмэлдүүлэх | Төртний  | Аюул, нийгмэлтэй эрх үг үс-<br>дэргүүн гүйцэлтийн хангалтын<br>байгууллагууд     |
| 30 | Энэ төлөвлөгөөний амьдралын хангалтад ажл   | 1 сарын<br>үгдэлтэй  | Төг, өргөн нутгийн эрх үг<br>дэргүүн комиссийн байгууллагууд                     |
| 31 | Хаягдсан гүйцэлтийн амьтан үгүйг суугагч өргөн нутгийн хүүхдийг нэрүүлж<br>дэргүүн хангалтад хангалтад, шийтгэлтэй хангалтад шийтгэлтэй хангалтад<br>ажлал  | Төртний да-<br>ргүүн хангалтад<br>хөдөө үсг ж-<br>дэргүүн үг-<br>дэргүүн | Аюул, нийгмэлтэй, гүйц, дэргүүн<br>эргүүн хангалтын комиссийн бай-<br>гууллагууд |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 9 дүгээр  
сарын 11-ний өдөр

Дугаар 167

Улаанбаатар  
хот

Аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар авах  
зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэл"-ийг 1 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

2. Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх талаар 1995-2005 онд баримтлах үндсэн чиглэлийн хүрээнд 1995-1996 онд хэрэгжүүлэх ажлын гүйцэтгэл төлөвлөгөөг 2 дугаар хавсралтын ёсоор баталж, түүнийг хэрэгжүүлж, аялал зохион байгуулж ижиллэхыг Худалдаа, үйлдвэрлэл, нам (Ц.ЦОГТ), Байгаль орчны нам (З.БАТЖАРГАЛ), Дэд бүтцийн хөгжлийн нам (Р.САНДАЛХАН), Эрүүт мэндийн нам (Н.НИЙМДАВАА)-д даалгасугай.

3. Худалдаа, үйлдвэрлэл, нам (Ц.ЦОГТ)-д даалгах нь аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгыг хэрэгжүүлэх зорилгоор аялал жуулчлалын асуудлыг зохион зохиожийг зохион байгуулж амжилтуулсугай.

Баялал жуулчлалыг хөгжүүлэх улсын бодлого, хяналт, зохицуулалтын асуудлыг хяналт, зохицуулалтын хамт төв, орон нутагт аялал жуулчлалын үйлдвэр зохицуулалтын тогтолцоог бий болгох арга хэмжээг зориулж.

4. Монголыг дэмжинэ аргын орнуудад зөвхө шугамаар санал тавьж тохиролцооны үндсэн дээр Монгол Улсад аялал жуулчлалыг хөгжүүлэх аргын төлөвлөгөө (баскетер план)-г эдгээр оронтой хамтран боловсруулах арга хэмжээг 1995-1996 онд багтаан авахыг Худалдаа, үйлдвэрлэл, нам (Ц.ЦОГТ), Үндэсний хөгжлийн газар (Ч.УЛААН)-г даалгасугай.

З.Монгол Улсын Үндэсний оюун

П.ЖАСРАЙ

Худалдаа, үйлдвэрлэл, нам

Ц.ЦОГТ

МОНГОЛ УЛСЫН 1995 ОНЫ 167 ДУГААР  
ЧУЛГАЛЫН 1 ДҮГЭЭР ХАВСРАЛТ

## МОНГОЛ УЛСАД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР 1995-2005 ОНД БАРИМЦЛАХ ҮНДСЭН ЧӨГӨЛӨЛ

Аялал жуулчлалт нь дэлхийн ард түмнүүдийн хооронд харилцан ойлголцох, бие биеэ танин мэдэх, эдийн засагт нийлгэм, соёл-шинжлэх ухааны хамтын ажиллагааг өргөжүүлэх гол арга хэрэгсэл төдийгүй үз үйлдэгч экспортоо болзооноо хэрэгсэл өншөрлийн үндэсний үйлдвэртэй болон орлогын эх үүсвэрийг өсгөж, дэдл эрхлэлтийг нэмэгдүүлдэг, эдийн засагт чухал мөхөөр үзүүлдэг үр ашигтай салбар юм.

Монгол орны байгалийн урлагийн гурт байдал, цэвэр тунгалаг ус, агаар, төрөл бүрийн ховор ан амьтан, ургамал, байгалийн элдэв сонин тогтон, нүүдлийн соёл ирээдүй, монголын ард түмний зан заншил, ахуй, өвөрмөц аж төрөх зур, олон мянган жилийн түүх, соёл, археологийн ховор нандин дурсгалт нь тус оронд үндэсний аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэс болно.

Монгол улс олон улсын харилцаанд эрдэмтэй орохын хэрээр манай орны өвөрмөц онцлог байдалыг сонирхож танилцахаар ирж буй гадаадын аялагч, жуулчдын тоо өсөж хэдийнхэнэ байгаа нь дэлхийн аялал жуулчлалын байгууллагуудын мэдээ болон манай улсын мэргэжлийн байгууллагуудын судалгаанаас гаргалж байна.

Монгол орон дэлхийн аялал жуулчлалын нэгэн сонирхолтой бүс нутаг болон хөгжих нөхцөл боломж байгаа болон уг салбарын үр ашиг, эх холбоодлыг харгалзан гадна, дотоодын аялал жуулчлалыг тус орны хөгжлийн тэргүүтэй салбарын хөгжлэнд хүргэж хөгжүүлэх асуудлыг төр, засгийн бодлогын хөгжлэнд аял хэнэ.

Монгол Улсын үндэсний аялал жуулчлалын өөрийн орны аюулгүй байдал, олон улсын өмнө түүхтэй үүргийнхээ хүрээнд, дэлхий даяаны нийтлэг хандлага болж буй экологийн баримжаатий, эдийн засгийн тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн өнлөр үр ашигтай, бие даасан салбарын хөгжлэнд хүргэж хөгжүүлэх нь аялал жуулчлалын талаар баримцлах үндсэн чиглэл болно.

Энэхүү үндсэн чиглэлийг гэрээлж байдалар бүсчилж тодорхойлно.

1. Байгаль орчин, түүх, соёлын дурсгалт зүйлс, ард түмний ахуй, зан заншилын шинж чанарыг тусгасан өөр өөрийн онцлогтой,

үйлчилгээний өвөрмөц ялгаа чиглэлтэйгээр аялал жуулчлалыг бүсчилж хөгжүүлнэ. Үүнд:

-цэнгэг устай нуур, байгалийн үзэсгэлэн бүхий амьсгалын бүсэд усан онгоц, завиар аялах, үзэсгэлэнт байгаль, ан амьтан, шувуу ажиглах, боломжтой газарт загасчлах, өвлийн улиралд цана, тэшүүр, уулын цанын спортыг хөгжүүлэх, дархад цагаан ардын амьдрал ахуй, зан заншил, соёл, цааны аж ахуйтай танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ;

-монголын түүх, соёлын ховор нандин дурсгал, үзэсгэлэнт байгаль бүхий Орхон голын бүсэд эртний олон овог аймаг, улс гүрний үлдээсэн түүх, соёлын дурсгалт зүйл, хот, балгасын туурь, хөшөө, монголын модон сийлбэрийн урлаг, монголын эрд түмний ахуй соёл, зан үйлтэй танилцуулах, морь, сарлаг унуулах, загасчлах, рашаан эмчилгээ, сувилгаа хийлгэх, байгалийн элдэв сонин тогтоц, үзэсгэлэнт газрыг ажиглах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ;

-эх газрын говийн байгаль, ан амьтантай танилцуулах, говийн бүсэд говийн унаган төрхөөрөө байгаа эмзэг онгон байгаль, ургамал, цаг уурын үзэгдэл, байгалийн элдэв сонин тогтоц, ховор ан амьтанг ажиглах, эртний шим ертөнцийн үлдэгдэл, палеонтологийн олдворыг үзүүлэх, зөвшөөрөгдсөн зарим ан амьтанг агнуулах, нар, элсний эмчилгээ засал, сувилгаа хийх, тэмээний аж ахуйтай танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ;

-тал хээрийн онгон байгалийг харуулсан дорнод талын бүсэд уужим их тал хээрийн нутаг, ан амьтан, шувуу ажиглах, сөнөсөн галт уул, эртний хүн чулуун хөшөө, дэлхийн II дайны түүхийг харуулсан цогцолбор дурсгалтай танилцуулах, зээр, гөрөөс агнах, дорнод монголын эрд түмний зан заншил, соёл, ахуйтай танилцах, байгалийн халуун уур агаарыг эмчилгээ, сувилгаанд ашиглах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ;

-Их эзэн Чингис хааны амьдрал ахуйтай холбоотой Гурван голын сав нутгийн бүсэд Чингис хааны нэртэй холбоотой газар нутаг, хөшөө дурсгал, Хэнтий нурууны үзэсгэлэнт онгон байгаль, ан амьтан, Монголын эртний түүх, соёлын дурсгалт хөшөө, булш, бунхан, буриад зоны зан заншил, соёл ахуйтай танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ;

-өндөр уулын бүсийн байгалийг харуулах Алтай-Хангайн бүсэд мөнх цаст уул нуруу, Хадан уул, давст болон цэнгэг уст нуур, өвөрмөц сонин тогтоц бүхий байгаль, ан амьтан, баруун монголын олон ястны амьдрал ахуй, зан заншил, соёл, аж төрөх ёстой танилцах, зөвшөөрөгдсөн зарим ан амьтанг агнах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

-монголын ард түмний эртний болон одоогийн хөгжил дэвшлийг харуулах төвийн бүсэд төрөл бүрийн музей үзэх, нийслэл хотын байдалтай танилцах, хурал зөвлөлгөөн, бизнесийн уулзалт зохион байгуулах, Улаанбаатар хотын ойролцоох үзэсгэлэнт онгон байгаль, эртний түүх, соёлын дурсгалт зүйлтэй танилцуулах чиглэлтэй аялал жуулчлалыг хөгжүүлнэ.

Аялал жуулчлалын дээрх бүс нутагт биологийн төрөл зүйл, байгаль орчны тэнцвэрт байдлыг хангах, түүний даац боломжинд тохирсон хүч чадлаар барилга хот байгуулалтын орчин үеийн ололтыг үндэсний уламжлалтай зөв хосолсон шийдлээр байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээргүйгээр жуулчны баазыг барьж байгуулна.

Унаган байгаль орноо хамгаалах зорилгоор жуулчид, аялагчдыг тогтоосон чиглэл /маршрут/, замаар явуулна.

Аялал жуулчлалыг бүсчлэн хөгжүүлэх тусгай хөгөлбөр, төслүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. Байгаль, ахуй, эрдэм шинжилгээ, спорт, рашаан сувилал, агнуур, соёл, урлаг, бизнес, олон улсын хурал зөвлөлгөөн зэрэг аялал жуулчлалын олон төрлийг дангаар нь буеу хослуулахын зэрэгцээ төрөлжсөн жуулчлалыг түлхүү хөгжүүлэхэд анхаарна. Төрөлжсөн жуулчлалыг өндөр настан, залуучууд, хүүхэд, сурагчдынх гэж насны онцлог байдлаар ангилан зохион байгуулах болно.

Аялал жуулчлалын улирлын хэлбэлзлийг багасгах, өвлийн улиралд авах жуулчдын тоог нэмэгдүүлэх болно.

Өөрийн улсын иргэдийн дотооддоо жуулчлах, аялах нөхцөлийг бүрдүүлэн дэмжлэг үзүүлэх, зохион байгуулахад анхаарна.

2.Зочид буудал, жуулчны баазыг орчин үеийн шаардлагын дагуу хэд хэдэн төрлийн зоогийн газар, баар, үзвэр, худалдаа, тоглоом, спортын танхим, талбай, усан бассейн, халуун ус, утаалга, хими цэвэрлэгээ, шуудан холбоо, мөнгө солих үйлчилгээ, засмал зам, талбай, цэвэр бохир усны инженерийн шугам сүлжээ бүхий иж бүрнээр барьж байгуулна.

Орчин үеийн зочид буудлын аж ахуйг монгол гэртэй зохистой хослуулан хөгжүүлд, түүний тохилог байдлыг сайжруулах замаар жуулчдыг байраар хангана.

Аялал жуулчлалын зориулалтаар одоо ашиглаж байгаа зочид буудал, рашаан сувилал, жуулчны баазуудыг өргөтгөн шинэчилж үйлчилгээг сайжруулах замаар зэрэглэлийг нь ахиулж олон улсын жишигт ойртуулах арга хэмжээ авна.

Шинээр зочид буудал, жуулчны бааз, рашаан сувиллын объект

барих явдлыг дэмжинэ. Гадаадын хөрөнгө оруулалттай баригдах зочид буудал, жуулчны баазад ашиглах газрыг тодорхой хугацаанд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгож урамшуулна.

3. Аялал, жуулчлалын салбарыг мэргэжилтэй боловсон хүчнээр хангах асуудлыг мэргэжил, боловсролын талаар төрөөс явуулж буй бодлогын хүрээнд авч үзэж, аялал жуулчлалын салбарын боловсон хүчнийг шинээр болон давтан бэлтгэх тогтолцоог бий болгож, сургалтын хөтөлбөрийг шинэчилж сайжруулна.

4. Аялал жуулчлалын чиглэлтэй жуулчны бааз, зочид буудал, рашаан сувиллын объект, тээврийн байгууллага, зуучлах товчоог өмчийн бүх хэлбэрээр чөлөөтэй хөгжүүлнэ.

5. Жуулчны байгууллагуудаас жуулчдад үйлчлэх төрөл бүрийн үйлчилгээг дэлхийн жишигт ойртуулах арга хэмжээг авч, үйлчилгээний соёлыг дээшлүүлнэ. Жуулчны байгууллагын ажил, үйлчилгээг сайжруулах гол арга нь тус салбар дахь өрсөлдөөн гэж үзэж шударга өрсөлдөөнийг өрнүүлэх арга механизмыг бүрдүүлнэ.

6. Жуулчдад зориулан монголын үндэсний гэр урлалын болон бэлэг дурсгалын зүйлийн нэр төрлийг олшруулж, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлнэ. Түүх, соёлын дурсгалт цогцолбор, музей, үндэсний парк, байгалийн үзэсгэлэнт газар, ан амьтан, ургамал, соёл, урлаг, баяр наадмын арга хэмжээг харуулсан зургийн цомог, танилцуулга, зурагт хуудсыг олноор үйлдвэрлэж худалдаалах, түгээх ажлыг зохион байгуулна.

Бэлэг дурсгалын зүйл болон эх орны үйлдвэр, аж ахуйн нэгжийн бүтээгдэхүүний худалдааг зочид буудал, жуулчны бааз, жуулчны аяллын чиглэл, замын дагуу өргөнөөр зохион байгуулна.

7. Төр, засгаас гадаад, дотоодын аялал жуулчлалын талаар явуулах нэгдсэн бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулан зохицуулах үүрэг бүхий аялал жуулчлалын бие даасан байгууллагыг байгуулна. Тус байгууллага нь жуулчны байгууллагын үйл ажиллагаанд мэргэжлийн хяналт тавьж зэрэглэл тогтоох, аж ахуй эрхлэх эрх олгох, жуулчдын эрх ашгийг хамгаалах, жуулчны төрөл бүрийн үйлчилгээг дэлхийн жишигт ойртуулах арга хэмжээг авах, аялал жуулчлал хөгжүүлэх хөтөлбөр төслүүд боловсруулж хэрэгжүүлэх, аялал жуулчлалын асуудлаар гадаад хамтын ажиллагаа, сургалчилгаа болон боловсон хүчний нэгдсэн бодлого явуулахын зэрэгцээ тээвэр, соёл урлаг, байгаль орчин, худалдаа, хил, гааль, төв орон нутгийн төр, засгийн байгууллагуудтай аялал жуулчлалын байгууллагын ажлыг уялдуулан зохицуулах үүрэг гүйцэтгэнэ.

8. Дэлхийн болон бүс нутгийн олон улсын жуулчны байгууллагуудтай тогтоосон харилцаа холбоогоо улам өргөтгөж үйл



ажиллагаанд нь идэвхтэй оролцоно. Монголын аялал жуулчлалын байгууллагууд хөрш болон гадаадын бусад улс орнуудтай хамтын ажиллагааг төрөл бүрийн хэлбэр, удаан хугацааны, хөтөлбөрийн үндсэн дээр өргөжүүлэн хөгжүүлнэ.

9. Жуулчны урсгал ихтэй, өргөн зах зээл бүхий гадаадын зарим оронд Монголын жуулчны төлөөлөгчийн газрыг нээн ажиллуулж, өөрийн орны аялал жуулчлалын зах зээлийн сурталчилгааг идэвхжүүлэн оновчтой зөв хийж, аялал жуулчлалын зар сурталчилгаанд гадаад, дотоодын хэвлэл мэдээлэл, олон улсын хурал зөвлөлгөөн, үзэсгэлэн, яармагийг ашиглана.

Сурталчилгааны гол хэлбэр болох төрөл бүрийн танилцуулга, зурагт хуудас хэвлэн тараах, ердийн болон дүрс бичлэгийн кино хийж үзүүлэх, аялал жуулчлалын талаар жил бүр давлагааны материал гаргаж гүтээх арга хэмжээг авна.

10. Аялал жуулчлал хөгжих таатай нөхцөлийн нэг болох эдийн засгийн орчин, хөшүүргийг боловсронгуй болгох арга хэмжээ авна.

Зочид буудал, жуулчны бааз, рашаан сувилал, амралтын газруудын эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх механизмыг бүрдүүлэхийн зэрэгцээ жуулчинд олноор ирэх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор зочид буудал, жуулчны бааз, амралтын газар, олон улсын нислэгийн үнэ тарифт тодорхой хувь хэмжээгээр хөнгөлөлт үзүүлэхийг дэмжинэ.

Жуулчны байгууллагуудын эдийн засгийн албыг бэхжүүлж, бүртгэл тооцооны бүх ажлыг механикжуулж, орчин үеийн техник хэрэгслээр хангана. Аялал жуулчлалын бүртгэл статистикийн үзүүлэлтийн системийг бий болгож мэдээлэл дамжуулах журам тогтооно. Жуулчны мэдээлтийн санг шинээр бүрдүүлнэ.

Аялал жуулчлалын эдийн засаг, маркетингийн ойрын болон хэтийн хөгжлийн төлөвийг тодорхойлж, зах зээлийн эдийн засгийн харилцаанд нийцүүлэн хөгжүүлнэ. Жуулчны салбарт гадаадын хөрөнгө оруулалт хийх явдлыг дэмжинэ. Аялал жуулчлал нь валютын орлого оруулдаг үл үзэгдэгч экспортын бие даасан дэд салбарын хувьд Гадаадын хөрөнгө оруулалтын тухай Монгол Улсын хуульд заасан хөнгөлөлтөд хамааруулах асуудлыг боловсруулж шийдвэрлэнэ.

11. Гадаадын жуулчдыг Монгол Улсад, манай жуулчдыг гадаадын оронд байх үед тэдний эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг баталгаажуулах арга хэмжээ авч даатгалын журамд хамааруулна.

12. Аялал жуулчлалын бүс нутгийн дэд бүтцийг хөгжүүлэхэд онцгой анхаарна. Олон улсын агаарын тээврийн шугам, нислэгийн тоо, төмөр замын тээврийн аяллыг нэмэгдүүлэх зорилгоор хоёр

болон олон талын гэрээ, хэлэлцээрүүдийг гадаад улс орон, тээврийн байгууллагуудтай байгуулж ажиллана.

Жуулчны их ачааллын үед жуулчин солилцож байгаа орнуудын тээврийн байгууллагуудтай хамтарсан нислэг хийх, галт тэрэг, автобусны цуваа гаргах, тэдгээр орны нисэх онгоц, суудлын вагоныг түр хугацаагаар түрээслэх зэрэг үр ашигтай хэлбэрүүдийг ашиглана.

Жуулчид тээвэрлэх зориулалтын алсын болон дунд зайн нислэгийн орчин үеийн нисэх онгоц, дотоодын тээвэрт зориулан жижиг нисэх онгоц, нислэг тэрэг, суудлын автомашин, моторт завь худалдан авч ашиглана.

Жуулчны урсгал ихтэй аялал жуулчлалын гол бүс нутгуудад хатуу хучилттай нисэх, буух зурвас, зорчигчдын тохилог танхим бүхий нисэх онгоцны буудлууд барих, өргөтгөн шинэчлэх, аэродром, холбоо, навигацын тоног төхөөрөмжөөр тоноглоно. Мөн төмөр замын өртөө, автобусны тохилог буудлуудыг барих, өргөтгөн шинэчлэх арга хэмжээ авна.

Жуулчдын үйлчилгээнд зориулан суудлын автомашин, мотоцикль, унадаг дугуйгаар төлбөртэй үйлчлэх парк, цэгүүдийг байгуулах явдлыг дэмжинэ.

Аялал жуулчлалын бүс нутгийн авто замын сүлжээг хатуу хучилттай болгох, томоохон гол мөрөн дээр гүүр барих арга хэмжээг Монгол Улсад авто замын сүлжээг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөөтэй уялдуулан авч хэрэгжүүлнэ.

Жуулчны баазуудыг эрчим хүчний найдвартай эх үүсвэртэй болгох арга хэмжээ авна. Төвийн болон эдийн засгийн бусад бүсийн эрчим хүчний төвлөрсөн системд ойролцоо байрлалтай жуулчны баазуудыг цахилгаан дамжуулах өндөр хүчдэлийн шугамаар холбохын зэрэгцээ өвөр багатай, хүч чадал ихтэй, гүлш, шатахуун бага зарцуулаг, байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлдэггүй цахилгаан үүсгүүрүүдийг ашиглана.

Зочид буудал, жуулчны бааз, рашаан сувилал, жуулчдын тээврийн хэрэгслийг сансрын холбооны системтэй холбосон холбооны тоног төхөөрөмжөөр тоноглох арга хэмжээ авна.

Аялал, жуулчлалын тодорхой чиглэлээр бусад салбарын мастер төлөвлөгөөтэй уялдуулсан тусгай дэд хөтөлбөрүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ.

13. Түүх соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах, археологийн олдвор судалгааны зүйлийг үзүүлдэр байдлаар засч тохижуулан гадаад, дотоодын жуулчдад үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Одоогоор мэдэгдэж, судлагдсан зарим ховор нандин дурсгалыг тэргүүн ээлжинд сэргээн засварлахад анхаарна. Монголын түүхэнд

тодорхой үүрэг гүйцэтгэсэн хүмүүс, томоохон үйл явдлын талаар дурсгалын цогцолбор босгох, монгол үндэсний амьдрал ахуй, зан үйл, соёл болон байгальтай холбоотой төрөл бүрийн музей, үзэсгэлэн шинээр зохион байгуулах арга хэмжээ авна.

14. Аялал жуулчлалыг хөгжүүлэхийн хэрэгцээ байгаль орчныг хамгаалах ажлыг эрчимжүүлэх, түүний унаган төрх байдлыг алдагдуулахгүй байх, даац боломжоос нь хэтрүүлэхгүй байх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлнэ. Хүрээлэн буй орчинд аялал жуулчлалын үзүүлэх нөлөөллийг багасгах, аялал жуулчлалыг өөрийг нь байгаль хамгаалах нэг хэрэгсэл болгон ашиглахыг эрхэмтэнэ.

Засгийн газрын 1995 оны 167 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

**МОНГОЛ УЛСАД АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫГ ХӨГЖҮҮЛЭХ ТАЛААР  
1995-2005 ОНД БАРИМТЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛИЙН ХҮРЭЭНД  
1995-1996 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ХӨТӨЛБӨР-  
ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Хийх ажлын агуулга	Хугацаа	Хариуцан гүйцэтгэх байгууллага
1.	Аялал жуулчлалын тухай хуулийн төслийг боловсруулан Засгийн газарт оруулах, улмаар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр бэлтгэх	1995 оны III улиралд	Худалдаа, үйлдвэрийн яам
2.	Байгаль орныг тэнцвэрт байдлыг хангах, дагалдах үйлдвэрлэл, үйлчилгээ, дэд бүтцийг гүдгүү хөгжүүлэх, эдийн засгийн салбаруудын хөгжлийн ерөнхий бодлого, төлөвлөгөөтэй нарийн уялдуулах зэргийг баримтлан, аялал жуулчлалыг үндэсний өвөрмөц байдал, онцлогтой хослуулж бүсчлэн тодорхой төрөл, чиглэлээр хөгжүүлэх төслүүдийг боловсруулан эхний хэлжийн арга хэмжээг тодорхойлон хэрэгжүүлж эхлэх. Үүнд:		
	а/Ховсголийн бүсийн төсөл	1995 оноос	Худалдаа, үйлдвэрийн яам, Дэд бүтцийн

			хөгжлийн нам, Байгаль орчны нам, "Монтех-Ориол" ББХК, Ховсгал аймгийн Засаг даргын Тамгын газар
б/Орлон голын бүс / Өвөрхангайн чиглэл/	1996 оны I хагасаас		Худалдаа, үйлдвэрийн нам, Дэл бүтцийн хөгжлийн нам, Эрүүд мэндийн нам, Соёлын нам, холбогдох аймгуудын Засаг даргын Тамгын газар
в/говийн бүс	1995-1997 онд		Худалдаа үйлдвэрийн нам, Эрүүд мэндийн нам, Байгаль орчны нам, Омноговь аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох аж ахуйн нэгжүүд
г/ Дорнодын бүс	1996-1997 онд		Худалдаа, үйлдвэрийн нам, Эрүүд мэндийн нам, Байгаль орчны нам, Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газар
д/Хэнтийн бүс	1995-1997 онд		Худалдаа, үйлдвэрийн нам, Эрүүд мэндийн нам, Байгаль орчны нам, Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар, холбогдох аж ахуйн нэгжүүд
е/баруун бүс	1996 оноос		Худалдаа, үйлдвэрийн нам, Эрүүд мэндийн нам, Байгаль орчны нам, холбогдох аймгуудын Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгжүүд
ж/товийн бүс	1995-1997 онд		Худалдаа, үйлдвэрийн нам, Эрүүд мэндийн нам, Байгаль орчны нам, холбогдох аймгуудын Засаг даргын Тамгын газар, аж ахуйн нэгжүүд
Бүсийн ерөнхий төслийн хүрээнд хэрэгжүүлж болох, одоо боловсруулагдаад байгаа төслүүдийн талаар: -сонгон шалгаруулалт хийх, шаардлагатай зарим төслийг шинэчлэх буюу тодорнон	1995		Худалдаа, үйлдвэрийн нам,

	өөрчлөх ажлыг зохион байгуулах			
	-боловсруулсан төслийг хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэрийн асуудлыг шийдвэрлэх	1995-1996 онд	Худалдаа, үйлдвэрийн яам, Сангийн яам	
4.	Аялал жуулчлалын салбарт галаадмын хөрөнгө оруулалтыг хохуулэн дэмжих талаар санал боловсруулж Засгийн газарт оруулах	1995 оны IV улиралд	Худалдаа, үйлдвэрийн яам	
5.	Аялал жуулчлалын бааз, үйлдвэр, үйлчилгээний нэгүүд, жонд буудал, рашаан сувилалд зэрэглэл тогтоох асуудлыг үндэсний нэгдсэн стандартчоллын хүрээнд шийдвэрлэх	1995 онд	Худалдаа, үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Үндэсний стандартчолал, хэмжээл зүйн төв	
6.	Олоо ажиллаж байгаа жуулчдын бааз, үйлчилгээний нэгүүд, рашаан сувилал, жонд буудлын зэрэглэлийн түвшинг тогтоож, аттестагчлох	1995-1996 оны II улиралд	Худалдаа, үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар	
7.	Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах эрх бүхий аж ахуйн нэгжүүдийг аттестагчлох	1995 оны III улиралд	Худалдаа, үйлдвэрийн яам	
8.	Аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах эрх олгох, хяналт тавих журмыг шинэчлэх	1995 онд	Худалдаа, үйлдвэрийн яам	
9.	Нүүдлийн нөхцөлд зохиц-сон үндэсний аялал жуулчлалын баазын загвар боловсруулан турших арга хэмжээ авах	1995-1996 оны II улиралд	Худалдаа, үйлдвэрийн яам, Дэд бүтцийн хөгжлийн яам	
0.	Ресторан, баар, зоогийн газруудад галаадмын жуулчдад үйлчлэх эрх олгох журам боловсруулан хэрэг-жүүлэх	1995 оны IV улирлаас	Худалдаа, үйлдвэрийн яам	
1.	Аялал жуулчлал хөгжүүлэх, бүс чиглэлийг бодолцон "Адуучин" бааз байгуулах боломжийг судлан, 1996 онд Төв аймагт бий болгож турших	1996 оноос	Худалдаа, үйлдвэрийн яам, аймгуудын Засаг даргын Тамгын газрууд, үүний дотор Төв аймгийн Засаг даргын Тамгын газар	
2.	Аялал жуулчлал эрхлэх аж ахуйн нэгжид байвал зохих	1995 оны III улиралд	Худалдаа, үйлдвэрийн яам	

- |     |  |                       |  |   |
|-----|--|-----------------------|--|---|
|     | мэргэжилтний жагсаалтыг ангилал бүрээр гаргаж батлах   |                       |  |   |
| 13. | Дотоодын их, дээд сургууль, коллежид аялал жуулчлалын мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлэх арга хэмжээ авах  | 1996 оноос            | Шинэжлэх боловсролын Хуудалдаа, нам үйлдвэрийн нам   | ухаан, нам, үйлдвэрийн  |
| 14. | Мэргэжлийн мэргэжилтэй багш, боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах санал боловсруулж, шийдвэртэй                                      | 1996 оноос            | Хуудалдаа, Шинэжлэх боловсролын Засгийн газрын Хэрэг эрхлэх газар  | үйлдвэрийн нам, ухуан, нам, Хэрэг эрхлэх газар  |
| 15. | Аялал жуулчлалын боловсон хүчин бэлтгэж буй гадаад орны туршлагыг судлах, улмаар боловсон хүчин бэлтгэх сургалтын шатлал, агуулгын стандарт тогтоох, багшлах боловсон хүчин болон ном, сурах бичиг бэлтгэх | 1996 оноос            | Хуудалдаа, Шинэжлэх боловсролын нам  | үйлдвэрийн ухуан, нам   |
| 16. | Хөрш орнуудтай жуулчлон солилцох ажлыг зохих журам, зохион байгуулалттай хэрэгжүүлж байх асуудлыг хэлэлцэн шийдвэртэй  | 1995 оноос            | Хуудалдаа, Улсын ерөнхий газар, Хилийн цэргийг удирдах газар   | үйлдвэрийн нам, гаалийн ерөнхий газар, Хилийн цэргийг удирдах газар   |
| 17. | Жуулчлалын салбарт хамтран ажиллах хэлэлцээрийг ОХУ-тай шинэчлэн байгуулах   | 1995 оноос            | Хуудалдаа, Шинэжлэх боловсролын нам  | үйлдвэрийн нам  |
| 18. | Манай улсад байгаа аялал жуулчлалын баяр, рашаан ус төрөл, бүс, чиглэл зэргийг тусгасан сурталчилгааны материалыг хэвлүүлж, цаашид байнга шинэчлэн тодотгож байх, гадаад сурталчилгааг эрчимжүүлж          | 1995 оноос            | Хуудалдаа, Байгаль орны нам, Соёлын нам, Эрүүд мэндийн нам, аймгуудын Засаг даргын Тамгын газар (нийгэмлэг, холбоотой камеран) | үйлдвэрийн нам, Байгаль орны нам, Соёлын нам, Эрүүд мэндийн нам, аймгуудын Засаг даргын Тамгын газар (нийгэмлэг, холбоотой камеран) |
| 19. | Гадаадын жуулчдыг хүтээн авах ор хоногийн тухайн жилдний боломжийг гаргаж байх   | 1995 оны III улирлаас | Хуудалдаа, Эрүүд мэндийн нам   | үйлдвэрийн нам, Эрүүд мэндийн нам   |
| 20. | Жуулчдын үйлчилгээний гүйшлэг дээшлүүлж, аюулгүй, тав тухтай байлгах зорилгоор аялал жуулчлалын  | 1995 оны II улирлаас  | Хуудалдаа, Шинэжлэх боловсролын нам  | үйлдвэрийн нам  |

- гэрээг бүртгэж байх
21. Аялал жуулчлалын талаар статистик мэдээ гаргаж байх журмыг боловсруулан мөрдүүтэх 1995 оны III улирлаас Худалдаа, үйлдвэрийн яам, Улсын статистикийн газар, Хилийн цэргийг удирдах газар
22. Салбарын статистик-мэдээллийн санг бий бол-гох арга хэмжээ авах 1995-1996 онд Худалдаа, үйлдвэрийн яам, Улсын статистикийн газар
23. Жуулчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангах, даатгалд хамрааруулж байх талаар журам боловсруулж, хэрэгжүүлэх 1995 онд Худалдаа, үйлдвэрийн яам, Эрүүл мэндийн яам, Сангийн яам, Цагдаагийн ерөнхий газар, даатгалын байгууллагууд
24. Жуулчдыг хил, гаалиар нэвтрэхэд хөнгөн шуурхай, зохих журмын дагуу үйлчилж байх арга хэмжээ авах, энэ талаар гарч байгаа гомлол, мэдээллийг тухай бүр барагдуулж байх 1995 оноос Улсын гаалийн ерөнхий газар, Хилийн цэргийг удирдах газар
25. Аялал жуулчлалын статистик-мэдээллийн сан, боловсон хүчнийг бэлтгэх бөхөн бусад чиглэлийн орчин үеийн техникээр тоноглох боломжийн талаар санал боловсруулж Засгийн газарт танилцуулах 1995 оны III-IV улиралд Худалдаа, үйлдвэрийн яам, Улсын статистикийн газар, Шинэжлэх ухаан, боловсролын яам, Хилийн цэргийг удирдах газар
26. Монголд ирж байгаа гадаадын жуулчдын өдөрлөг ( бхэрэг наадма)-ийг жил бүрийн 8 дугаар сард гэмдэлэх тусгай хөтөлбөр боловсруулан зохион байгуулах 1995 оноос Худалдаа, үйлдвэрийн яам, нийслэл, Төв аймгийн Засаг даргын Тамгын газар
27. Олон улсын жуулчдыг байгууллагад сүүлийн жилүүдийн татварыг төлөх 1995 оны III улиралд Худалдаа, үйлдвэрийн яам, аялал жуулчлалын холбогдох байгууллагууд
28. Тусгай хамгаалалттай болон дархан цаазтай газар, байгалийн цогцолбор газар, түүх, соёлын дурсгалт зүйл оршиж буй газар нутгийн аялал жуулчлалын чиглэл (маршрут), баазын байршлыг тогтоох 1995 онд Худалдаа, үйлдвэрийн яам, Байгаль орны яам, Соёлын яам, холбогдох аймгуудын Засаг даргын Тамгын газар
29. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах, сэргээн засварлах, шинээр ил музей байгуулах, түүнийг тойрсон 1995 оноос Худалдаа, үйлдвэрийн яам, Соёлын яам, холбогдох төв, орон нутгийн байгууллагууд

үйлчилгээний цогцолбор бий болгож, жуулчдын үтэх үзвэр, үйлчилгээг нэмэгдүүлэх чиглэлээр тусгай төслүүд боловсруулан хэрэгжүүлэх арга хэмжээ авах (Өмчийн бүх хэвшлийн нэгжүүдтэй хамтран)

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1995 оны 9 дүгээр  
сарын 15-ны өдөр

Дугаар 169

Улаанбаатар  
хот

Тусгай хамгаалалттай зарим газар  
нутгийн хамгаалалтын горим,  
хилийн тэсийг батлах тухай

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн 26 дугаар зүйлийн 5, 6-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1. "Дархан цаазат газрын хамгаалалтын нийтлэг горим"-ыг 1 дүгээр хавсралтын, "Байгалийн цогцолборт газрын хамгаалалтын нийтлэг горим"-ыг 2 дугаар хавсралтын, "Дархан цаазат болон байгалийн цогцолборт зарим газрын тусгай горим"-ыг 3 дугаар хавсралтын, ёсоор тус тус баталсугай.

2. Байгалийн нөөц болон дурсгалт зарим газрын хилийн заагийг 4 дүгээр хавсралтын ёсоор баталсугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын дор дурдсан тогтоол, тогтоолын заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

а/ "Дүрэм батлах тухай" 1991 оны 7 дугаар сарын 15-ны өдрийн 217 дугаар тогтоол;

б/ "Дархан цаазтай газар, байгалийн үндэсний цогцолборт газар болгож, тэдгээрийн хилийн цэс, хамгаалалтын горимыг батлах тухай" 1992 оны 2 дугаар сарын 22-ны өдрийн 31 дүгээр тогтоол;

в/ "Дүрэмд өөрчлөлт оруулах тухай" 1992 оны 2 дугаар сарын 26-ны өдрийн 36 дугаар тогтоол;



г/"Зарим газар нутгийг улсын тусгай хамгаалалттай болгох тухай" 1992 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн 64дүгээр тогтоолын 1-5 дугаар зүйл;

д/"Тусгай хамгаалалттай газрын хилийн цэс, хамгаалалтын горимыг батлах тухай" 1994 оны 1 дүгээр сарын 12-ны өдрийн 9 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "Хустай, Угтаалын болон Шарга, Манханы байгалийн нооц газар, Ганга нуурын дурсгалт газрын хилийн цэсийг 1 дүгээр хавсралтын ёсоор ... баталсугай" гэснээс бусад хэсэг, 2,4 дүгээр зүйл;

е/"Улсын тусгай хамгаалалттай зарим газрын хилийн цэс, хамгаалалтын горимыг батлах тухай" 1994 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн 95 дугаар тогтоолын 1,2 дугаар зүйл.

Монгол Улсын Ерөнхий сайд

П.ЖАСРАЙ

Байгаль орчны сайд

З.БАТЖАРГАЛ

Засгийн газрын 1995 оны 169 дүгээр  
тогтоолын 1 дүгээр хавсралт

## ДАРХАН ЦААЗАТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН НИЙТЛЭГ ГОРИМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Энэхүү нийтлэг горим нь төр, захиргааны хийгээд дархан цаазат газрын хамгаалалтын бүх шатны болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс дархан цаазат газар, түүний орчны бүс нутагт явуулах үйл ажиллагааг тухайн дархан цаазат газрын хамгаалалтын дэглэм, түүний орчны бүс нутгийн нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан зохицуулахад оршино.

2.Дархан цаазат газар, түүний орчны бүс нутагт явуулах үйл ажиллагааг Газрын тухай болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль энэ нийтлэг горимд нийцүүлэн зохицуулж зохион байгуулах ажлыг дархан цаазат газрын хамгаалалтын асуудал хариуцсан төрийн захиргааны холбогдох байгууллага эрхлэн хэрэгжүүлнэ.

3. Дархан цаазат газарт явуулах аливаа үйл ажиллагаа нь дархан цаазат газрын хамгаалалтын дэглэмийг чандлан сахиж, түүний байгаль орчны тэнцвэрийг хадгалахад чиглэгдэнэ.

4. Энэхүү нийтлэг горимыг дархан цаазат газрын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага иргэн дагаж мөрдөх үүрэгтэй.

5. Шаардлагатай гэж үзвэл дархан цаазат газарт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн хүрээнд дагаж мөрдөх хамгаалалтын тусгай горимыг Засгийн газраас тогтооно.

### Хоёр. Хамгаалалтын нийтлэг горим

6. Дархан цаазат газрын хуулиар зөвшөөрөгдсөн бүсэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн үйл ажиллагаа явуулахдаа дор дурдсан журмыг баримтална:

а/Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль болон энэ горимд заасны дагуу тухайн газрыг хамгаалах, нөхөн сэргээх талаар ногдуулсан үүргийг хэрэгжүүлэх;

б/аливаа судалгаа, шинжилгээний ажлыг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдсэн төслийн үндсэн дээр хэрэгжүүлж байх;

в/аливаа ажил, үйлчилгээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр явуулахдаа дараахь журам, дэглэмийг мөрдлөг болгох:

-байгалийн аялал, жуулчлалыг зөвшөөрөгдсөн бүсэд гал түймрийн аюулгүй үед зохион байгуулах;

-хөрсний нөхөн сэргээлт, ойн арчилгаа цэвэрлэгээг мод ургамал ургаж цэцэглэх, ан амьтан үржиж төллөх, ороо хөөцөлзөөннийхөөс бусад үед хийхээс гадна ан амьтаны байршил, байгальд сөрөг нөлөөгүй арга, технологи, техник, багаж хэрэгслийг ашиглах, тухайн газар нутагт ургадаг ургамал, модны үр, тарьц хэрэглэх;

-ан амьтныг тоолох болон тэдгээрийг хамгаалах, өсгөн үржүүлэх зориулалттай биотехникийн арга хэмжээг ан амьтны үржиж төллөхөөс бусад үед тэдний байршилыг алдагдуулах, байгаль орчинд сөрөг нөлөөлөхөөс сэргийлэх арга хэмжээг урьдчилан авсны үндсэн дээр хэрэгжүүлж байх;

-рашлан, эмчилгээ, сувилгааны чанартай бусад эрдсийг байгалийн тэнцвэрт байдалд нь харилцахгүйгээр ашиглах;

-уул овоо тахиx, уламжлалт зан үйлийн ёслол үйлдэх, зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, тэдгээрийг зохиод бүтээл туурвихад ашиглахдаа экологид сөрөг нөлөөлөхгүй арга технологи ашиглах;

-нутгийн оршин суугчид ахуйн хэрэгшээндээ байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг түүж ашиглахдаа орчны гэнцвэрт харьцаа, нөөцөд сөрөг нөлөөлөхөөргүй энгийн арга хэрэглэх;

-ашиглаж байгаа нутаг дэвсгэр, байгалийн нөөц баялагт зохих журмын дагуу зохион байгуулалт, хянан баталгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэж байх;

-газар ашигласны болон бусад ажил, үйлчилгээ явуулж орлого олсны төлбөр, хуралэмжийг зохих журмын дагуу цаг хугацаанд нь талэх;

-орчныхоо байгалийг хамгаалах асуудлыг хариуцаж, зөрчил гарсан тохиолдолд хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдад тухай бүр мэдэгдэж байх;

-аж ахуйн нэгж, байгууллага, иргэн зөвхөн тогтоож өгсөн газарт хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулж, өөрийн ашиглаж, нутаглаж байгаа газрыг эвдрэл, бохирдлоос хамгаалах, талхлагдсан хөрс, ургамлыг нөхөн сэргээх, баталсан зураг төслөөр орчноо тохижуулж, хамгаалалтын захиргаанаас биотехникийн болон бусад арга хэмжээ авахад туслалцаа үзүүлэх;

-ашиглах газрынхаа бүртгэл зураглалыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн жил бүр тодотгож байх;

-үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх, тусгай буутдах, барилга байгууламжийг бусдад шилжүүлэх хөлслүүлэх, түрээслүүлэх зэрэг тохиолдолд тухайн хамгаалалтын захиргаанд мэдэгдэж гэрээнд нэмэлт өөрчлөлт хийлгэж байх;

-ой хээрийн түймэрт өртөж болзошгүй газарт байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага түймрээс сэргийлэх арга хэмжээ авч түймэртэй тэмцэх багаж хэрэгслийг бэлтгэсэн байхаас гадна жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 1,8 дугаар сарын 20-ноос 10 дугаар сарын 15-ны хооронд байгаль хамгаалагчдад туслах өндөржүүлсэн бэлтгэлтэй жижүүр, эргүүл томилон ажиллуулж байх.

7.Хязгаарлалтын бүсээс байгалийн дагалт баялгийг нутгийн иргэд үр жимс нь боловсорч гүйцсэн үед байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга,технологиор,ахуйн хэрэгшээндээ түүж ашиглаж болно.

8.Аж ахуйн нэгж, байгууллага иргэн газраа зориулалтын дагуу ашиглаж зөвхөн гэрээнд заагдсан үйл ажиллагаа явуулна.

9.Дархан цаазат газрын нутаг дэвсгэрт аливаа ажил үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж,байгууллага,иргэн нь зохих журмын дагуу зөвшөөрөл авсан байна.

10.Улсын хилийн дагуу байрладаг дархан цаазат газрын нутаг дэвсгэрийн улсын хилтэй нийлсэн хэсэгт хил хамгаалалтын

зориулалттай инженер, техникийн төхөөрөмжийг байрлуулж мөр хянах зурвасыг зохих заавар, журмын дагуу байгуулж болно.

11. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн судалгаа шинжилгээний ажил явуулахдаа дараахь журмыг баримтална:

а/ судалгаа шинжилгээний ажлыг зөвшөөрөлд хэсэг газарт, тогтоосон хугацаанд батлагдсан хөтөлбөрийнхээ хүрээнд хийх;

б/ хамгаалалтын бүсэд байгалийн төрх байдал, ус, хөрс, ургамал, амьтны аймгийн онцлог, тэдгээрийн хувьсал, өөрчлөлттэй холбогдсон судалгаа шинжилгээний ажил явуулахдаа байгаль орчинд аливаа өөрчлөлт, сөрөг нөлөөгүй арга хэлбэрийг хэрэглэх;

в/ судалгаа шинжилгээний ажлын хугацааг сунгах, үргэлжлүүлэн хийх шаардлага гарвал холбогдох үндэслэл, тооцоо гарган, үр дүнг тодорхойлж, хамгаалалтын захиргааны санал, дүгнэлтийг авч байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

12. Дархан цаазат газрын нутаг дэвсгэрийг дайран гарсан улс, орон нутгийн чанартай авто замаар зорчих иргэн, түүнчлэн дархан цаазат газрын нутаг дэвсгэрт хяналт шалгалт хийх үүрэг бүхий албан тушаалтан тухайн дархан цаазат газраар зөвшөөрөл авахгүйгээр нэвтэрч болно.

13. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дархан цаазат газарт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

а/ аялал, жуулчлалын тогтоосон зам чиглэл, амрах, отоглох цэгийг дур мэдэн өөрчлөх, тогтоосноос бусад газарт ил задгай гал түлэх, үнс нурмаа унтраалгүй орших;

б/ улсын хилээр нүүдэллэн орж, гарч байгаа цагаан зээр, хавтгай, хулан, аргаль, янгир зэрэг нүүдлийн амьтдын хөдөлгөөн, байршилд саад учруулж, үргээх, дүрвээх;

в/ улсын хилийн дагуу орших дархан цаазат газарт хил залгаа гадаад улсаас мал отроор оруулах, гадаадын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр өвс хадлан, давс хужир бэлтгүүлэх, ан амьтанд зохиомлоор мараа бэлтгэх, байшин барилга барих,

г/ улс, орон нутгийн чанартай авто замаар зорчигчид тогтоосон зам, чиглэлийг өөрчлөх, хяналт шалгалт хийх албан тушаалтан өөрийн албан үүрэгт холбогдолгүй бусад үйл ажиллагаа явуулах;

д/ Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль, энэ горимд зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулах.

Гурав. Хамгаалалтын нийтлэг горимыг  
хэрэгжүүлэх үйл ажиллагаа

14. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв, орон нутгийн байгууллага, албан тушаалтан дархан цаазат газар, түүний орчны бүсэд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай болон Газрын тухай Монгол Улсын хуулийн холбогдох заалт, энэхүү нийтлэг горимыг дагаж мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

15. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн 27 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг зохицуулна:

а/дархан цаазат газрын онгон бүс, хамгаалалтын бүс, хязгаарлалтын бүсийн заагийг газрын зурагт тэмдэглэн баталгаажуулах;

б/дархан цаазат газрын хилийн заагтай залгаа орших орчны бүс нутгийн иргэдийн дархан цаазат газрыг хамгаалахад гүйцэтгэх үүргийн чиглэлийг гаргаж өгөх;

в/дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд байрласан аж ахуйн нэгж, байгууллага, тэнд байнга оршин суудаг иргэдээс хамгаалалтын дэглэм, энэ горимыг мөрдөхтэй холбогдуулан гүйцэтгэх үүргийн чиглэлийг тогтоож, тэдгээртэй байгуулах гэрээний загварыг батлан гаргах;

г/дархан цаазат газрын зохих бүсээс байгалийн дагалт баялаг ашигласны болон тэдгээрт хуульд заасан ажил, үйлчилгээ явуулсны төлбөр, хураамж тогтоох талаар санал боловсруулж зохих хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлүүлэх, тэдгээрийн орлогоос байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зориулсан хэсгийг хуваарилах, захиран зарцуулах журмыг санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтоох;

д/аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд ашиглуулах газрын байршил, дээд хэмжээг тухайн дархан цаазат газрын онцлогтой уялдуулан тогтоох;

е/дархан цаазат газрын газар болон байгалийн баялгийн ашиглалт, хамгаалалттай холбогдсон данс, бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөглөх, тайлагнах журмыг холбогдох төв байгууллагатай хамтран баталж мөрдүүлэх;

ж/дархан цаазат газрыг судлан шинжлэх, ашиглах, сурталчилгах зорилгоор хуулиар зөвшөөрөгдсөн бүсэд ажиглалт

туршилт явуулах, дүрс бичлэг хийх, кино зураг авах зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд зохих журмын дагуу олгох:

з/аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран буюу дангаараа дархан цаазат газрын хамгаалалт, ашиглалтын асуудлаар хууль, тогтоомжид нийцсэн шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

и/хязгаарлалтын бүсэд байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагуудын үйл ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах, тэднээс байгаль хамгаалалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох:

к/дархан цаазат газрын бүртгэл, зураглалын ажлыг мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлж нэгдсэн дүнг мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах;

д/дархан цаазат газрын ашиглалт, хамгаалалтын талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хамгаалалтын асуудал хариуцсан боловсон хүчнээр хангах, дархан цаазат газрын хамгаалалтыг хариуцсан байгууллагыг санхүү, аж ахуйн хувьд бэхжүүлэх, хөрөнгө оруулах, санхүүжүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авах.

16. Нийтлэг горимыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага дор дурасан асуудлыг хамтран зөвшилцөж зохицуулна:

а/хязгаарлалтын болон орчны бүсэд байрласан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн ашиглах газрын хэмжээг тогтоох, тухайн газар нутгийг хамгаалах, нөхөн сэргээх, дархан цаазат газрын дэглэм, энэ горимыг дагаж мөрдөхөд тэдний гүйцэтгэх үүргийг тохироцгож тэдэнтэй гэрээ, хэлцэл байгуулж дүгнэх;

б/аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд ашиглуулахаар олгосон газарт газар болон байгалийн нөөц баялгийн зохион байгуулалт, хянан баталгааг тэдгээрийн зардлаар хийлгэх ажлыг зохион байгуулах;

в/цаг агаарын хүндрэл тохиолдсон үед хязгаарлалтын бүсэд мал оруулах, отор нүүдэл хийх, өвс хадлан бэлтгэх болон бусад асуудлаар хууль тогтоомжинд нийцүүлэн түр журам гаргаж мөрдүүлэх;

г/байгалийн баялгийн нөөц нь хомсодсон, төлөв байдал нь өөрчлөгдөн доройтолд орж татхлагдсан газар нутгийг сэргээн сайжруулах арга хэмжээ авах.

17. Дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа энэхүү горимыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дор дурдсан үйл ажиллагааг зохицуулна:

а/Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу шинжилгээ судалгаа, тооллого

вуулах, дээж, сорьц авах, хэмжилт хийх, ой арчлах, хөрс, ургамлыг  
өхөн сэргээх, хортон шавьж, мэрэгчид, гүймрээс сэргийлэх,  
загээртэй тэмцэх, рашаан, эмчилгээ сувилгааны зориулалттай  
усад эрдэс, байгалийн баялгийг ашиглах, аялал, жуулчлалыг зохион  
айгуулах зэрэг үйл ажиллагаа эрхлэхээр байгаль орчны асуудал  
ариусан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан,  
саят уг үйл ажиллагааг эрхлэх үүрэг бүхий аж ахуйн нэгж,  
айгууллага, иргэнтэй үйл ажиллагааных нь хүрээ, хамтрах нутаг  
эвсгэр, ашиглах технологи, арга хэлбэр, техник, тоног төхөөрөмж,  
агаж хэрэгслийг тохиролцож гэрээ байгуулах, гэрээний  
эрэгжилтийн явцад хяналт тавьж биелэлтийг нь тогтоосон  
угааанд дүтнэж байх.

б/дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд байнга оршин  
уудаас бусад иргэн тухайн бүсэд түр нэвтрэн орж уг газар  
утагтай танилцах, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах  
ол тэдэнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол  
Улсын хуульд заасны дагуу ийнхүү үйл ажиллагаа эрхлэн явуулах  
зөвшөөрөл олгож, хяналт тавих;

в/зохиох зөвшөөрлийн дагуу дархан цаазат газрын нутаг  
эвсгэрт ажил, үйлчилгээ явуулсны болон байгалийн дагалт баялаг,  
цар ашигласны төлбөр, хураамжийг аж ахуйн нэгж, байгууллага,  
иргэнээс хураан авч зохиох орлогод оруулах ажлыг зохион  
ийгуулахад тусалж дэмжих;

г/дархан цаазат газрыг хамгаалахад зориулан олгосон  
эрэнгийг үр ашигтай захиран зарцуулах;

д/дархан цаазат газрын хилийн заагийг Улсын Их Хурлаас  
италсны дагуу, түүний онгон, хамгаалалтын, хязгаарлалтын болон  
орчны бүсийг байгаль орчны асуудал хариусан төрийн захиргааны  
айгууллагаас тогтоосны дагуу гэмдэгжүүлэх, сэргээх ажлыг  
илбоддох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

е/хязгаарлалтын бүсэд гэрээгээр газар ашиглаж байгаа аж  
ахуйн нэгж, байгууллага, иргэний газар ашиглалтад хяналт тавих,  
идний газрын хэмжээг жил бүр тодотгож байх;

ж/аялал, жуулчлалын зам, нэвтрэх гарцыг чиглэлийн дагуу  
мэдэгжүүлэх, аялагчид, жуулчид байнга болон түр буудаллах цэг,  
иртанилгааны байр байгуулах, тэдгээрийг тохижуулах;

з/байгалийн төрх байдалд нөлөөгүйгээр шинжилгээ  
далгааны ажил явуулах, ажиглалт, судалгаа хийх цэгийн байршлыг  
итгоох, байгуулах, тохижуулах;

и/байгаль хамгаалагчдын байршлыг сонгон тогтоож,  
ариусан нутаг дэвсгэрт нь байршуулах, тэдний ажиллах, амьдрах  
эхцэлийг хангах, дархан цаазат газрын хамгаалалтын дэглэмийг

сахих шаардлагад нийцүүлэн мал аж ахуй эрхлэх, хадлан тэжээл бэлтгэх газрыг нь зохицуулж өгөх;

к/хязгаарлалтын бүсэд байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, байгальд удаа дараа сөрөг нөлөөлсөн тохиолдолд тэдгээрийн үйл ажиллагааг нь таслан зогсоох буюу түүнтэй холбогдсон санал дүгнэлт гаргаж зохиох эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

л/аялал, жуулчлал эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагын хүнийг аялагч, амрагчдад зориулсан байр бий болгох, тохижуулахад татан оролцуулах;

м/дархан цаазат газарт байгаа байгаль, түүхийн дурсгалт газруудын бүртгэл гаргах, түүх соёлын дурсгалыг сэргээхэд туслалцаа үзүүлэх;

н/дархан цаазат газрын хувийн хэргийг эрхлэн хөтөлж жил бүр тодотгон баяжуулж, байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тайлагнаж байх;

о/дархан цаазат газрын бүртгэл зураглалын ажлыг мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлж нэгдсэн дүнг мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах;

п/ан амьтдын сүргийн нягтшил, өвчин эмгэгийг мэргэжлийн байгууллагаар судлуулан тогтоолгож, өвчин эмгэгийн тархалтад хяналт тавьж, эрүүлжүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагаар авахуулж байх;

18.Орон нутгийн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а/иргэдэд дархан цаазат газрын тухай болон тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж, заавар, журмыг сурталчлах;

б/хамгаалалтын захиргаанаас хийж байгаа ажилтай танилцах, тэдний сонсгол, илтгэлийг авч хэлэлцэх, заавар, зөвлөлтөө өгөх;

в/дархан цаазат газрын орчны бүсэд байгалийн баялаг ишиглах /мод бэлтгэх, ан амьтан агнах, барих, ашиглах, геологийн хайгуул хийх, газар тариалан эрхлэх зэрэг/ ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд зөвшөөрөл олгохдоо хамгаалалтын захиргаанд мэдэгдэж байх.

19.Хамгаалалтын захиргаа нь өөрийн хариуцан хамгаалж байгаа нутаг дэвсгэрийнхээ байгальд учруулсан хохирлын хэмжээг тухайн баялгийн экологи, эдийн засгийн үнэлгээ, уг баялгийг нөхөн сэргээх зардлын нийт дүнгээр тооцож гэм буруутай аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр нөхөн төлүүлдэг.



20. Дархан цаазат газрын нутаг дэвсгэрт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль, бусад хууль тогтоомж, энэ горимыг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрх бүхий улсын байцаагч хууль тогтоомжийн дагуу торгууль, тэлбөр ногдуулна.

Засгийн газрын 1995 оны 169 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

## **БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН НИЙТЛЭГ ГОРИМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү нийтлэг горим нь төр, захиргааны хийгээд байгалийн цогцолборт газрын хамгаалалтыг хариуцсан бүх шатны болон бусад байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс байгалийн цогцолборт газар /цаашид "цогцолборт газар" гэнэ/, түүний орчны бүс нутагт явуулах үйл ажиллагааг тухайн цогцолборт газрын хамгаалалтын дэглэм, орчны бүс нутгийн нутаг дэвсгэрийн онцлогтой уялдуулан зохицуулахад оршино.

2. Цогцолборт газар, түүний орчны бүсэд явуулах үйл ажиллагааг Газрын тухай болон Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль, энэ нийтлэг горимд нийцүүлэн зохицуулж зохион байгуулах ажлыг цогцолборт газрын хамгаалалтын асуудал хариуцсан төрийн захиргааны холбогдох байгууллага эрхлэн хэрэгжүүлнэ.

3. Цогцолборт газарт явуулах үйл ажиллагаа нь уг цогцолборт газрын хамгаалалтын дэглэмийг чандлан сахиж, түүний байгаль орчны гэнцвэрийг хадгалахад чиглэгдэнэ.

4. Энэхүү нийтлэг горимыг цогцолборт газрын хуулиар зөвшөөрөгдсөн бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэн дагаж мөрдөх үүрэгтэй.

5. Шаардлагатай гэж үзвэл тухайн цогцолборт газарт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн хүрээнд дагаж мөрдөх хамгаалалтын онцлог горимыг Засгийн газраас тогтооно.

Хоёр. Хамгаалалтын нийтлэг горим

6. Цогцолборт газрын хуулиар зөвшөөрөгдсөн бүсэд аж ахуйн нэгж, байгууллага, иргэн үйл ажиллагаа явуулахдаа дор дурдсан журмыг баримтална:

журмыг баримтална:

а/Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль болон энэ горимд заасны дагуу тухайн газрыг хамгаалах, нөхөн сэргээх талаар ногдуулсан үүргийг хэрэгжүүлэх;

б/аливаа судалгаа шинжилгээ ажил, үйлчилгээг байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийгдсэн төстийн үндсэн дээр хэрэгжүүлж байх;

в/аливаа ажил, үйлчилгээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр явуулахдаа дараахь журам, дэглэмийг мөрдлөг болгох:

-байгалийн аялал, жуулчлалыг зөвшөөрөгдсөн бүсэд гал түймрийн аюулгүй үед зохион байгуулах;

-уламжлалт мал аж ахуй эрхлэхэд шаардагдах хянал, хороо, саравч барих, худаг гаргах, хадлан тэжээл бэлтгэх газрыг хамгаалалтын захиргаанаар тогтоолгож, орчных нь газрын төрх байдлыг хадгалахтай холбогдсон арга хэмжээ авч байх;

-Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн 17 дугаар зүйлийн 3-5-д заасан барилга байгууламж барих, байгуулахдаа уг ажил дууссаны дараа түүний орчныг сэргээн тохижуулж хамгаалалтын захиргаанд хүлээлгэн өгч байх;

-хөрсний нөхөн сэргээлт, ойн арчилгаа цэвэрлэгээг мод ургамал ургаж цэцэглэх, ан амьтны үржиж төллөх, ороо хөөцөлдөөнийхөөс бусад хугацаанд хийхээс гадна ан амьтны байршил, байгальд сөрөг нөлөөгүй арга, технологи, техник, багаж хэрэгсэлийг ашиглах, тухайн газар нутагт ургадаг ургамал, модны үр, тарьц хэрэглэх;

-ан амьтныг тоолох болон тэдгээрийг хамгаалах, өсгөн үржүүлэх зориулалттай биотехникийн арга хэмжээг ан амьтны үржиж төллөхөөс бусад үед тэдний байршилыг алдагдуулах, байгаль орчинд сөрөг нөлөөлөхөөс сэргийлэх арга хэмжээг урьдчилан авсны үндсэн дээр хэрэгжүүлж байх;

-рөшөөн эмчилгээ сувилгааны чанартай бусад эрдсийг байгалийн тэнцвэрт байдалд нь харилцахгүйгээр ашиглах;

-уул овоо тахих, уламжлалт зан үйлийн ёслол үйлдэх, зураг авах, дууны болон дүрс бичлэг хийх, зохиол бүтээл туурвихдаа экологид сөрөг нөлөөлөхгүй арга технологи ашиглах;

-нутгийн оршин суугчид ахуйн хэрэгцээндээ зориулан байгалийн дагалт баялаг, эмийн болон хүнсний ургамлыг түүж ашиглахдаа орчны тэнцвэрт харьцаа нөөцөд сөрөг нөлөөлөхгүй энгийн арга хэрэглэх;

-ашиглаж байгаа нутаг дэвсгэрт, байгалийн нөөц баялагт зохих журмын дагуу зохион байгуулалт, хянан баталгаа, байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийлгэж байх;

-цахилгаан, дулааны шугам сүлжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр барьж байгуулах;

-газар ашигласны болон бусад ажил, үйлчилгээ явуулж орлого олсны төлбөр, хураамжийг зохих журмын дагуу цаг хугацаанд нь төлөх;

-орчинхоо байгалийг хамгаалах асуудлыг хариуцаж, зөрчил гарсан тохиолдолд хамгаалалтын захиргаа, байгаль хамгаалагчдад тухай бүр мэдэгдэж байх;

-аж ахуйн нэгж, байгууллага, иргэн зөвхөн тогтоож өгсөн газарт зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулж, өөрийн ашиглаж, нутаглаж байгаа газрыг эвдрэл, бохирдлоос хамгаалах, талхлагдсан хөрс, ургамлыг нөхөн сэргээх, баталсан зураг төслөөр орчноо тохижуулж, хамгаалалтын захиргаанаас биотехникийн болон бусад арга хэмжээ авахад туслалцаа үзүүлэх;

-ашиглаж байгаа газрынхаа бүртгэл, зураглалыг мэргэжлийн байгууллагаар хийлгүүлэн жил бүр тодотгож байх;

-үйл ажиллагааны чиглэл өөрчлөгдөх, татан буугдах, барилга байгууламжийг бусдад шилжүүлэх, хөлслүүлэх, түрээслүүлэх зэрэг тохиолдолд тухайн хамгаалалтын захиргаанд мэдэгдэж гэрээнд нэмэлт, өөрчлөлт хийлгэж байх;

-ой хээрийн түймэрт өртөж болзошгүй газарт байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага түймрээс сэргийлэх арга хэмжээг авч, түймэртэй тэмцэх багаж хэрэгслийг тогтоосон хэмжээний дагуу бэлтгэсэн байхаас гадна жил бүрийн 4 дүгээр сарын 1-нээс 6 дугаар сарын 1.8 дугаар сарын 20-ноос 10 дугаар сарын 15-ны хооронд байгаль хамгаалагчдад туслалцаа өндөржүүлсэн бэлтгэлтэй жижүүр, эргүүд томилон ажиллуулж байх.

7.Хязгаарлалтын бүсээс байгалийн дагалт баялгийг нутгийн иргэд үр жимс нь боловсорч гүйцсэн үед байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга технологиор түүж ахуйн хэрэгцээндээ ашиглаж болно.

8.Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн газраа зориулалтын дагуу ашиглаж зөвхөн гэрээнд заагдсан үйл, ажиллагаанд явуулна.

9.Цогцолборт газрын нутаг дэвсгэрт аливаа ажил, үйлчилгээ явуулах аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь зохих журмын дагуу зөвшөөрөл авсан байна.

10.Улсын хилийн дагуу байрладаг цогцолборт газрын нутаг дэвсгэрийн улсын хилтэй нийлсэн хэсэгт хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн төхөөрөмжийг байрлуулж, мөр хянах зурвасыг зохих заавар, журмын дагуу байгуулж болно.

11. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн цогцолборт газарт судалгаа шинжилгээний ажил явуулахдаа дараахь журмыг баримтална:

а/судалгаа шинжилгээний ажлыг зөвшөөрөлд заасан газарт, тогтоосон хугацаанд батлагдсан хөтөлбөрийнхээ хүрээнд хийх;

б/онцгой бүсэд байгалийн төрх байдал, ус, хөрс, ургамал, амьтны аймгийн онцлог, тэдгээрийн хувьсал, өөрчлөлттэй холбогдсон судалгаа шинжилгээний ажил явуулахдаа байгаль орчинд аливаа өөрчлөлт, сөрөг нөлөөгүй арга хэлбэрийг хэрэглэх;

в/аялал жуулчлал, хязгаарлалтын бүсэд энэ зүйлийн "б"-д зааснаас гадна тухайн газрын байгалийн төрх байдлыг өөрчлөхгүй байх арга хэлбэрийг хэрэглэх;

г/судалгаа шинжилгээний ажлын хугацааг сунгах, үргэлжлүүлэн хийх шаардлага гарвал холбогдох үндэслэл тооцоо, үр дүнг нарийвчлан тогтоож, хамгаалалтын захиргааны санал, тодорхойлолтыг үндэслэн байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад асуудлыг тавьж шийдвэрлүүлэх.

12. Цогцолборт газрын нутаг дэвсгэрийг дайран гарсан улс, орон нутгийн чанартай авто замаар зорчих иргэн, түүнчлэн цогцолборт газрын нутаг дэвсгэрт хяналт шалгалт хийх үүрэг бүхий албан тушаалтан тухайн цогцолборт газраар зөвшөөрөл авахгүйгээр нэвтэрч болно.

13. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь цогцолборт газарт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

а/аялал, жуулчлалыг зохион байгуулахдаа тогтоосон зам чиглэл, амрах, отоглох цэгийг дур мэдэн өөрчлөх, тогтоосноос бусад газарт гал түлэх, үнс нурмаа унтраалгүй ил задгай орчих;

б/улсын хилээр нүүдэллэн орж гарч байгаа цагаан зээр, хавтгай, хулан, аргаль, янгир зэрэг нүүдлийн амьтдын хөдөлгөөн байршилд саад учруулж үргээх, дүрвээх;

в/улсын хилийн дагуу орших цогцолборт газарт хил залгаа гадаад улсаас мал отгоор оруулах, галаачын аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр өвс хадлан, давс хужир бэлтгүүлэх, ан амьтанд зохиомлоор мараа бэлтгэх, байшин барилга барих;

г/улс, орон нутгийн чанартай авто замаар зорчигчид тогтоосон зам, чиглэлийг өөрчлөх, хяналт шалгалт хийх албан тушаалтан өөрийн албан үүрэгт холбогдолгүй бусад үйл ажиллагаа явуулах;

д/Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль, энэ горимд зөвшөөрснөөс бусад үйл ажиллагааг явуулах.

Гурав. Хамгаалалтын нийтлэг горимыг  
хэрэгжүүлэх үйл ажиллагаа

14. Байгаль орчны асуудал хариуцсан төв, орон нутгийн байгууллага албан тушаалтан цогцолборт газар, түүний бүсэд Тусгай хамгаалалттай газар, нутгийн тухай болон Газрын тухай Монгол Улсын хуулийн холбогдох заалт, энэхүү нийтлэг горимыг дагаж мөрдүүлэх ажлыг хэрэгжүүлнэ.

15. Байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн 27 дугаар зүйлд заасныг хэрэгжүүлэх хүрээнд дор дурдсан үйл ажиллагааг зохицуулна:

а/цогцолборт газрын онцгой бүс, аялал, жуулчлалын бүс, хязгаарлалтын бүсийн заагийг газрын зурагт тэмдэглэн баталгаажуулах;

б/цогцолборт газрын хилийн заагтай залгаа орших орчны бүс нутгийн иргэдийн цогцолборт газрыг хамгаалахад гүйцэтгэх үүргийн чиглэлийг гаргаж өгөх;

в/цогцолборт газрын зохих бүсэд байрласан аж ахуйн нэгж, байгууллага, тэнд байнга оршин суудаг иргэдээс хамгаалалтын дэглэм, энэ горимыг мөрдөхтэй холбогдуулан гүйцэтгэх үүргийн чиглэлийг тогтоож, тэдгээртэй байгуулах гэрээний загварыг батлан гаргах;

г/цогцолборт газрын зохих бүсээс байгалийн дагалт баялаг ашигласны болон тэдгээрт хуульд заасан ажил, үйлчилгээ явуулсны төлбөр, хураамж ноогдуулах талаар санал боловсруулж зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлэх, тэдгээрийн орлогоос байгаль орчныг хамгаалах арга хэмжээнд зориулсан хэсгийг хуваарилах, захиран зарцуулах журмыг санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай зөвшилцөн тогтоох;

д/аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд ашиглуулах газрын байршил, дээд хэмжээг тухайн цогцолборт газрын онцлогтой уялдуулан тогтоох;

е/цогцолборт газрын газар болон байгалийн баялгийн ашиглалт, хамгаалалттай холбогдсон данс бүртгэл, тайлангийн маягт, тэдгээрийг хөтлөх, тайлагнах журмыг холбогдох төв байгууллагатай хамтран баталж мөрдүүлэх;

ж/цогцолборт газрыг судлан шинжлэх, ашиглах, сурталчлах зорилгоор хуулиар зөвшөөрөгдсөн бүсэд ажиглалт, туршилт явуулах, дүрс бичлэг хийх, кино зураг авах зөвшөөрлийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд зохих журмын дагуу олгох;

з/аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газартай хамтран буюу дангаараа цогцолборт газрын хамгаалалт, ашиглалтын асуудлаар хууль, тогтоомжид нийцсэн шийдвэр гаргах, түүнийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах, хэрэгжилтэнд нь хяналт тавих;

и/цогцолборт газрын зөвшөөрөгдсөн бүсэд байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулах, тэднээс байгаль хамгаалтын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох;

к/цогцолборт газрын бүртгэл, зураглалын ажлыг мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлж, нэгдсэн дүнг мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах;

л/цогцолборт газрын ашиглалт, хамгаалалтын талаар төрийн бодлогыг хэрэгжүүлэх, хамгаалалтын захиргааныг боловсон хүчинээр хангах, цогцолборт газрын хамгаалалтыг хариуцсан байгууллагыг санхүү, аж ахуйн талаар бэхжүүлэх, хөрөнгө оруулах, санхүүжүүлэх зэрэг зохион байгуулалтын арга хэмжээ авах;

16. Нийтлэг горимыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага дор дурдсан асуудлыг хамтран зөвшилцож зохицуулна:

а/хязгаарлалтын бүсэд бэлчээрийн уламжлалт мал аж ахуй эрхлэх, одоо байгаа өвөлжөө, хаваржаа, худгийг тухайн газар нутгийн экологид сөрөг нөлөөлөхгүйгээр ашиглах нөхцөл журмыг тохиролцож мөрдүүлэх;

б/цогцолборт газрын зөвшөөрөгдсөн бүсэд болно орчны бүсэд байрласан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн ашиглах газрын хэмжээг тогтоох, тухайн газар нутгийг хамгаалах, нөхөн сэргээх, цогцолборт газрын хэмжээг тогтоох, тухайн газар нутгийг хамгаалах, нөхөн сэргээх, цогцолборт газрын дэглэм, энэ горимыг дагаж мөрдөхөд тэдний гүйцэтгэх үүргийг тодорхойлж тэдэнтэй гэрээ хэлцэл байгуулах дүгнэх;

в/аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд ашиглуулахаар олгосон газарт газар болон байгалийн нөөц баялгийн зохион байгуулалт, хянан баталгааг тэдгээрийн зардлаар хийлгэх ажлыг зохион байгуулах;

г/цаг агаарын хүндрэл тохиолдсон үед цогцолборт газрын аялал жуулчлал, хязгаарлалтын бүсэд мал оруулах, отор нүүдэл хийх, хадлан бэлтгэх болон бусад мал оруулах, отор нүүдэл хийх, хадлан бэлтгэх болон бусад асуудлаар түр журам гаргаж мөрдүүлэх;

д/байгалийн баялгийн нөөц нь хомсодсон, төлөв байдал нь өөрчлөгдөн доройтолд орж талхлагдсан газар нутгийг сэргээн сайжруулах арга хэмжээ авах.

17.Цогцолборт газрын хамгаалалтын захиргаа энэхүү горимыг хэрэгжүүлэхтэй холбогдсон дор дурдсан үйл ажиллагааг зохицуулна:

а/Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу судалгаа шинжилгээ, тооллого явуулах, дээж, сорьц авах, хэмжилт хийх, ой арчлах, хөрс, ургамлыг нөхөн сэргээх, хортон шавьж, мэрэгчид, гүймрээс сэргийлэх, гэдгээртэй тэмцэх, рашаан, эмчилгээ сувилгааны зориулалттай бусад эрдэс, байгалийн баялгийг ашиглах, аялал жуулчлалыг зохион байгуулах зэрэг үйл ажиллагаа эрхлэхээр байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас зөвшөөрөл авсан, эсвэл уг үйл ажиллагааг эрхлэх үүрэг бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй үйл ажиллагааных нь хүрээ, хамрах нутаг дэвсгэр, ашиглах технологи, арга хэлбэр, техник, тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг тохиролцож гэрээ байгуулах, гэрээний хэрэгжилтийн явцад хяналт тавьж биелэлтийг нь тогтоосон хугацаанд дүгнэж байх;

б/цогцолборт газрын зөвшөөрөгдсөн бүсэд байнга оршин суудаг бусад иргэн тухайн нутаг дэвсгэрт түр нэвтрэн орж, уг газар нутагтай танилцах, хуулиар зөвшөөрөгдсөн үйл ажиллагаа явуулах бол гэдэнд Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол улсын хуульд заасны дагуу ийнхүү үйл ажиллагаа эрхлэн явуулах зөвшөөрөл олгож, хэрэгжилтэд нь хяналт тавих;

в/зохио зөвшөөрлийн дагуу цогцолборт газрын нутаг дэвсгэрт ажил, үйлчилгээ явуулсны болон байгалийн дагалт баялаг, газар ашигласны төлбөр, хураалжийг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдээс хураан авч зохио орлогод оруулах, уг ажлыг зохион байгуулахад тусалж дэмжих;

г/тухайн цогцолборт газрыг хамгаалахад зориулан олгосон хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах;

д/цогцолборт газрын хилийн заагийг Улсын Их Хурлаас баталсны дагуу, түүний онцгой, аялал жуулчлалын, хязгаарлалтын болон орчны бүсийг байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосны дагуу тэмдэгжүүлэх, сэргээх ажлыг холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

е/аялал жуулчлалын болон хязгаарлалтын бүсэд гэрээгээр газар ашиглаж байгаа аж ахуйн нэгж, байгууллага, иргэний газар ашиглалтад хяналт тавих, тэдний газрын хэмжээг жил бүр тодотгож байх;

ж/аялал жуулчлалын зам, нэвтрэх гарцыг чиглэлийн дагуу тэмдэгжүүлэх, аялагчид, жуулчдын байнга буюу түр буудаллах, сурталчилгааны цэгийг байгуулах, тохижуулах;

з/байгалийн төрх байдалд нөлөөлөхгүйгээр судалгаа шинжилгээний ажил явуулах, ажиглалт, судалгаа хийх цэгийн байршлыг тогтоох, байгуулах, тохижуулах;

и/байгаль хамгаалагчдын байршлыг сонгон тогтоож, хариуцсан нутаг дэвсгэрт нь байршуулах, тэдний ажиллах нөхцөлийг хангах, хамгаалалтын дэглэмийг мөрдөх шаардлагатай нийцүүлэн мал аж ахуй эрхлэх, хадлан бэлтгэх газрыг нь тогтоож өгөх;

к/цогцолборт газрын зохих бүсэд байрлаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж байгальд удаа дараа сөрөг нөлөөлсөн тохиолдолд үйл ажиллагааг нь таслан зогсоох буюу түүнтэй холбогдсон санал дүгнэлт гаргаж зохих эрх бүхий байгууллагад тавьж шийдвэрлүүлэх;

д/аялал жуулчлал эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллагыг аялагч, жуулчлагчдаа зориулсан байр бий болгох, тохижуулахад татан оролцуулах;

м/тухайн газар нутагт байгаа байгаль, түүхийн дурсгалт газруудын бүртгэл гаргах, түүх соёлын дурсгалыг сэргээхэд туслалцаа үзүүлэх;

н/цогцолборт газрын хувийн хэргийг эрхлэн хөтөлж, жил бүр тодотгон баяжуулж байгаль орчны асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад тайлагнаж байх;

о/цогцолборт газрын бүртгэл, зураглалын ажлыг мэргэжлийн байгууллагаар захиалан хийлгүүлд нэгдсэн дүнг мэдээллийн санд оруулах ажлыг зохион байгуулах;

п/ан амьтдын сүргийн нягтшил, өвчин эмгэгийг мэргэжлийн байгууллагаар судлуулан тогтоолгож, өвчин эмгэгийн тархалтад хяналт тавьж, эрүүджүүлэх арга хэмжээг холбогдох байгууллагаар авахуулж байх.

18.Орон нутгийн зөсөг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага дор дурдсан үйл ажиллагаа явуулна:

а/иргэдэд цогцолборт газрын тухай болон тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль тогтоомж, заавар, журмыг сурталчлах;

б/хамгаалалтын захиргаанаас хийж байгаа ажилтай танилцах, тэдний сонголт, илтгэлийг авч хэлэлцэх, заавар, зөвлөлгөө өгөх;

в/цогцолборт газрын орчны бүсэд байгалийн баялаг ашиглах /мод бэлтгэх, ан амьтан агнах, барих, ашиглах, геологийн хайгуул хийх, газар тариалан эрхлэх зэрэг/ажил, үйлчилгээ эрхлэх аж ахуйн



нэгж, байгууллага, иргэнд зөвшөөрөл олгохдоо хамгаалалтын захиргаанд мэдэгдэж байх.

19.Хамгаалалтын захиргаа нь өөрийн хариуцан хамгаалж байгаа нутаг дэвсгэрийнхээ байгальд учруулсан хохирлын хэмжээг тухайн баялгийн экологи, эдийн засгийн үнэлгээ, уг баялгийг нөхөн сэргээх зардлын нийт дүнгээр тооцож гэм буруутай аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээр нөхөн төлүүлдэг.

20.Цогцолборт газрын нутаг дэвсгэрт Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол улсын хууль, бусад хууль тогтоомж, энэ горимыг зөрчсөн гэм буруутай этгээдэд эрх бүхий улсын байцаагч хууль тогтоомжийн дагуу торгууль, төлбөр ногдуулна.

Засгийн газрын 1995 оны 169 дүгээр  
тогтоолын 3 дугаар хавсралт

## ДАРХАН ЦААЗАТ БОЛОН БАЙГАЛИЙН ЦОГЦОЛБОРТ ЗАРИМ ГАЗРЫН ТУСГАЙ ГОРИМ

Нэг. Увс нуурын ай сав, Богдхан уул, Хан  
Хэнтий, Отгонтэнгэр болон Говийн их  
дархан цаазат газарт мөрдөх

1.Увс нуурын ай савын дархан цаазат газрын Хархираа-Түргэн уул, Отгонтэнгэрийн дархан цаазат газрын Отгонтэнгэр уулын оргилд авирах зам чиглэлийг тухайн дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа, мэргэжлийн холбогдох байгууллага хамтран тогтоох бөгөөд уулын авиралтын үед дараахь горимыг дагаж мөрдөнө:

а/авиралтыг зөвхөн тогтоосон зам, чиглэлээр явуулж, заасан цэгт отоглож, амарч байх;

б/авиралтын чиглэлийн дагуухь газар болон отоглож, амарсан цэгийг бохирдуулахгүй байх;

в/авиралтын үед байгальд сөрөг нөлөөлөх хийгээд түймэр гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авсан байх.

2.Увс нуурын усанд хүн орох цэгүүдийг хамгаалалтын захиргаанаас тухайн сумын Засаг даргатай хамтран тогтоож, уг цэгийг гэмдэгжүүлэх, эрэг орчныг тохижуулах, унаган төрх байдлаар нь байлгах арга хэмжээг байнга авч байна.

3.Увс нуурын эргийн болон түүнд цутгадаг голуудын дагуухь бургасыг хамгаалах, зохистой ашиглуулах асуудлыг хамгаалалтын захиргаанаас холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зохицуулна.

4. Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа хамгаалалтын горимыг мөрдүүлэх асуудлыг дараахь байгууллагуудтай зохицуулна:

а/дархан цаазат газраар дамжин өнгөрч байгаа төмөр замын зурваст явагдах үйл ажиллагааг Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газартай;

б/дархан цаазат газрын хилийн заагт багтаж байгаа Туул голын урд эрэг, түүний орчинд иргэд амрах, зугаалах тодорхой бүс тогтоож, тохижуулах арга хэмжээг холбогдох дүүргийн Засаг даргатай;

в/нийслэл болон Богдхан уулын ойролцоо орших бусад суурин газарт нүүдэллэн орж ирсэн бута, согоо, бусад ан амьтдын хөдөлгөөнийг зохицуулах асуудлыг холбогдох дүүргийн Засаг дарга, нийслэлийн байгаль орчны хяналтын газартай;

г/Их, Бага тэнгэрийн ам дахь төр, засгийн үйлчилгээний цогцолбор бүхий нутаг дэвсгэрт Богдхан уулын байгаль хамгаалагч, захиргааны хяналт шалгалтын асуудал эрхэлсэн албан тушаалтан ажил үүргээ гүйцэтгэх асуудлыг Төрийн тусгай хамгаалалтын газартай.

5. Аялагч, жуулчдыг Хан, Хэнтийн дархан цаазат газрын хязгаарлалтын бүсэд орших Нэмэх, Чулуут голын дагуу авто хөсгөөр зөвхөн Тогоо хадны даваа хүртэл тогтоосон чиглэлээр аялуулна.

6. Отгонтэнгэрийн дархан цаазат газрын Даян-уулын ари, Алтантолгойн элс, Баянзүрх уулын зэрлэг сонгиныг аж ахуйн нэгж, байгууллага, иргэд үйлдвэрлэлийн болон аж ахуйн зориулалтаар түүж ашиглахыг хориглоно.

7. Говийн их дархан цаазат газарт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

а/дархан цаазат газрын нутаг дэвсгэр болон орчны бүс нутгаас заг, мод, сөөг, бутлаг ургамлыг төвлөрсөн хэрэгцээний түвшинд хэрэглэх;

б/хавтгай, мазаалай, тахь, бөхөн зэрэг ховордсон зэрлэг ан амьтан нутагшиж байгаа нь тогтоогдсон газарт хүн, мал оруулах.

Хоёр Хөвсгөл, Горхи-Тэрэлж, Говь  
гурвансайханы байгалийн цогцолборт  
газарт мөрдөх

8. Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын хамгаалалтын горимыг мөрдүүлэхтэй холбогдсон асуудлыг тус цогцолборт газрын хамгаалалтын захиргаа дараахь байдлаар зохицуулна:

д/нуурын мөсөн болон усан замаар тээвэртүүдэх ачааны төрөл, хэмжээ, ачаа тээвэрлэх хугацааг холбогдох байгууллагуудтай хамтран тогтоож зөвшөөрөл олгох, тээвэртэлтэд хяналт тавих;

б/ нуурын усаар хөвөгч хэрэгсэл /моторт завь, усан онгоц/-д үхтэг шалгалт хийж, нуур, голын усыг нефтийн бүтээгдэхүүн болон хог хаягдлаар бохирдуулахгүй байх нөхцөлийг хангасан тохиолдолд нуурын усаар явах зөвшөөрөл олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

в/Хатгал-Ханх, Хатгал-Жанхайн чиглэлийн автомашины замыг засч тохижуулахад байнга ашиглах чулуу, шороо, элс, хайрга авах карьерийн цэгийг тогтоож өгөх;

г/нуураар аялагчид болон зорчигчид нуурын усыг бензин, шатахуун, хог хаягдлаар бохирдуулахгүй байх, хөвөгч хэрэгсэл нь техникийн аюулгүй байдлыг хангасан байхын зэрэгцээ даац хэтрүүлэхгүй байх шаардлага тавих;

д/Хөвсгөлийн байгалийн цогцолборт газрын нутаг дэвсгэрт байрлаж буй Хатгал тосгон, Ханх сумын төвийн эдэлбэр газарт газар ашиглах асуудлыг тухайн сум, тосгоны Засаг дарга, захирагч нартай хамтран зохицуулж шийдвэрлэж байх.

9.Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газрын аялал жуулчлалын бүсийн Баруунбаян голын дагуу аялагч, жуулчдыг авто хөсгөөр зөвхөн Гүнжийн сүм хүртэл явуулна.

10.Говь гурвансайханы байгалийн цогцолборт газарт дараахь үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

а/цогцолборт газрын Зүүнсайхан уулын Оюут, Ёл, Улиастай, Мухаршивэр, Шат, Битүүгийн амны тэмдэгжүүлсэн цэгээс дотогш Хонгор, Зулганайн голын сав,Хэрмэн цав, Нэмэгт уулын хонгилын хэсгээр авто машинаар явах;

б/цогцолборт газрын нутаг дэвсгэр болон орчны бүс нутгаас заг, мод, сөөг, бутлаг ургамлыг төвлөрсөн хэрэгцээний түлшинд хэрэглэх.

Засгийн газрын 1995 оны 169 дүгээр  
тогтоолын 4 дүгээр хавсралт

## БАЙГАЛИЙН НӨӨЦ БОЛОН ДУРСГАЛТ ЗАРИМ ГАЗРЫН ХИЛИЙН ЗААГ

Нэг.Байгалийн нөөц газар

### 1.БАТХААН УУЛ

Өвөрхангай аймгийн Бүрд сумын нутаг Мухар модны даваа, түүнээс хойш орших Төв аймгийн Эрдэнэсант сумын нутаг Алагийн уулзвар, түүнээс зүүн урагш орших Өлийн хөтөл, Сант уул,Саалтын гозгор уул /1616,3/,Хар уул /1879,4/,Салхит хайрхан, Ламхаан уул /2090,4/, түүнээс баруун урагш орших Дунтолгой /Бунхан толгой 1598,4/, түүнээс баруун хойш орших Давалны гурван бууш /1795,2/, Цагаантолгой, Хүдэртолгой, /Модот овгор/,Хадат овгор, түүнээс хойш орших Мухар модны даваа.

### 2.НАГАЛХААН УУЛ

Хавиргын даваа, түүнээс баруун хойш орших Ганц модны овогцжөөний баруун хойд өндөр, Улаан-эргийн гарам, түүнээс зүүн хойш орших Хадат толгойн булаг, Хушуу булаг, Гурван хөхтийн Зүүн хөхт уул, түүнээс урагш орших Зүүн ханан, Ханангийн булаг, түүнээс баруун урагш орших Зүүн ханан, Ханангийн булаг, түүнээс баруун урагш орших Бавгийн булаг, түүнээс баруун хойш орших Хавиргын даваа.

### 3.БУЛГАН ГОЛ

Монгол улсын хилийн 60 дугаар багана, түүнээс баруун хойш хилийн 58, 59 дүгээр багана хүрч, түүнээс зүүн тийш орших Ярангайн хар үзүүрийн хөтөл, түүнээс зүүн урагш орших Зүүн хаац уул, Хөндлөн дэх тэжээлийн цэгийн байшин, түүнээс урагш орших Далангийн арлын адаг, Майхан толгой, түүнээс баруун тийш орших Баруун хаац уул /1683,2/, түүнээс баруун хойш орших Улсын хилийн 60 дугаар багана.

### 4.ТХАЧИНВАНДАЛ УУЛ

Улсын хил дээрх Баруун холбоо улаан толгой /1294,0/, түүнээс хойш орших Сэнжит өндөр уул /Суман өндөр1331,9/, түүнээс зүүн

хойш орших Баруун араат уул /1287,7/, Улаан толгой /1106,0/, Булшит толгой /1053,0/, 1065,9 тоот, Бухын булаг, Барчин уул /1134,4/, түүнээс зүүн урагш орших 1048,5 тоот, Шар өндөр /980,1/, түүнээс баруун урагш эргэж улсын хилийн дагуу Баруун холбоо улаан толгой /1294,0/.

### Хоёр Дурсгалт газар

#### 1.БУЛГАН УУЛ

Цагаандаваа, түүнээс зүүн хойш орших Тэмээн чулууны хяр, түүнээс урагш орших Баянбулагийн эх, Хөх чулуутын давааны замын уулзварт, Цохиотын хяр, түүнээс баруун тийш орших Булган

уулын зүүн урд талын Хөх хадан цохио, Ханан хад, Ганц модны булаг, түүнээс баруун хойш орших Цагаандаваа.

#### 2.ЭЭЖ ХАЙРХАН УУЛ

1329,9 тоот, түүнээс хойш орших 1230,0 тоот, түүнээс зүүн хойш орших 1145,8 тоот, түүнээс зүүн урагш орших Хаянгийн их худаг /1124,0/, 1185,0 тоот, түүнээс урагш орших Хаянгийн хар толгой /1290,0/, түүнээс баруун урагш орших 1270,0, 1398,0, тоотууд, түүнээс баруун хойш орших 1334,0, 1329,9 тоотууд

#### 3.УРАНТОГОО-ТУЛГА УУЛ

Шандан толгой /1922,0/, түүнээс зүүн хойш орших Талбөрийн зам ба Улаандавааны замын уулзвар, Улаандавааны зам ба Шандын булгийн замын уулзвар, түүнээс зүүн урагш орших Шандын овооны өвөр /1412,8/, түүнээс урагш орших Талбулагийн горхины гарам, түүнээс урагш горхио өгсөж Талбулаг, түүнээс баруун тийш автомашины замаар Эрээний жалга замын уулзвар, түүнээс баруун хойш Бухтын хөндийн 1449,4 тоот, түүнээс баруун хойш орших Шандан толгой /1922,0/.

#### 4.ХҮЙСИЙН НАЙМАН НУУР

Баянхайрхан /2685,0/, түүнээс зүүн хойш орших өндөрлөг /1 тоот шон/, түүнээс зүүн урагш орших Баяннуур, түүнээс зүүн урагш нуруудан 2613,0, 2601,0, 2926,0 тоот өндөрлөгүүд, 2926,0 тоотоос зүүн урагш 3,8 км-т орших 2 тоот шон, түүнээс зүүн тийш 1 км-т

орших 3 тоот шон, түүнээс зүүн ургаш 1,1 км-т орших 4 тоот шон, түүнээс баруун ургаш орших Ширээтийн даваа /2790,8/, түүнээс баруун урагш 1,6 км-т орших 5 тоот шон, түүнээс 1,1 км-т орших 6 тоот шон, түүнээс 1,5 км-т орших 7 тоот шон, түүнээс баруун тийш 2,1 км-т орших 8 тоот шон, түүнээс баруун хойш орших 2985,0 тоот өндөрлөг, түүнээс баруун хойш 1,3 км-т орших 9 тоот шон, түүнээс баруун хойш 4 км-т орших 10 тоот шон, түүнээс хойш орших 2849,0 тоот өндөрлөг, түүнээс зүүн хойш 2,7 км-т орших 11 тоот шон, түүнээс хойш нуруулдан 5,7 км-т орших 12 тоот шон, Баянхайрхан /2685,0/.

## МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ТОГТООЛ

1995 оны 12 дугаар  
сарын 27-ны өдөр

Дугаар 390

Улаанбаатар  
хот

**Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах  
буюу хөнгөн ялаар солих талаархи Эрүүгийн  
хуулийн зарим зүйл, хэсэг заалтыг  
тайлбарлах тухай**

Ялтныг хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих асуудлыг шийдвэрлэхдээ Эрүүгийн хуулийн заалтыг зөв хэрэглэх нь гэмт халдлагаас иргэн, нийгмийг хамгаалах гэмт хэрэг үйлдсэн этгээдийг цээрлүүлэх, засаж хүмүүжүүлэх, ялтныг болон бусад хүнийг гэмт хэрэг үйлдэхээс урьдчилан сэргийлэх зорилгыг биелүүлэх нэг гол нөхцөл мөн.

Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай Эрүүгийн хуулийн заалтыг нэгэн мөр ойлгож, зөв хэрэглэх явдлыг хангах зорилгоор Монгол улсын Дээд шүүхээс ТОГТООХ нь:

1. Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих журмыг хорих, засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгүүлсэн бөгөөд Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлд заасан насанд хүрсэн этгээд, түүнчлэн 18 насанд хүрэхийн өмнө үйлдсэн гэмт хэрэгт хорих буюу засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ял шийтгүүлсэн бөгөөд Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлд заасан этгээдэд хэрэглэнэ.

2. Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 2, 4, 5, 6 дахь хэсэгт зааснаар шүүх ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих журмыг зөвхөн өөрийн засарч хүмүүжсэнээ үлгэр жишээ зан төлөв, үнэн шударга хөдөлмөрөөрөө харуулсан бөгөөд шүүхээс оногдуулсан ялаас хуульд заасан хувийг нь гүйцэд эдэлсэн ялтанд хэрэглэнэ.

3. "Үлгэр жишээ зан төлөв" нь ял эдлэх тухайн дэглэмийн хорих ангид тогтоосон журмыг сахин биелүүдэхийн хамт гэм буруугаа ухамсарлаж, дахин гэмт хэрэг үйлдэхгүй байх итгэл үнэмшилтэй болсон ял эдэлж байх хугацаандаа сахилгын зөрчил гаргаагүй, хэрэв гаргаж арга хэмжээ авагдсан бол түүнийг арилгуулсан, хорих ангийн захиргаа, ялтны сайн дурын байгууллагаас зохиож байгаа ажилд идэвхтэй оролцдог, боловсрол, мэдлэгээ дээшлүүлэхэд биеэ дайчлан ажилладаг, бусад ялтны хүмүүжилд сайн нөлөө үзүүлдэг, үйлдсэн

гэмт хэргийнхээ улмаас учруулсан хохирлыг арилгахад бололцоогоо дайчилдаг зэргээр тодорхойлогдоно.

4. “Үнэнч шударга хөдөлмөрлөх” гэдэг нь ялтан оногдсон болон даалгасан ажлыг хугацаанд нь чанар сайтай, бүрэн хийж гүйцэтгэх, шинэ зүйл сэдэж санаачлах, шинээр мэргэжил эзэмших буюу мэргэжлийнхээ зэргийг ахиулах, ажлын багаж хэрэгсэл, техник тоног төхөөрөмжинд ариг гамтай хандах, хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг сахих болон ялтны хөдөлмөр сургалтын хүрээнд тавигдах бусад шаардлагыг бүрэн биелүүлсэн байх зэргээр илэрнэ.

5. Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай асуудлыг шүүх шийдвэрлэхдээ уг этгээд засарч хүмүүжсэнээ харуулж чадсан эсэх, эдэлбэл зохих ялаас хуульд заасан хувийг гүйцэд эдэлсэн эсэхийг хянаж үзэхээс гадна Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 354 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар түүний үйлдсэн хэргийн хүнд, хөнгөн, хувийн байдал, зан төлөв, засрал хүмүүжлийг нэгэн адил харгалзан үзэх үүрэгтэй.

6. Хорих ял шийтгүүлсэн ялтны эдэлсэн ялын тооцоог гаргахдаа түүний хорих газар биечлэн эдэлсэн ялын хугацаанаас гадна цагдан хоригдсон хоног, шагналын хоног, ял эдэлж байхдаа эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн болон чөлөөтэй байсан хугацааг ял эдэлсэн хугацаанд оруулан тооцно. Харин шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол биелүүлэхийг Эрүүгийн хуулийн 41 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 42 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Эрүүгийн байцаан шийтгэх хуулийн 352 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар хойшлуулсан, ийнхүү хойшлуулсан хугацаанд эмнэлэгт хэвтэж эмчлүүлсэн, түүнчлэн ял эдлэхээс зайлсхийсэн, хорих газраас оргосон хугацааг хорих ял эдэлсэн хугацаанд оруулж тооцохгүй.

7. Шүүхээс оногдуулсан ялын зарим хэсэг нь өршөөл үзүүлдэх тухай хуулиар хасагдсан тохиолдолд түүний эдэлбэл зохих ялын нийт хугацаанаас өршөөгдсөн хугацааг хасч үлдсэн ялаас хуульд заасан хувиар эдэлбэл зохих ялыг тооцон Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 4, 5, 6 дахь хэсэг, 50<sup>1</sup> дүгээр, 53 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 4 дэх хэсгийн а, б, в, 5 дахь хэсгийн а, б-д заасан журмыг хэрэглэх эсэхийг шүүх шийдвэртэнэ.

8. Шүүх ялтны засрал хүмүүжил, ял эдэлсэн байдлын тухай зохих байгууллагын тодорхойлолт, ялын тооцоо, дүгнэлт зэрэг ач холбогдол бүхий баримт бичгийн хүчин төгөлдөр байдал, үндэслэлийг шалгаж хүчин төгөлдөр бус буюу дутуу, шаардлагатай мэдээлэл агуулаагүй бөгөөд тэдгээрийг шүүх хурлаар тогтоох боломжгүй байвал материалыг зохих ёсоор гүйцэд бүрдүүлэхээр ял



эдлүүлэх байгууллагад нь захирамж гаргахгүйгээр буцааж байвал зохино.

9. Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэж судлах буюу эдтээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай асуудлыг шийдвэрлэхдээ насанд хүрсний дараа гэмт хэрэг үйлдсэн хүний хувьд эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн заалтыг, 18 насанд хүрэхийн өмнө гэмт хэрэг үйлдэж ял шийтгүүлсэн этгээдийн хувьд мөн хуулийн 53 дугаар зүйлийн заалтыг баримтлах бөгөөд харин 18 насанд хүрэхийн өмнө үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгүүлсэн ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн судлах, эдтээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих асуудлыг шийдвэрлэхэд мөн хуулийн 51 дүгээр зүйлд заасан хязгаарлалтууд үл хамаарна.

10. Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 8 дахь хэсэгт заасан эдтээгүй үлдсэн хорих ялыг засан хүмүүжүүлэх ажил хийлгэх хөнгөн ялаар солихдоо гэдгээрийн хугацааг уг төрлийн ялын хуулиар тогтоосон хэмжээ болон эдтээгүй үлдсэн хорих ялын хугацаанаас хэтрүүлд болохгүй гэдгийг сольж оногдуулсан засан хүмүүжүүлэх ажил хийлгэх ялын хугацаа нь тухайн ялтны эдтээгүй үлдсэн хорих ялын болон Эрүүгийн хуулийн 27 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар засан хүмүүжүүлэх ажил хийлгэж ялын дээд хугацаа 1 жил 6 сараас хэтэргч болохгүй гэж ойлгоно.

11. Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн "урьд гэмт хэрэг санаатай үйлдэж, хорих газар ял эдэлж байсан бөгөөд ял, шийтгэлгүйд тооцоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байхад гэмт хэрэг санаатай дахин үйлдэж хорих ял шийтгүүлсэн" гэдгийг гэмт хэрэг санаатай үйлдэж хорих ял шийтгүүлд хорих газар ял эдэлж дууссан боловч ял шийтгэлгүйд тооцоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байхад түүнчлэн хорих ял эдэлж байхдаа Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 6, 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "а, б, в"-д зааснаас бусад гэмт хэрэг санаатай үйлдэж хоёр дахь удаагаа хорих ял шийтгүүлсэн этгээд гэж ойлгоно.

Эрүүгийн хуулийн 51-р зүйлийн "д"-д заасан урьдах гэмт хэрэгт ял шийтгэлгүйд тооцоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байхад гэмт хэрэг санаатай үйлдэж хоёр удаа хорих ял шийтгүүлсэн этгээд гэдэгт урьд нь гэмт хэрэг санаатай буюу болгоомжгүй үйлдэж ял эдэлж байсан бөгөөд ял шийтгэлгүйд тооцоогүй буюу ял шийтгэлгүй болоогүй байх хугацаанд дахин гэмт хэрэг санаатай үйлдэж хоёр болон түүнээс дээш удаа хорих ял шийтгүүлсэн этгээд гус тус хамдарна.

12. Шүүх Эрүүгийн хуулийн хэд хэдэн зүйлээр ял оногдуулахдаа ялаас хугацааны өмнө тэнсэн судлах буюу эдтээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих журмыг хэрэглэж болохгүй зүйл, хэсгээр

оногдуулсан ялд нь уг журмыг хэрэглэж болох зүйл, хэсгээр оногдуулсан ялыг багтаасан бол ялгныг хугацаанаас өмнө тэнсэн суллах, эдлээгүй үлдсэн ялыг өөр хөнгөн ялаар солих журмыг хэрэглэхгүй.

13. Хэрэв Эрүүгийн хуулийн 51 дүгээр зүйлийн "б", "в"-д зааснаар ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу ялыг хөнгөн ялаар солих журмыг хэрэглэхгүй зүйл, хэсгээр оногдуулсан ялыг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольж болох зүйл хэсгээр оногдуулсан хүнд ялд нь багтаасан тохиолдолд уг этгээдийг хугацаанаас өмнө ялаас тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих эсэх тухай асуудлыг шийдвэртэхдээ багтаасан хүнд ялаар нь авч үзэх боловч уг этгээд хаалттай зүйл, хэсгээр оногдуулж багтсан ялын хугацаатай тэнцүү буюу илүү хэмжээний ял эдэлсэн байвал зохино.

14. Хад хэдэн гэмт хэрэгт оногдуулсан ялыг нэмж нэгтгэсэн тохиолдолд ялаас хугацааны өмнө тэнсэж суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай асуудлыг шийдвэртэхдээ энэ тогтоолын 12, 13 дугаар зүйлд зааснаар хаалттай зүйл, хэсгээр оногдуулсан ялыг заавал эдэлсэн байх зарчмыг баримталбал зохино.

15. Шүүх ялгныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллахдаа эдлээгүй үлдсэн ялын хэмжээг жил, сар, хоногоор шүүгч захирамжаа тодорхой зааж тэр хэмжээгээр тэнсэж, хянан харгалзах хугацааг тогтоон өгч заавал зохино.

16. Ялаас хугацааны өмнө тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзсан хугацааны дотор гэмт хэрэг шинээр үйлдвэл Эрүүгийн хуулийн 38 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг журамлан шинээр оногдуулсан ял дээр тэнсэгдсэн ялыг бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэнэ. Хэрэв эдлээгүй үлдсэн хорих ял нь өөр хөнгөн ялаар солигдсон этгээд уг ялыг эдэлж дуусаагүй байхдаа гэмт хэрэг шинээр үйлдэж ял шийтгүүлбэл Эрүүгийн хуулийн 38 дугаар зүйлийн нэгдэх хэсгийг журамлан шинээр оногдуулсан ял дээр урьдах сольж оногдуулсан ялаас эдлээгүй үлдсэн хугацааг хорих ялд шилжүүлэн бүгдийг буюу заримыг нэмж нэгтгэнэ.

17. Эдлээгүй үлдсэн хорих ялаас тэнсэн суллагдсан этгээд тэнсэгдсэн ялын хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдэж уг хэрэгтээ торгох ял шийтгүүлбэл Эрүүгийн хуулийн 38 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт зааснаар таслан шийдвэрлэх тогтоолыг тус тусад нь гүйцэтгэнэ.

18. Эрүүгийн хуулийн 53 дугаар зүйлд заасан журмаар хугацаанаас өмнө тэнсэн суллагдсан этгээд хянан харгалзсан хугацаанд гэмт хэрэг шинээр үйлдэж ял шийтгүүлсэн тохиолдолд энэ тогтоолын 16 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан шийдвэрлэнэ.

19. Ялтныг хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солихдоо нэмэгдэл ялаар чөлөөлөх эсэхийг шүүх өөрийн санаачилгаар буюу хорих ял эдлүүлж байгаа байгууллагын саналаар шийдвэртэй болно.

20. Шүүх нэмэгдэл ялыг эдлүүтэхээр үлдээсэн нь ЭБШ хуулийн 354-р зүйлийн гурав дахь хэсэгт заасан хугацаа өнгөрсөний дараа нэмэгдэл ялаас хугацааны өмнө чөлөөтүүлэх тухай асуудлыг дахин хэлэлцэхэд саад болохгүй.

21. Шүүх ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэж суллах эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай асуудлыг Эрүүгийн хуулийн 50 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт зааснаар хорих ял эдлүүлэх байгууллагын саналаар хэлэлцэн шийдвэртэй. Эдгээр байгууллага ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай саналынхаа хууль ёсны үндэслэлийг, тухайлбал ялтан үлгэр жишээ зан төлөв, үнэнч шударга хөдөлмөрөөрөө эсэргэц хүмүүжсэнээ харуулсныг болон шүүхээс оногдуулсан ялаас хуульд заасан хувийг эдэлснийг тодорхой баримт, тооцоогоор баталсан байвал зохино.

22. Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах, эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай саналд энэ зүйлд дурдсан баримт, тооцоо тусгагдаагүй, буруу тусгагдсан буюу санал гаргах аль нэг нь байгууллага, албан тушаалтан татгалзсан байвал шүүх материалыг хэлэлцэхгүйгээр ял эдлүүлж байгаа байгууллагад буцааж байвал зохино.

23. Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай асуудлыг хорих ял эдлүүлж байгаа байгууллагын нутаг дэвсгэрийн хувьд харьяалж байгаа сум буюу сум дундын, дүүргийн шүүх шийдвэртэй.

24. Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн суллах эдлээгүй үлдсэн буюу ялыг хөнгөн ялаар солих тухай асуудлыг хэлэлцэх шүүх хуралд прокурор, таслан шийдвэрлэх тогтоолыг биелүүлж байгаа байгууллагын төлөөлөгчийг оролцуулан нээлттэй хийнэ.

25. Шүүх ялтныг ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай асуудлыг шийдвэрлэх бүрдээ түүнийг эдлээгүй үлдсэн ялын хугацаанд хяналтдаа байлгах, хүмүүжүүлэх үүргийг хөдөлмөрийн тодорхой хамт олонд буюу иргэнд даалгах боломжийг судлан аль болохоор өргөн хэрэглэж байх нь зүйтэй.

26. Ялтныг ялаас хугацаанаас өмнө тэнсэн суллах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай шүүгчийн захирамжинд уг этгээдийн хувийн болон ам бүлийн байдал, ялангуяа гэмт хэрэг үйлдэх үедээ хэдэн настай байсан, урьд ял шийтгүүлж байсан эсэх,

үйлдсэн гэмт хэрэг, шүүхээс оногдуулсан ялын төрөл, хэмжээ, ялын тооцоо, нэмэгдэл ял зэргийг тодорхойлж түүнийг ялаас хугацааны өмнө тэнсэн судлах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольсон буюу ийнхүү судлах, солихоос татгалзсан үндэслэлийг тодорхой заасан байвал зохино. Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн судласан буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар сольсон тохиолдолд шүүгчийн захирамжийн хуулбарыг тухайн этгээдийн ял эдэлж байсан байгууллага таслан шийдвэрлэх тогтоол гаргасан шүүх болон тэнсэн судлагдсан буюу эдлээгүй үлдсэн ял нь хөнгөн ялаар солигдсон этгээдийн оршин суух орон нутгийн цагдаагийн байгууллагад хүргүүлж байвал зохино.

27. Ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн судлах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай саналыг шийдвэртэсний дараа холбогдох хавтаст хэргийг /материалыг/ тухайн шүүхэд хадгална. Харин ялтныг ялаас хугацааны өмнө тэнсэн судлах буюу эдлээгүй үлдсэн ялыг хөнгөн ялаар солих тухай шүүхэд шууд ирүүлсэн өргөсөл, хүсэлтийг тухайн ялыг эдлүүлж байгаа байгууллагад нь шилжүүлж байвал зохино.

28. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Улсын Дээд шүүхийн Бүгд хурлын 1992 оны 5-р сарын 19-ний өдрийн 37, 1993 оны 12-р сарын 27-ны өдрийн 56 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Ерөнхий шүүгч

Д. ЛЭМБЭРЭЛЦЭРЭН

Шүүгч

Б. ДАНГААСҮРЭН